



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



ГЭР БҮЛИЙН
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ТЭМЦЭХ

НИЙГМИЙН
АЖИЛТНУУДАД

ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



ГЭР БҮЛИЙН
ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ
НИЙГМИЙН АЖИЛТНУУДАД

ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР
2018

ГАРЧИГ

Оршил	7
Гэр бүлийн хүчирхийлэл	11
а. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр.....	12
б. Гэр бүлийн хүчирхийллийн онцлог, үе шатууд	14
в. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, үр дагаврууд.....	16
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо	19
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд нийгмийн ажилтны гүйцэтгэх үүрэг	23
Сургуулийн нийгмийн ажилтны гүйцэтгэх үүрэг	31
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд нийгмийн ажилтны баримтлах зарчим.....	35
Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах.....	37
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага	39
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх бусад зохицуулалт	43
Нийгмийн ажилтанд хамаарах журмууд	49-50
Хавсралтууд 1-21.....	51-274

ГАРЫН АВЛАГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Г.ГАНБАЯСГАХ

Т.ЦОГЗОЛМАА

ЗӨВЛӨХ:

Б.ОЮУН

Л.БИЛГҮҮН

Д.ЭНХЧИМЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй нийгмийн ажилтнуудад зориулж энэхүү гарын авлагыг Швейцарийн хөгжлийн агентлаг болон НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагаас боловсруулж бэлтгэв.

ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХ ТӨВ ТББ

Утас: 311512, 1800-1903

Электрон шуудан: gendereqcen@magicnet.mn

www.stoptrafficking.mn

Вэбсайт:

Facebook:

Mongolian Gender Equality Center/Хүйсийн тэгш эрх төв



ОРШИЛ

Монгол улсад гэр бүлийн хүчирхийлэл газар авч өнгөрсөн 6 жилийн байдлаар 95 хүн буюу сард 2 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас амиа алдсан.



Үүнээс харахад хохирогч гомдол гаргасан ч хуулийн хамгаалалтын гадна үлдэж байсан.

Иймд гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор³ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 оны 12 сарын 22-нд баталж, уг хууль 2017 оны 02 сарын 1-ээс хэрэгжиж байна. Энэ хууль дараах 10 гол өөрчлөлтийг авчирснаараа онцлог.

1 http://www.police.gov.mn/media/Statistic_medee/2016_12_sar_medee/Ger_buliin_huchirhiilel_2016.12.pdf

2 <http://prokuror.mn/index.php?newsid=721>

3 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1 заалт

01

Хохирогчдын дийлэнх нь хуулийн хамгаалалтын гадна үлддэг байдлыг өөрчилсөн.

02

Бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан, баг, хороо, сум, дүүргийн холбогдох албан тушаалтан, төрийн ажилтан, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй төрийн бус байгууллагын ажилтан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар цагдаагийн байгууллагад, цагдаагийн албан хаагчийн эзгүйд сум, багийн засаг даргад мэдээлэх үүрэгтэй болсон.

03

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээн авах, байгууллага, албан тушаалтныг тодорхой заасан.

04

Цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг тодорхой болсон.

05

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахаар болсон.

06

Хохирогчид үзүүлэх үйлчилгээг төрөлжүүлэн хуульчилсан.

07

Хохирогчийг хамгаалах үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломж бүрдсэн.

08

Зөрчил ба гэмт хэргийг заагласан.

09

Шаталсан, ялгамжтай хариуцлага хүлээлгэхээр болсон.

10

Хэрэг шалгах явцад хүчирхийлэл үйлдэгчийн тодорхой эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээг хуульчилсан.¹

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль¹ хэрэгжиж эхэлснээс хойш 2017 онд Гэр бүлийн хүчирхийллийн 1286 гэмт хэрэг үйлдэгдсэнээс нийслэлд 757 бүртгэгдэж өмнөх оноос буурсан бол зөрчил 2028 бүртгэгдэж өмнөх оноос 3 дахин, дуудлага мэдээлэл 2,2 дахин нэмэгдсэн байна².

Дуудлага, мэдээлэл, зөрчил өссөн нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг иргэд цагдаагийн байгууллагад шуурхай дамжуулдаг болж иргэний үүргээ биелүүлж байгаатай, цагдаагийн байгууллагын зүгээс дээрх дуудлага, мэдээллүүдийг нэн тэргүүнд шалгаж хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл бүрт хуулийн хариуцлага ногдуулж байгаатай холбоотой.

Уг хуулиас нийгмийн ажилтантай холбоотой заалтуудыг энэхүү гарын авлагаар дамжуулан та бүхэнд танилцуулж байна. Мөн энэ хуулийг хэрэгжүүлэхээр холбогдох яам, агентлагууд дангаараа болон хамтарч нийт 35 журам батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрээс нийгмийн үйлчилгээ, нийгмийн ажилтантай шууд хамааралтай 11 журам, бусад байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлэх 6 журам, бусад холбогдох журмуудыг бүрэн эхээр нь хавсаргав.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд чанартай үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхэд тань энэхүү гарын авлага та бүхэнд тус дөхөм болно гэдэгт найдаж байна.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, шинэчилсэн найруулга, 2016 оны 12 сарын 22-нд батлагдаж, 2017 оны 02 сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

² ЦЕГ-ын гэмт хэрэг, зөрчлийн тоо мэдээ, 2017 он, <http://www.police.gov.mn/news/content/id/3410/type/33>



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн **3-р зүйлд** зааснаар:

1. Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд.
2. Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.
3. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хамаатай бөгөөд

“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж дээр дурьдсан этгээд буюу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээд уг хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.¹

Гэмт хэрэг нь хүний идэвхтэй (**үйлдэл**) буюу идэвхгүй (**эс үйлдэл**) зан үйлээр дамжин илэрдэг.

Үйлдэл хийх гэдэг нь: хүний идэвхитэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ.

Эс үйлдэл нь: тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгохыг хэлнэ. ²

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.1 заалт

² <http://www.court.bu.gov.mn/index.php/2010-04-25-02-08-48>


А. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийг дараах **4 хэлбэрт** ангилсан. Үүнд:

1. Бие махбодын хүчирхийлэл
2. Сэтгэл санааны хүчирхийлэл
3. Эдийн засгийн хүчирхийлэл
4. Бэлгийн хүчирхийлэл.


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээд уг хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг **бие махбодын хүчирхийлэл** гэнэ.¹ Тухайлбал:

- Алгадах, өшиглөх, цохих, зодох, үсдэх гэх мэтээр биед гэмтэл, бэртэл учруулах. Ихэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид биеийн ил харагдахгүй хэсгүүдийг гэмтээдэг.
- Эд юмаар цохиж зодох, гэмтээх, бэртээх
- Түлэх, шарх, сорви үүсгэх
- Хутга, мэс, зэвсгийн чанартай зүйл, зэвсэг хэрэглэн сүрдүүлэх, гэмтээх
- Амь насыг нь хохироох гэх мэт.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээд уг хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг **сэтгэл санааны хүчирхийлэл** гэнэ.² Тухайлбал:

- Бусдын дэргэд үг хэлээр доромжлох, байнга хараалын үг хэллэг хэрэглэж, бүдүүлэг байдлаар харьцах
- Бусадтай сул талаар нь харьцуулах
- Хийж буй зүйлийг нь байнга хянах, хардах, алхам бүрийг нь мөрдөн мөшгих
- Түүнтэй холбоотой хэн нэгнийг болон зарим зүйлийг хохирооно, сүйтгэнэ гэж айлгах



¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.2 заалт

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.3 заалт

- Өөрийгөө ална гэж сүрдүүлэх
- Найз нөхөд болон сонирхдог зүйлгүй болгох
- Хэрэв түүнээс салбал бүх юмаа алдана гэж сүрдүүлэх
- Түүнд ирсэн захидлыг замаас нь задлах
- Утсаар ярихад таслах, ярих хүмүүсийн тоо, хугацааг хязгаарлах
- Өөрийн гэр бүлээс гадуур амрагийн явдлаа ярих
- Найз нөхөд, ах дүүсийнхээ хажууд дорд үзэх, түүний тухай худал ярих
- Худалч, хулгайч, сэтгэцийн өвчтэй, хамгийн муу хүн гэдэгт итгүүлэх
- Хүсэл мөрөөдөл, үзэл бодлыг нь үл ойшоох
- Гутаах, доромжлох, хараах, загнах, буруутгах
- Нэр хоч өгөх, гоочлох, тавлах
- Айлган сүрдүүлэх, зандрах
- Өөртөө болон амьдралд итгэх итгэлгүй болгох
- Заналхийлэх, улмаар амиа хорлоход хүргэх гэх мэт

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээд уг хуулийн үйлчлэлд хамаарах хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг **эдийн засгийн хүчирхийлэл** гэнэ.¹ Тухайлбал:


- Мөнгөн орлогод нь хяналт тавих
- Орлогын эх үүсвэргүй болгох, эх үүсвэрээс нь салгах
- Эдийн засгийн эрх мэдэлгүй болгох
- Гэрийн бүх мөнгийг хянаж, цагдах
- Өөрийн гэсэн мөнгөтэй байхыг үл зөвшөөрөх
- Ажил хийх болон боловсрол олоход нь саад хийх
- Зарцуулсан мөнгийг нэг бүрчлэн тооцох
- Мөнгөөр байнга гачигдуулах, мөнгө үрж, хэрэггүй зүйлд зарлаа гэж буруушаах
- Хувцас, ахуйн хэрэглээний зардлаар гачигдуулах



¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.4 заалт

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан уг хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг **бэлгийн хүчирхийлэл** гэнэ.¹ Тухайлбал:

- Хүслийг үл харгалзан хүч хэрэглэн хурьцал үйлдэх, хүчиндэх
- Хууран мэхлэх, айлган сүрдүүлэх замаар бэлгийн дур хүслээ хангах
- Бэлэг эрхтнийг нь гэмтээх, элдэв аргаар тарчлаах
- Бэлгийн харьцаанд ёс бусаар орох, орохыг шаардах, оруулах гэх мэт.
- Хэдийгээр албан ёсоор гэрлэснээр хосуудын дунд бэлгийн харьцааны эрх үүсч байгаа ч бэлгийн хүчирхийлэл үйлдэх эрх үүсэхгүй. Зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид эхнэрээ зодож, үг хэлээр доромжилж, сэтгэл санаагаар дарамталсныхаа дараа бэлгийн харьцаанд албадан оруулдаг. Энэ нь хүчингийн гэмт хэрэг бөгөөд эмэгтэйн хүсэл зоригийн эсрэг үйлдэл юм.



Б. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОНЦЛОГ, ҮЕ ШАТУУД

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус харьцаатай гэр бүлийн гишүүдийн дунд үйлдэгддэг. Энэ нь хэн нэг хүний ганц нэг удаагийн санамсаргүй үйлдэл бус харин тодорхой зорилготой, урьдаас төлөвлөж, ахин дахин давтан үйлдэж, даамжирдгаараа бусад гэмт хэрэг, зөрчлөөс ялгаатай.

ДАЛД: Гэр бүлийн хүрээнд үйлдэх нь хүчирхийлэгчид хэзээ хүчирхийлэл үйлдэхээ төлөвлөх, бусдад мэдэгдэхгүй байх, хуулийн байгууллагын ажилтнуудын хараанд өртөхгүй байх, өөрийгөө зөвтгөх зэрэг сөрөг талуудыг давуу тал болгон ашигладаг.

ДАВТАГДДАГ: Энэ үйлдэл нь далд явагддаг тул дахин үйлдэгдэх магадлал хамгийн их. Хүчирхийлэл нь тухайн хүний үзэл хандлагатай шууд холбоотой учир үзэл бодол нь өөрчлөгдөөгүй цагт давтагдсаар л байдаг. Давтамж нь янз бүр байж болно. Зарим тохиолдолд 1-2 жилийн зайтай байх явдал бий.

ДААМЖИРДАГ: Нийгэмд “эр эмийн хооронд илжиг бүү жороол”, “гэр бүлийн дотоод асуудал бусдад хамаагүй” гэх зэргээр гэр бүлийн хүчирхийллийг үл тоох, гэр бүлийн аливаа асуудалд эмэгтэй хүнийг буруутгах хандлага давамгайлдаг учраас эмэгтэйчүүд хүчирхийллийн тухай бусдад мэдээлэхгүй, нууж, улмаар хуулийн байгууллага хүчирхийлэл үйлдэгчид тохирсон ял, шийтгэл оноож чадаагүйгээс гэр бүлийн хүчирхийлэл улам даамжирдаг.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.5 заалт



Гэр бүлийн хүчирхийлэл нь дараах 4 үе шаттай. Үүнд:

1. Бал сар буюу эвлэрлийн үе

Энэ үед хүчирхийлэл үйлдэгч уучлалт гуйн, дахин хэзээ ч ийм үйлдэл хийхгүй хэмээн амлаж, бэлэг авч өгөх зэргээр гуйж гувшдаг. Тэд мөн “архи уугаад ухаанаа алдчихжээ, ажил дээр хүн уур хүргээд, хэрэв чи . . . -гүй байсан бол, энэ хүүхдүүд” гэх зэрэг тайлбараар өөрийгөө цагаатгадаг.

2. Хуримтлал, бухимдлын үе

Хүчирхийлэл үйлдэгч уучлалт гуйсан хэдий ч хэсэг хугацааны дараа дахин бага багаар хүчирхийлэл үйлдэж эхэлдэг. Энэ үед зөрчил хурцдаж, улам ойр ойрхон маргаж, мөнгө төгрөгөөр гачигдуулах, ялихгүй зүйлээр шалтаглах нь ихсэнэ. Эдгээр үйлдлийн давтамж улам ойртож, ихэссээр байдаг.

3. Хүчирхийлэл буюу тэсрэлтийн үе

Энэ үед уур хилэн, түрэмгийлэл, доромжлол даамжирч зодоон цохионоор тэсэрдэг. Хүчирхийлэлд өртөгсөд үүнийг зогсоох ямар ч хүч тэнхэлгүй байдаг учраас зарим нь амиа хорлохыг оролдож, галзуурмаар болдог. Бие махбодын хүчирхийлэл, зодоон цохион тодорхой хугацаанд явагддаг бол сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийлэлд цаг хугацааны хязгаар байдаггүй.

4. Хяналт тогтоож, эрхшээлдээ оруулах

Дээрх үйлдлүүд давтагдаж, даамжирсаар тухайн гэр бүл бүхэлдээ хүчирхийлэгчийн эрхшээл, хяналтад ордог. Хүчирхийлэгч бүх зүйлийг өөрийн хүссэнээр байлгахыг эрмэлзэж, тэр хүслээ хангадаг.

В. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ШАЛТГААН, ҮР ДАГАВРУУД

Олон хүн гэр бүлийн хүчирхийллийг архидалт, ядуурлаас үүдэлтэй гэж үздэг ч, бодит амьдрал дээр гэр бүлийн хүчирхийлэл нь тэгш бус байдал, өөрөөр хэлбэл эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус байдал, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг ролийн талаарх нийгэмд тогтсон ойлголт, хүчтэй нь хүчгүйгээ ялгаварлан гадуурхаж, дээрэлхдэг хандлага, хүмүүжлээс үүдэлтэй бөгөөд архидалт, ядуурал нь хүчирхийллийг өдөөгч хүчин зүйлс юм.

Тухайлбал, хүмүүс:

Боловсролгүй, арчаагүй, ядуу эмэгтэйчүүд л хүчирхийлэлд өртдөг гэж ярьдаг.

Гэвч энэ нь бодит байдалд тэр бүр нийцдэггүй. Учир нь хүчирхийлэл тухайн хүний нас, бие, царай зүс, боловсрол мэдлэгээс хамаардаггүй. Өндөр цалинтай, боловсролтой эмэгтэйчүүд энэ байдлаа нуух, арга зам олох боломж сайтай байдаг.

Зарим хүмүүс хүчирхийлэл үйлдэгчид сэтгэцийн өвчтэй гэж боддог.

Сэтгэцийн өвчнөөр халхавчилж хүчирхийлэл үйлдэх явдал их байгаа ч нийт хүчирхийлэл үйлдэгсдийн ердөө 2% нь л сэтгэцийн өвчтэй, 98% эрүүл байдгийг судалгаагаар тогтоосон байдаг¹.

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй өөрөө л буруутай. Овоо босгоогүй бол шаазгай юунд суух вэ? Эмэгтэйчүүд үг сөргөн маргалдаж, гэр орноо цэвэрлэхгүй, бохир заваан байлгаж, үрэлгэн загнаснаас л эрчүүдийг хүчирхийлэл үйлдэхэд хүргэсэн гэж зарим хүмүүс үздэг.

Энэ нь хүчирхийлэгчийг хэтэрхий өршөөж буй хэрэг. Санаа нийлэхгүй зүйл байж болно. Хүн бүр өөрийн үзэл бодол, аливааг даван туулах чадвар, амьдралыг үзэх үзэлтэй. “Хүчирхийлэл үйлдэгч туйлын зөв, бусад хүмүүс түүнийг дагаж мөрдөх ёстой” гэсэн ойлголт байхгүй.

¹ Монголд гэр бүлийн хүчирхийллийн талаар асуумж авч судалсан байдал Дэд доктор, дэд профессор Д. Одонтуяа (АУИС) Дэд профессор Брэдли Ихриг (JCS олон улсын байгууллага) <http://mongolmed.mn/article/5042>

Гэр бүлийн хүчирхийлэл нь дараах сөрөг үр дагавартай. Үүнд:

Бие хүнийг үгүйсгэдэг. Хүн бүр өөрийн гэсэн орон зайд амьдрах, хувийн нууцтай байх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөртөө итгэж, бахархах, шүүмжлэлийг эсэргүүцэх, татгалзах, алдаа гаргах, тусламж гуйх, өөрийгөө үнэлж хүндлэн өөрөөрөө байх боломж, орон зайг үгүйсгэдэг.

Эрүүл мэнд: Байнгын айдас түгшүүрээс шалтгаалан амьсгал давхцах, толгой эргэх, зүрх судасны өвчин, бамбай, цусны даралт, нойргүйдэх, хэт ядаргаанд орох, толгой тархи өвдөх, ходоод, бөөрний үйл ажиллагаа муудах, түлэгдэх, гэмтэж, бэртэж хөдөлмөрийн чадвараа түр эсвэл бүрмөсөн алдах, тахир дутуу болох, бэлгийн хүчирхийллийн улмаас ХДХВ, бэлгийн замаар дамжих халдвар авах, хүсээгүй жирэмслэлт зэрэг сөрөг үр дагавартай.

Ажил мэргэжил: Ихэвчлэн ажил хийлгэхгүй, удаан хугацаанд гэрт суулгадгаас мэдлэг, мэргэжлээрээ хоцрох, өөрийгөө чадваргүй, юу ч хийж чадахгүй гэсэн итгэл үнэмшилтэй болох, сурч боловсрох боломж олддоггүй, илүү цагаар ажиллах нөхцөл бүрддэггүйгээс санхүү, эдийн засгийн хувьд бусдаас хараат болдог.

Ганцаардуулах Төрөл бүрийн аргаар ах дүү, найз нөхөд, төрөл садан, хамт олон зэрэг гаднын хүрээллээс тусгаарладаг. Ганцаардлаас болж хүн өөрийн үнэ цэнэ, хүч чадлаа алдаж, хэн ч өөрийг нь ойлгохгүй, сонсохгүй, хүндлэхгүй байгаа мэт болж, өөрийгөө хэнд ч хэрэггүй гэдэгт итгэж эхэлдэг.

Хүүхдийн сурлага, хүмүүжил доголдох Хүчирхийллийн улмаас хүүхдийн сэтгэл, санаа хямарч, цочирдох, хүчирхийллийг асуудал шийдвэрлэх гол арга хэмээн ойлгож, хүчирхийлэгч болон өсөх, толгой гэдэсний өвчин, харшилд өртөх, тэвчишгүй ааш авир гаргах, архи дан согтуурах, мансуурах донд автах, ууртай түрэмгий болж, гэрээсээ дайжин, гудамжинд гарах, РС тоглоомонд донтох, бусдад дээрэлхүү зан авир гаргах, эсвэл хэт дотогшоо чиглэж, бусдаас харьцаагаа таслах, хичээл сургуульдаа идэвхгүй болох, сургууль завсардах зэрэг сөрөг үр дагаврууд учирдаг.

Мөн байнгын хүчирхийлэл дарамтад байдаг эмэгтэй ихэнх тохиолдолд уур, бухимдлаа хүүхэддээ гаргадаг учраас хүүхэд ээждээ гомдож, уурлан, харилцаа нь хөндийрөх эсвэл эмэгтэйчүүд хүүхдээ хүчирхийллээс хол байлгахын тулд халамжийн төвд өгдөг.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО

Энэ тогтолцоог Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар шийдвэр гаргах бүх түвшинд тодорхойлсон бөгөөд энэхүү гарын авлагад нийгмийн ажилтанд холбогдох хэсгийг танилцуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд орон нутгийн түвшинд хамтарсан баг ажиллана. Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.¹

Хамтарсан баг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ²:

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх,
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах
- Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх,
- Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.
- Хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан баг хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Ингэхдээ нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзана.³

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1 заалт

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2 заалт

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43.3 болон 43.4 заалтууд

Хамтарсан багаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг дараахь 7 төрөлд ангилна.⁴ Үүнд:

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	ХЭН, ЯМАР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
1. Аюулгүй байдлын хамгаалалт ⁵	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн байгууллага, холбогдох газар хэлтсүүдэд ажиллаж буй алба хаагч - Хамтарсан багийн гишүүд - Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, прокурор нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, болон зөрчлийн хэрэг бүртгэлийн явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ ⁶	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд үйлчилгээ үзүүлнэ. - Яаралтай тусламжаас бусад үйлчилгээг хохирогчийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, стандарт, зааврын дагуу үзүүлнэ.
3. Сэтгэл зүйн үйлчилгээ ⁷	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн ажилтан сэтгэл зүйн анхан шатны тайвшруулах зөвлөгөө өгнө. - Сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг цаашид мэргэжлийн сэтгэл зүйч үзүүлнэ. - Эрүүл мэндийн ажилтан сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлнэ.
4. Нийгмийн халамжийн үйлчилгээ ⁸	Хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам (батлагдаагүй)

⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.1 заалт

⁵ Хавсралт 13. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам

⁶ Хавсралт 17. Хохирогчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам

⁷ Хавсралт 3. Хохирогчид сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлэх журам

⁸ Батлагдаагүй байна.

5. Хүүхэд хамгааллын үйлчилгээ ⁹	<ul style="list-style-type: none"> - Хүүхэд хамгааллын анхан шатны болон хоёрдогч шатны урьдчилан сэргийлэх, хамгаалах, холбон зуучлах үйлчилгээг Хамтарсан баг үзүүлнэ. - Тусгай хамгаалалтаар хангах, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг асуудал эрхэлсэн төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн байгууллага, иргэн үзүүлж, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал сайжирсан эсэхэд үйлчилгээний үнэлгээ хийж, эргэх холбоотой ажиллана. - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 7 түүнээс дээш настай бол хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүүхдийн саналыг харгалзана.
6. Эрх зүйн туслалцаа ¹⁰ ;	<ul style="list-style-type: none"> - Эрх зүйн зөвлөгөөг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн ТББ, мөн хамтарсан баг биечлэн болон утсаар цахим хэлбэрээр үзүүлнэ. - Бүх шатны засаг дарга хохирогч хүүхдэд эрхзүйн зөвлөгөөг цахим хэлбэрээр үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд 107,108 дугаарын утсаар эрхзүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгнө. - Хохирогч хүүхэд 7-оос дээш настай бол өөрийн саналыг харгалзан үзнэ.
7. Холбон зуучлах үйлчилгээ ¹¹	<ul style="list-style-type: none"> - Хохирогчтой эхэлж холбоо тогтоосон байгууллага, ажилтан нь: <ul style="list-style-type: none"> ○ холбон зуучлах үйлчилгээг төлөвлөх, ○ холбогдох байгууллага, мэргэжилтэнд шилжүүлэх, ○ үйлчилгээний үр дүнд хяналт тавих, үнэлэх зэргээр ○ кейс хаагдах хүртэл зохицуулалтыг бүрэн хийнэ.

Ингэхдээ цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээ, нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийж, хохирогчид хэрэгцээтэй үйлчилгээг тодорхойлсны дараа тухайн хохирогчийн хүсэл, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлнэ. Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг¹ Хавсралт 12-оос үзнэ үү.

⁹ Хавсралт 14. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх журам

¹⁰ Хавсралт 6. Холбон зуучлах үйлчилгээний журам

¹¹ ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.10.04 А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Өмнөх хэсэгт дурдсан үйлчилгээнүүдийг хохирогчдод үзүүлж, хамтарсан багийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхдээ нийгмийн ажилтан дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Нийгмийн ажилтны үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд анхаарах зүйлс, хэрэгжүүлэх журмыг доорх хүснэгтийн 2-р баганаар толилуулж байна.

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ	АНХААРАХ ЗҮЙЛС, ХОЛБОГДОХ ЖУРАМ
<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байдлын талаар албан үүрэгтэй холбоотойгоор олж мэдсэн бол цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад мэдээлэх¹² - Мэдээллийг амаар, бичгээр, утсаар, цахим хэлбэрээр өгч болно.¹³ 	<p>“Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам” (Хавсралт 2)-оос дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд ГБХ-д өртсөн болон өртөж болзошгүй тухай мэдээлэл, сэжиг таамаг, санал гомдол хүсэлтийг хүүхдийн тусламжийн утасны ажилтан, сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягтын дагуу бүртгэж, харьяаллын дагуу хамтарсан багт шилжүүлнэ. - Хамтарсан багийн нарийн бичгийн дарга мэдээллийг хүлээн авч, Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүлээн авах бүртгэлийн маягтад бүртгэнэ. - Бүртгэл нь анхдагч мэдээлэл болох ба үйлчилгээтэй холбоотой шийдвэрүүд гаргах үндэслэл болно¹⁴. <p>“Хохирогчдод эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам” (Хавсралт 17)-оос дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлсэн тохиолдолд болон иргэний хамгаалуулах хүсэлтийг үндэслэн нэн даруй Эрүүл мэндийн байгууллагын оршин байгаа орон нутгийн цагдаагийн байгууллагад амаар, бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэх - Хохирогчийг цагдаагийн албан хаагч ирэх хүртэлх хугацаанд түр тусгаарлан хамгаалах арга хэмжээ авах¹⁵

¹² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23.1 заалт

¹³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23.3 заалт

¹⁴ Хавсралт 2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам

¹⁵ Хавсралт 17. Хохирогчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам

<p>Хохирогчийг мэдээллээр хангах, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх¹⁶</p>	<p>“Хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх журам” (Хавсралт 3)-аас дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр, хохирогчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн шуурхай, чанартай, хүртээмжтэй, үнэ төлбөргүй байна. - Бүх шатны Засаг дарга хохирогчид ганцаарчлан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. - Нийгмийн ажилтан хохирогчид анхан шатны тайвшруулах зөвлөгөө өгч, мэргэжлийн байгууллага, хүмүүстэй холбон зуучилна. - Зөвлөгөө өгөхдөө хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавина. - Хохирогчийг ялгаварлан гадуурхахгүй, нууцыг чандлан хадгална. - Хохирогчийг хангалттай мэдээллээр хангаж, үйлчилгээнд хамрагдах эсэх талаар бие дааж сонголтоо хийх боломжоор хангах, сонголтыг хүндэтгэнэ.
<p>Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх¹⁷</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдал; хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагавар; хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох зорилгоор үнэлгээг хийнэ. Нөхцөл байдлын үнэлгээ нь дүгнэлт хэлбэртэй байна.¹⁸</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх журам (Хавсралт 11)-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Нөхцөл байдлын үнэлгээг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, шаардлагатай тохиолдолд аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хариуцсан мэргэжилтэн, Хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран хийнэ. - Нөхцөл байдлын үнэлгээ нь хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ. - Холбогдох байгууллага, албан тушаалтанд хохирогч өөрөө, хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс ГБХ, хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн талаар мэдээлэл ирүүлсэн тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. - ГБХ-ийн тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ цагдаагийн албан хаагчийн аюулын зэргийн үнэлгээг харгалзана. - Нөхцөл байдлын үнэлгээг мэдээлэл авснаас хойш яаралтай үед нэн даруй, бусад нөхцөлд 72 цагийн дотор хийнэ.

¹⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.1 заалт

¹⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.2 заалт

¹⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32.1 болон 32.2 заалт

<p>Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах¹⁹</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх журам (Хавсралт 11)-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд хамтарсан багаас 2-оос доошгүй хүн оролцоно. - Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ журмын хавсралтаар батлагдсан үнэлгээний маягтын дагуу хийнэ. - Хоёр буюу түүнээс дээш тооны хохирогч байвал нөхцөл байдлын үнэлгээг тус тусад нь хийнэ. - Хамтарсан багийн нарийн бичгийн дарга нөхцөл байдлын үнэлгээний талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн санд оруулна.
<p>Хохирогчийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах²⁰</p> <p>Хохирогчид үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ²¹</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан дараах төрөлтэй байна.²²</p> <p>1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;</p>	<p>Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам (Хавсралт 6)-аас дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбож өгөх, тэдний аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжих үйлчилгээ юм. - Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхдээ аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина. - Хохирогчийн нууцлалыг чанд хадгална. - Өөртэй нь хамааралтай шийдвэр гаргах үйл явцад хохирогчийн оролцоог хангана. - Хохирогчийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байна. - Холбон зуучлах үйлчилгээ 4 үе шаттай байна. <p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам (хавсралт 2)-оос дэлгэрүүлэн үзнэ үү.</p>

¹⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.3 заалт

²⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.4 заалт

²¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарах журам нь батлагдаагүй байна.

²² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40.1 заалт

<p>2. Зөвлөгөө өгөх;</p> <p>3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;</p> <p>4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;</p> <p>5. Өдрийн үйлчилгээнд хамруулах;</p> <p>6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;</p> <p>7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;</p> <p>8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;</p> <p>9. Нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;</p> <p>10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.²³</p>	<p>- Нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан иргэний бүртгэл, сэтгэлзүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд холбон зуучилна.</p> <p>- Хэрэв хүүхэд Аюулын зэргийн түвшин дунд, эрсдэл өндөр байвал хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучилна.</p> <p>- Эмнэлгийн яаралтай тусламжаас бусад үйлчилгээг харьяа эрүүл мэндийн байгууллагад нь, хамгаалалтанд байгаа бол тухайн байгууллагын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилна.</p> <p>- Сэтгэл зүй, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий иргэн, магадлан итгэмжлэгдсэн байгууллагад холбон зуучилна.</p> <p>- Хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнд “ГБХ-ийн хохирогч хүүхдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх журам” (Хавсралт 14) –ын дагуу холбон зуучилна.</p> <p>“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам” (Хавсралт 5)-аас үзнэ үү.</p> <p>- Олон нийтийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсан. Өмнөх хүснэгтэд дурдагдсан 10 үйлчилгээнд хэрхэн хамруулах үйлчилгээний төрөл, чиглэл, хэлбэр, хамрагдах хүн, үйлчилгээнд тавигдах чанарын шалгуур үзүүлэлт, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавигдах шаардлага зэргийг тусгасан.</p> <p>- Нийгмийн ажилтан хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон үйлчлүүлэгчийн өргөдлийг цагдаагийн байгууллагын тодорхойлолт, нөхцөл байдлын үнэлгээний хамт Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт ирүүлнэ.</p>
<p>Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгааг сум, багийн засаг дарга, цагдаагийн алба хаагч, эрүүл мэндийн ажилтан болон баг, хорооны ажилтантай хамтран хийх, бүртгэл хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах²⁴</p>	<p>“Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам” (Хавсралт 18)- ийг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хамтарсан баг, албан тушаалтан хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр ГХУСА33-ийн салбар зөвлөлд хүргүүлнэ. - Тайланд дараах агуулгыг тусгана. - Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагаа, ТББ-тай хамтарсан г.м - Эрсдэлтэй бүлгийг илрүүлсэн талаар - Нөхцөл байдлын үнэлгээний хэрэгжилт - Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж үйлчилгээ, үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

²³ Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1 заалт

²⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.5 заалт

	<p>Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (Хавсралт 12)-ыг үзнэ үү</p> <ul style="list-style-type: none"> - Сум, дүүргийн ИТХ, орон нутагт ажиллах хамтарсан багийг өрхийн эмч (эрүүл мэндийн нийгмийн ажилтан), сум, баг, хорооны нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн, халамжийн, хүүхэд гэр бүл хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, шаардлагатай бол цэцэрлэгийн арга зүйч, хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байгуулах тухай тогтоол гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана. - Хамтарсан багийг сум, хороо, багийн засаг дарга ахалж ажиллана. - Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар суманд ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн, хороонд хөгжлийн нийгмийн ажилтан, багт багийн нийгмийн ажилтан ажиллана. - Хамтарсан баг нь журманд заасан урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээнүүдийг үзүүлэх үүрэгтэй. - Нарийн бичиг (нийгмийн ажилтан) Хамтарсан багийн үйлчилгээний мэдээллийн сангаас хувийн хэргийн дугаар авч, үйлчилгээний мэдээллийг оруулна. - Нарийн бичиг (нийгмийн ажилтан) үйлчлүүлэгчийн хүсэлтээр үйлчилгээг зогсоох, үйлчилгээний үр дүнг үнэлэх, хувийн хэргийг хаах үед холбогдох баримтыг хавсарган, хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.
--	--

<p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах²⁵</p>	<p>Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (хавсралт 12)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, түүнээс урьдчилан сэргийлэх арга, гэр бүлийн хүчирхийлэл гарсан/өртсөн тохиолдолд мэдээлэх, хандах газар, холбогдох утасны дугаар, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцлах зарчим зэргийг иргэдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй байдал зэргийг харгалзан үзэж, товч тодорхой, үнэн зөв мэдээлэл боловсруулж, ашиглана. - Урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. - Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт сурталчилгааг зохион байгуулах - Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох - Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нарт сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах
<p>Хохирогчид үзүүлэх хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөх, уялдуулан зохицуулах, үйлчилгээний тайлан, мэдээнд үндэслэн дараа жилийн үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах саналыг Засаг даргад гаргах²⁶</p>	<p>Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (хавсралт 12)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Нарийн бичиг (нийгмийн ажилтан) багийн гишүүдийн чиг үүргийг хуваарилах, оролцоо, үр дүнг хянах үүрэгтэй. - Хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөв, орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. - Засаг дарга жил бүр хамтарсан багийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйлчилгээний зардлыг тусгайлан төсөвлөж, ИТХ-д мэдүүлнэ. - Тухайн шатны ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг хэлэлцэн батална. - Хохирогчид хариу үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн асуудлыг эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

²⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.6 заалт 1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.7 заалт

²⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлээс

<p>Хохирогч өөрөө эсвэл хохирогч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, хамтарсан баг зөвшөөрсөн тохиолдолд хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах ажлыг нийгмийн ажилтан хариуцан зохион байгуулах бөгөөд аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна.²⁷</p>	<p>Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам (хавсралт 7)-ыг үзнэ үү .</p> <ul style="list-style-type: none"> - Уулзалтыг баг, хороо, сумын нийгмийн ажилтан зохион байгуулж, аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна. - Уулзалт зохион байгуулсан, оролцсон ажилтнууд уулзалтын талаарх мэдээллийн нууцлалыг хадгална. - Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах нэг удаагийн уулзалтын хугацааг 60 минутаас хэтрэхгүйгээр зохион байгуулна. - Уулзалтыг хохирогчид түр хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, газраас өөр холбогдох байгууллагад зохион байгуулна. - Хохирогчийг уулзалт зохион байгуулах байранд хүргэх, буцаах үеийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна.
--	--

²⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлээс

СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ	АНХААРАХ ЗҮЙЛС, ХОЛБОГДОХ ЖУРАМ
<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багтай хамтран ажиллах²⁸</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам (Хавсралт 2)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хамтарсан баг, байгууллага, иргэн “Хүүхэд хамгааллын дүрэм”-ийг баталж мөрдөнө. - Эрсдэлд байгаа, аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээгээр эрсдэлийн зэрэг “дунд”, “өндөр” гэж үнэлэгдэн хамтарсан багийн шийдвэрээр хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучилна. <ul style="list-style-type: none"> - Төрөл садны асрамж - Асралт гэр бүлийн үйлчилгээ - Түр хамгаалах байр - Нэг цэгийн үйлчилгээний төв - Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ - Үрчлэлт <p>Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (хавсралт 12)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хамтарсан багийн гишүүн сургуулийн нийгмийн ажилтан нь хүүхдийн боловсролын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана. - Хамтарсан багийн гишүүд мэргэжлийн ёс зүйг баримтлан, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. - Хамтарсан багийн гишүүд болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах чиглэлээр бусад талуудтай хамтран ажиллана. <p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам (батлагдаагүй)</p>

²⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.2.1 заалт

<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтанд зөвлөгөө өгөх²⁹</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам (Хавсралт 2)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй мэдээлэл, сэжиг таамаглал, гомдлыг 107,108 хүүхдийн тусламжийн утас болон нийгмийн ажилтан хүлээн авч, Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягтын дагуу бүртгэн, харьяаллын дагуу хамтарсан багт шилжүүлнэ. - Аюулын зэргийн үнэлгээг цагдаагийн ажилтан хийж, эрсдлийн түвшинг тогтооно. - Нийгмийн ажилтан хүчирхийлэл үйлдэгдсэн газарт очиж, хүүхэд гэр бүлд Нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. - Аюулгүйн зэргийн үнэлгээ, Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн Хамтарсан багт мэдээллийг хүргүүлж, шийдвэрлүүлнэ. - Сум хорооны болон сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, дахин ГБХ-д өртөхөөс сэргийлж, хүүхэд, хүчирхийлэл үйлдээгүй нь тогтоогдсон эцэг эхийн хамт хүүхдийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх зааварчилгааг өгнө. - Хамтарсан багийн үнэлгээнд тулгуурлан дэмжих, холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ. <p>“Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам” (Хавсралт 16)</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийг хамгаалах зорилгоор ямар арга хэмжээ авч байгааг хүүхдэд өөрт нь болон эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэж, хуулийн зохицуулалтыг тайлбарлана. - Тусгаарлах арга хэмжээ авах нь эцэг эх байх эрхийг зөрчсөн үндэслэл болохгүй³⁰ - Хүчирхийлэл үйлдэгч хамгаалалтанд авагдсан хүүхэдтэй уулзах, харилцах эрх хязгаарлагдана³¹. - Хүүхдийг хамгаалалтанд авснаар хүчирхийлэл үйлдэгч хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй³²
---	---

²⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.2.2 заалт

³⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30-р зүйл, 30.7.Хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах арга хэмжээ авсан нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

³¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30-р зүйл, 30.8.Энэ хуулийн 30.1-д заасан арга хэмжээ авагдсан нөхцөлд хүчирхийлэл үйлдэгчийн тухайн хүүхэдтэй уулзах, харилцах эрх хязгаарлагдана.

³² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30-р зүйл, 30.9.Энэ хуулийн 30.1-д заасан арга хэмжээ авагдсан үед хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй

<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах³³</p>	<p>Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам (хавсралт 12)-ыг үзнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, түүнээс урьдчилан сэргийлэх арга, гэр бүлийн хүчирхийлэл гарсан/өртсөн тохиолдолд мэдээлэх, хандах газар, холбогдох утасны дугаар, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцлах зарчим зэргийг иргэдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй байдал зэргийг харгалзан үзэж, товч тодорхой, үнэн зөв мэдээлэл боловсруулж, ашиглана. - Урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. - Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт сурталчилгааг зохион байгуулах - Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох - Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нарт сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах
<p>Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, стандарт, боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих³⁴</p>	<p>Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам (батлагдаагүй)</p>

³³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.2.3 заалт

³⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.2.4 заалт

<p>Бүх шатны боловсролын байгууллагын багш, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэгтэй.³⁵</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам (батлагдаагүй)</p>
---	--

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД НИЙГМИЙН АЖИЛТНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Нийгмийн ажилтан нь дээрхи хүснэгтүүдэд дурьдсан ажил үүргийг гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;
2. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах;
3. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг шуурхай хангах;
4. Нууцлалыг хамгаалах;
5. Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх;
6. Хүчирхийллийг үл тэвчих.³⁶

Нийгмийн ажилтан дээр дурьдсан зарчмыг баримтлан ажил үүргээ гүйцэтгэхдээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, холбогдох хууль, журмуудыг мөрдөж, хохирогчийг шаардлагатай мэдээллээр хангаж, хэрэгцээг нь тодорхойлж, нөөц бололцоондоо тулгуурлан уг хохирогчийн хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээ үзүүлнэ. Мөн:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл өгсөн этгээд гэрч, хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлсэн этгээд, энэ хуульд заасан үүргээ гүйцэтгэж байгаа албан тушаалтан, ажилтныг айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих, дарамт, шахалт үзүүлэх, буруутгах, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.³⁷
- Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.³⁸
- Хохирогчийг хуульд заасан эрхээ эдлэхэд түүний шашин шүтлэг, соёл, зан заншлын хэм хэмжээтэй холбогдуулан аливаа хязгаарлалт тогтоохыг хориглох³⁹ заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

³⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4.1-ээс

³⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.1 заалт

³⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.2 заалт

³⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.3 заалт

³⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29.2 заалт

Нийгмийн ажилтан үйл ажиллагааныхаа зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг товлож, шаардлагатай хөрөнгө нөөцийг тооцоолон, төлөвлөгөө гарган ажиллах бөгөөд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хохирогчид үзүүлсэн үйлчилгээгээ баримтжуулж, дараа, дараагийн ажлуудаа төлөвлөж, төсөв хөрөнгийг тооцоолж, үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад ашиглана.

Энэ сацуу бусад нийгмийн ажилтнуудтай туршлага солилцох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, бодлогуудыг цаг алдалгүй судалж, сургалтанд хамрагдах замаар ур чадвараа тогтмол сайжруулна.

ХҮҮХДИЙГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах тухай тусдаа бүлэг зохицуулалт орсон.

Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй⁴⁰ бөгөөд

- Хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах,
- ялгаварлан гадуурхах,
- сэтгэл санааны дарамт үзүүлэх,
- заналхийлэх,
- хүч хэрэглэх,
- зодож шийтгэх,
- тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх,
- үл хайхрах,
- хүүхдийн дэргэд архидан согтуурах,
- мансуурах,
- хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.⁴¹

Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төр, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг дарга болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй.⁴²

ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН УТАС: 108

Хүүхдийн хүчирхийллийн асуудлаар 108 утас орон даяар үнэ төлбөргүй мэдээлэл хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлж ажиллаж байна

Хүүхдийн тусламжийн 108 утас нь 24 цагийн турш 0-18 насны хүүхдүүд холбогдож өөрт хэрэгтэй мэдээлэл зөвлөгөө авах болон ямар нэгэн байдлаар гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, үл хайхрах дарамтанд өртсөн тохиолдолд тусламж үйлчилгээ авах боломжтой.

⁴⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28.1 заалт

⁴¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28.3 заалт

⁴² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29.1 заалт

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДУУДЛАГА, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС: 107

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар 107 утас орон даяар үнэ төлбөргүй мэдээлэл хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх бүх төрлийн мэдээллийг хүлээн авна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг хамгаалах НЦГ-ын дэргэдэх “Түр хамгаалах байр”-тай. Тус төв 24 цагаар үйл ажиллагаа явуулж, хохирогчдыг байрлуулан сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна.

Тусламжийн утсаар хүлээн авсан мэдээллийг цагдаагийн байгууллага эсхүл сум, багийн Засаг даргад хүргэх, хүүхдэд зөвлөгөө өгөх, шаардлагатай үйлчилгээ, туслалцаанд холбох ажиллагааг гэр бүл, хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.⁴³ Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам (Хавсралт 2)-ыг үзнэ үү.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.⁴⁴
- Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хоёр зуун нэгжтэй⁴⁵ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.⁴⁶
- Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.⁴⁷
- Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.⁴⁸
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчигчид торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.⁴⁹

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА:

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.⁵⁰

Харин гэмт хэргийн шинжтэй үйлдэлд 1-6 сар хүртэл баривчлах, эсвэл 2 жил хүртэл хугацаагаар хорино.

Гэмт хэрэг, зөрчлийн аль ч тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг “ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ”-нд заавал хамруулна. Хэрэг шалгагдах явцад хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчид дахин

⁴⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 46.1 заалт

⁴⁵ Эрүүгийн хууль, **5.3 дугаар зүйлийн** 3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

⁴⁶ Зөрчлийн тухай хуулийн 5.4.1 заалт

⁴⁷ Зөрчлийн тухай хуулийн 5.4.2 заалт

⁴⁸ Зөрчлийн тухай хуулийн 5.4.3 заалт

⁴⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 46.3 заалт

⁵⁰ Зөрчлийн тухай хуулийн 5.4.4 заалт

⁴³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29.4 заалт

эрсдэлтэй байдал үүсгэхгүйн тулд очих газар, уулзах хүн, эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг хязгаарлахаар хуульчилсан.

ХЗДХЯ-наас “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”⁵¹-ыг батлан гаргаж хэрэгжүүлж байна. Уг журамд:

- Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалтыг зохион байгуулна.
- Албадан сургалт нь шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэнэ.
- Эрх бүхий байгууллагын ажилтан (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургалтын ажилтан) албадан сургалтанд хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийг 24 цагийн дотор бүртгэлд хамруулж, түүнд сургалтад хамрагдах талаар танилцуулж, баталгаажуулна.
- Албадан сургалтыг шүүхээс оногдуулсан шийтгэл, ялын хугацаанд багтаан явуулна.
- Албадан сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй, долоо хоногт 16 цагаас доошгүй байна.
- Албадан сургалтанд хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд албан тушаалтны хууль ёсны шаардлага, шүүхээс хүлээсэн үүргийг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:

1.1. зодсон;

1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;

1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол 6

⁵¹ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04 А\73 тушаалаар баталсан.

сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой Эрүүгийн хуулийн бусад зохицуулалт:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан бол 12 жилээс 20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.⁵²
- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁵³
- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Гэр бүлийн хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁵⁴

⁵² Эрүүгийн хуулийн 10.1 зүйлээс

⁵³ Эрүүгийн хуулийн 10.4 зүйлээс. Тайлбар: Эрүүгийн хуульд заасан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.

⁵⁴ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлээс

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр боловсруулсан нийт 35 журмыг доорх жагсаалтаас үзнэ үү. Одоогийн байдлаар⁵⁵ 31 орчим журам батлагдан хэрэгжиж байна.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ ГАРАХ ЖУРАМ⁵⁶

№	Журмын нэр	Хуулийн заалт	Хариуцах байгууллага	Шийдвэрлэлт
1	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	17.1.3	Улсын ерөнхий прокурор ХЗДХЯ	2017оны 02 дугаар сарын 09-ны А/22, А/31 тоот тушаалаар баталсан.
2	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам	11.1.4	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.01.31-ний А/25 тоот тушаалын I дүгээр хавсралтаар баталсан.
3	Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам			
4	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам	33.1.6	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.06-ны А/29 тоот тушаалаар баталсан.

⁵⁵ 2017 оны 10 сарын байдлаар

⁵⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага, IDLO, ХЗДХЯ, УЕПГ, ШЕЗ, 2017 он

5	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам - Нийгмийн халамжийн үйлчилгээ - Хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам - Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам - Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журам	41.6	ХНХЯ	ХНХС-ын 2017.02.23-ний А/33 дугаар тушаалаар баталсан
		33.1.4		
6		41.6		
7		33.1.5	ГБХЗХГ	
		41.6		
8		33.1.7		
9		21.1.2	ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан.	
		21.1.4		
10		Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам	42.4	
11	Аюулын зэргийн үнэлгээ хийх журам	25.4.1	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/37 тоот тушаалаар баталсан.
12	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам	36.4	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/38 тоот тушаалаар баталсан.
13	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам	30.2	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.02.14-ний А/39 тоот тушаалаар баталсан.

14	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам	43.7	ХЗДХЯ ХНХЯ	ХЗДХС, ХНХС-ын 2017.03.13-ны өдрийн А/56, А/35 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
15	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам	44.3	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.03.22-ны өдрийн А/63, А/48, А/106 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
16	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр	44.5	ХЗДХЯ	ХЗДХС-ын 2017.04.04-ний А/73 тоот тушаалаар баталсан.
17	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам			
18	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх журам	38.2	ХНХЯ	ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/74 дугаар тушаалаар баталсан.
19	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам	36.4	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ний өдрийн А/80, А/60, А/132 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
20	Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	22.6	ХЗДХЯ ХНХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ний өдрийн А/84, А/54, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

21	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам	35.10	ХНХЯ	ХНХС-ын 2017.06.23-ний А/116 дугаар тушаалаар баталсан
22		13.1.2		
	<ul style="list-style-type: none"> - Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, - Сэтгэл зүйн зөвлөгөө, - Нийгмийн халамжийн үйлчилгээ, - Хүүхэд хамгааллын үйлчилгээ, - Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий мэргэжилтнийг давтан сургах хөтөлбөр, - Сургалт зохион байгуулах журам 			
23	Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам	37.3	ЭМЯ	ЭМС-ын 2017.10.12-ний А/394 дугаар тушаалын 1, 2, 3-р хавсралтаар баталсан
24		38.2		
25		41.6		
26		41.6		
	<ul style="list-style-type: none"> - Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн тусламжийн үйлчилгээ, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам 	33.1.2		
		33.1.3		

27	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	32.2	ХНХЯ ХЗДХЯ	ХНХС, ХЗДХС-ын 2017.07.04-ны өдрийн А/1201, А/178 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
28	Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам	20.3	ХНХЯ ХЗДХЯ ЭМЯ	ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.10.04 А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
29	Түр хамгаалах байрны үйлчилгээний хувьсах зардлыг тооцох журам ⁵⁷ “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам”	35.4 18.8	НХХЯ	НХХС-ын 2012 оны 07 сарын 18-ны өдрийн А\91 дугаар тушаалаар баталсан.
30	Түр хамгаалах байрны стандарт “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага” MNS 6040:2009	35.10	ХЗДХЯ Стандарчлал хэмжил зүйн газар	Нэмэлт өөрчлөлт хийх шаардлагагүй тул MNS 6040:2009 стандартаа мөрдөх

⁵⁷ НХХС-ын 2012 оны 07 сарын 18-ны өдрийн А\91 дугаар тушаалаар батлагдсан журмыг ашиглаж байна.

31	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд аюулгүй байдлын хамгаалалт хийх журам	41.6	ХЗДХЯ	Тус журмыг боловсруулан батлуулах шаардлагагүй бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 41.5-д заасан асуудлыг ХЗДХС-ын тушаалаар батлах "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам" мөн Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам"-аар зохицуулах боломжтой гэж Ажлын хэсэг дүгнэсэн.
32	Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандарт	36.4	ХЗДХЯ	СХЗГ-аас санал авахаар тоот явуулахад бэлэн болсон.
33	Хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам	40.2	ХНХЯ	Батлагдаагүй
34	Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам	14.1.2	БСШУСЯ	Батлагдаагүй
35	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам	14.1.5	БСШУСЯ	Батлагдаагүй

НИЙГМИЙН АЖИЛТАНД ХАМААРАЛТАЙ ЖУРМУУД:

Хавсралт 1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 гол өөрчлөлтийг тайлбарласан зурагт хуудсууд **51**

Хавсралт 2. ХНХС-ын 2017.02.23-ны А/33 дугаар тушаалаар баталсан **54**

- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам
 - o Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам
 - o Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам
 - o Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам
 - o Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журам
 - o Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журам

Хавсралт 3. ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/74 дугаар тушаалаар баталсан

- Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам **65**

Хавсралт 4. ХНХС-ын 2017.06.23-ны А/116 дугаар тушаалаар баталсан **74**

- Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий мэргэжилтнийг давтан сургах хөтөлбөр, сургалт зохион байгуулах

Хавсралт 5. НХХС-ын 2012 оны 07 сарын 18-ны өдрийн А/91 дугаар тушаалаар баталсан **85**

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам (Түр хамгаалах байрны үйлчилгээний хувьсах зардлыг тооцох журам,)

Хавсралт 6. ХЗДХС-ын 2017.04.04-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан. . **98**

- Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр

Хавсралт 7. ХНХС-ын 2017.04.20-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан. **108**

- Холбон зуучлах үйлчилгээний журам

Хавсралт 8. ХЗДХС, ХНХС-ын 2017.03.13-ны өдрийн А/56, А/35 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **121**

- Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам

Хавсралт 9. ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.03.22-ны өдрийн А/63, А/48, А/106 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **125**

- Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам

Хавсралт 10. ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ны өдрийн А/80, А/60, А/132 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **133**

- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам

Хавсралт 11. ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.04.06-ны өдрийн А/84, А/54, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **140**

- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам

БУСАД ХОЛБОГДОХ ЖУРМУУД

Хавсралт 12. ХНХС, ХЗДХС-ын 2017.07.04-ний өдрийн А/1201, А/178 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **147**

- Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам

Хавсралт 13. ХЗДХС, ХНХС, ЭМС-ын 2017.10.04 А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан. **180**

- Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам

Хавсралт 14. 2017 оны 02 дугаар сарын 09-ний А/22, А/31 тоот тушаалаар батлагдсан. **197**

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам

Хавсралт 15. ХЗДХС-ын 2017.02.06-ны А/29 тоот тушаалаар батлав. **203**

- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх журам

Хавсралт 16. ХЗДХС-ын 2017.02.14-ний А/37 тоот тушаалаар батлав. **207**

- Аюулын зэргийн үнэлгээ хийх журам

Хавсралт 17. ХЗДХС-ын 2017.02.14-ний А/39 тоот тушаалаар батлав. **225**

- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам

Хавсралт 18. ЭМС-ын 2017.10.12-ны А/394 дугаар тушаалаар батлав. **240**

- Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам
- Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам

Хавсралт 19. ХЗДХС-ын 2017.01.31-ний А/25 тоот тушаалын I дүгээр хавсралтаар баталсан. **251**

- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам;

Хавсралт 20. ХЗДХС-ын 2017.02.14-ний А/38 тоот тушаалаар батлав. **251**

- Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам

Хавсралт 21. ХЗДХС, ХНХС 2017.02.14-ний А/51, А/69 тоот хамтрсан тушаалаар батлав. **264**

- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 10 ГОЛ ӨӨРЧЛӨЛТ



ГЭР БУЛИЙН ХУЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ НЭГДЭВЭЛИЙГ ХУЛЭЭН КВАХ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТИЙГ ҮГДСӨРӨЙ ЗААСАН.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАМН ХУЛЭЭН ҮҮРЭГ ТӨДӨРӨЙ БОМН УН.



ХУЧИРХИЙЛЭХД ОРТООН ХУУХДИЙГ ТУСТАЙ ХАМГААЛАГААР ХАВИХАНА.



ХУЧИРХИЙЛЭХД ҮНЭГДЭВЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙГ ХУУЛЭЭНД ХАВИХАНА.



ХУЧИРХИЙЛЭХД ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙГ НЭГ ДӨӨРӨДСӨС ҮНЭГДЭВЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙГ ХАВИХАНА.



ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙГ ТААХЛАСАН



ШАТАДСАН, ЯЛГАМЖТАЙ ХАРИУЦЛАГА ХУЛЭЭНД ХАВИХАНА.



ХУЧИРХИЙЛЭХД ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙГ ТӨДӨРӨЙ ХАРИЛЦАХЫГ ХОРИГЛОХ





МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.5, 33.1.7 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/ нарт даалгасугай

САЙД



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/33 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь сум, хороо /баг/-ны хамтарсан баг, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, хүүхэд хамгааллын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд, иргэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, ертөж болзошгүй нөхцөл байдалд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх, шалгах, аюулгүйн зэргийн болон нөхцөл үнэлгээ хийх, тусгай хамгаалалтаар хангах, гэр бүлд нь эргэн нэгтгэх, дэмжих, холбон зуучлах, нийгэмшүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйлчилгээ байна.

1.3. Хүүхэд хамгааллын анхан болон хоёрдогч шатны урьдчилан сэргийлэх, хамгаалах, холбон зуучлах үйлчилгээг Хамтарсан баг үзүүлнэ. Тусгай хамгаалалтаар хангах, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг асуудал эрхэлсэн төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн байгууллага, иргэн үзүүлж, хүүхэд гэр бүлийн нөхцөл байдал сайжирсан эсэхэд үйлчилгээний үнэлгээ хийж, эргэх холбоотой ажиллана.

1.4. Энэ журмыг хэрэгжүүлэхэд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, тэдгээртэй нийцэж гарсан эрх зүйн акт, олон улсын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.5. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгч хамтарсан баг, магадлан итгэмжлэгдсэн байгууллага, иргэн нь үйл ажиллагаандаа мөрдөх "Хүүхэд хамгааллын дүрэм"-ийг баталж дагаж мөрдөнө.

1.6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 7, түүнээс дээш настай бол хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүүхдийн саналыг харгалзана.

Хоёр. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түүний хэлбэрүүд

2.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч болсон хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан баг, магадлан итгэмжлэгдсэн байгууллага, иргэн нь, хүүхдийг гэр бүл, нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах үйлчилгээ үзүүлнэ:

- 2.1.1. Мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шалгах;
- 2.1.2. Аюулгүйн зэргийн үнэлгээ хийх;
- 2.1.3. Нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- 2.1.4. Аюулгүй байдлыг хангах;
- 2.1.5. Хамтарсан багийн үйлчилгээ
- 2.1.6. Холбон зуучлах үйлчилгээ;
- 2.1.7. Үйлчилгээнд үнэлгээ хийх;
- 2.1.8. Гэр бүлд нь эргэн нэгтгэх эсэх талаар дүгнэлт гаргах;
- 2.1.9. Хувийн хэргийг хаах;

Гурав. Мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шалгах

3.1. Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй тухай мэдээлэл, сэжиг таамаглал, санал, гомдол, хүсэлтийг хүүхдийн тусламжийн утасны ажилтан, сум хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч, Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягтын дагуу бүртгэж, харьяаллын дагуу хамтарсан багт шилжүүлнэ.

3.2. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга мэдээллийг хүлээн авч, Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхэд хүлээн авах бүртгэлийн маягтад бүртгэнэ. Бүртгэл нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх анхдагч мэдээлэл бөгөөд тухайн хүүхэд болон гэр бүлд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой шийдвэрүүдийг гаргах үндэслэл болно.

3.3. Хүүхдийн талаарх мэдээллийг мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан хүчирхийлэлд өртсөн эсэх үнэн бодит байдлыг шалгах бөгөөд мэдээлэгчээс дараах асуудлыг тодруулж, тэмдэглэнэ.

- 3.4.1. нэр, хаяг, утасны дугаар;
- 3.4.2. тухайн хүүхэд, гэр бүлийг өмнө мэддэг эсэх;
- 3.4.3. тухайн гэр бүл, хүүхэдтэй ямар харилцаатай болох;
- 3.4.4. биеэр ирж уулзах боломжтой эсэх;
- 3.4.5. мэдээлэгч согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэх;
- 3.4.6. мэдээлэгчид тухайн гэр бүлийн зүгээс ирж болох дарамт, шахалт, айдас байгаа эсэх;

3.5. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээн авч, бүртгэснээс эхлэн хувийн хэргийг хаах хүртэлх үйлчилгээний үйл явцын мэдээллийг гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн нэгдсэн санд хамтарсан багийн нарийн бичгийн дарга оруулна.

Дөрөв. Аюулын зэргийн үнэлгээ хийх

4.1. Цагдаагийн албан хаагч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч байж болзошгүй эрсдэлийг "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн маягт, аргачлал"-ын дагуу хийх ба үнэлгээ хийх аргачлал дахь онцгой нөхцөл байдлууд нь эрсдэлийн түвшний өсөлтөд шууд хамаарна.

4.2 Хүүхдэд хийсэн аюулын зэргийн үнэлгээгээр "дунд", "өндөр" эрсдэлтэй нь тогтоогдсон тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр харьяа гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллах арга хэмжээ авах ба хүүхдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан түр хамгаалалтаар хангаж, хамтарсан багт мэдэгдэнэ.

Тав. Нөхцөл байдлын үнэлгээ хийх

5.1. Нийгмийн ажилтан хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр очиж, хүүхэд болон гэр бүлд Нөхцөл байдлын үнэлгээний журмын дагуу үнэлгээ хийнэ. Хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхэд, түүний гэр бүлд цаашид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох үндэслэл болно.

5.2. Хүүхэд, гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн нийгмийн ажилтан хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг хүүхдийн хувийн хэрэгт хавсаргана.

5.3. Нөхцөл байдлын үнэлгээний явцад үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж, дараах арга хэмжээ авна:

5.3.1. хүүхдийн аюулын зэргийн тусгай хамгаалалтаар хангах арга хэмжээ авна.

5.3.2. энэ журмын 4.6.1-т заасан арга хэмжээ авах шийдвэрийг хамтарсан багийн ахлагч гаргана.

5.3.3.Хамтарсан баг нь хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээ хийсний үндсэн дээр хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хүүхдэд хувийн хэрэг нээж,үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, шуурхай хамгаалах арга хэмжээ авах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд холбон зуучилна.

5.4. Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийхэд хамтарсан баг, нийгмийн ажилтанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

4.7. Энэ журмын 4.6-д дурдсан арга хэмжээ авах талаар гаргасан шийдвэрийг хамтарсан багийн хурлын шийдвэрт тусган, баталгаажуулж, баримт нотолгоог хувийн хэрэгт хавсаргана.

Зургаа. Аюулгүй байдлыг хангах

6.1. Хүүхдийн аюулын зэргийн үнэлгээ, эрсдлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтийг хамтарсан багийн гишүүд хэлэлцэн, тухайн хүүхэд, гэр бүлийн гишүүдэд шаардлагатай хамгааллын үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай хамтын шийдвэр гаргана.

6.2. Хамтын шийдвэр нь үнэлгээг хэлэлцсэн хамтарсан багийн хурлын тэмдэглэл байх бөгөөд хамтарсан багийн гишүүд гарын үсгээ зурж шийдвэрийг баталгаажуулна. Уг шийдвэрт хэлэлцсэн эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээний дүгнэлтийг хавсаргана.

6.3. Сум, хорооны болон сургуулийн нийгмийн ажилтан, шуурхай үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, дахин гэр бүлийн хүчирхийлэл дарамтад өртөхөөс сэргийлж, хүүхдийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хүүхэд, мөн хүчирхийлэл, дарамт үйлдээгүй болох нь тогтоогдсон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулан хамтран боловсруулж, хэрэгжүүлэх заавар өгнө

6.4. Үнэлгээний санал, дүгнэлтэд тэмдэглэл, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг бусад нотлох баримтыг хавсарган он, сар, өдөр, гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

6.5. Хүүхдийн болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээгээр дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах, арга хэмжээг 24 цагийн дотор авна. Үүнд:

6.5.1. хүчирхийлэгч нь хүүхдэд ноцтой хохирол учруулах хутга, буу галт зэвсэг хэрэглэсэн;

6.5.2. хүүхдийг өлсгөх, ямар нэг газар ганцааранг нь тусгаарласан, нуусан, хорьсон;

6.5.3. хүүхэд өөрийгөө болон бусдыг гэмтээх, бэртээхийг завдсан;

6.5.4. эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдээ асран хамгаалах чадваргүй, хүүхдэд ноцтой хохирол учруулж болзошгүй;

6.5.5. гэр бүлд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах боломжгүй, асран хамгаалагч нь хүүхдээ аваад буюу орхиод зугтаах, барьцаалах үйлдэл, эс үйлдэл үзүүлсэн;

6.5.6. хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд хүчирхийлэл үйлдэгчтэй нэг дор амьдарч байгаа бол;

6.5.7. хүүхэд бие махбодийн гэмтэл бэртэл авсан;

6.5.8. хүүхэд айдас, сэтгэл санааны дарамтанд орсон, дахин орж болзошгүй байгаа;

6.5.9. хүчирхийлэл үйлдэгч нь хүүхдийн эмзэг байдлыг ашиглан, өөрт ашигтайгаар шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй нөхцөл байдал үүссэн;

6.5.10. хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа байнга хэрэглэдэг бол;

6.5.11. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг бол;

6.5.12. хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн амь насанд заналхийлдэг бол;

Долоо. Хамтарсан багийн үйлчилгээ

7.1 Хамтарсан баг нь хүүхдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 37, 38.1.1, 40,41,42-р зүйлд заасан үйлчилгээг Хамтарсан багийн журмын дагуу үзүүлнэ.

Найм. Дэмжих, холбон зуучлах үйлчилгээ

8.1. Хамтарсан багийн нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатай талаар дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна.

8.2. Хамтарсан баг нь хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээнд үндэслэн дараах холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

8.2.1. Хэрвээ хүүхдэд энэхүү журмын 6.5.1- 6.5.12-т шалтгаан нөхцөл үүссэн болон аюулын зэргийн түвшин дунд, өндөр эрсдэлтэй бол мөн журмын 12.2.1- 12.2.6-д заасан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучилна.

8.2.2. эмнэлгийн яаралтай тусламжаас бусад үйлчилгээг хохирогч хүүхдийн байнга, эсхүл түр оршин сууж байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, хэрэв хохирогч хүүхэд эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд байгаа бол уг байгууллагын оршин байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилна.

8.2.3. сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий иргэн, магадлан итгэмжлэгдсэн байгууллагад холбон зуучилна.

8.2.4. хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан, уг үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй, хуулийн дагуу хэргийг шийдвэрлүүлэх шаардлагатай нөхцөлд хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнд "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн тусалцаа үзүүлэх журам"-ын дагуу холбон зуучилна.

8.2.5 хүүхэд түүний гэр бүлд үзүүлэх олон нийгийн оролцоонд тусилгээсн нийгмийн халамжийн үйлчилгээг төлөвлөж, хэлбэлдэх халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүгнэ.

8.3. Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлсэн байгууллага, ажилтан үйлчилгээний явц, үр дүнгийн талаар холбон зуучигсан хамтарсан баг, бусад байгууллагад эргэн мэдээлнэ.

8.4. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан багийн гишүүн байгууллага хүүхэд, гэр бүлийн аюулгүй байдал, нууцлалыг хангана.

8.5 Дэмжих, холбон зуучлах үйлчилгээний хэрэгжилтэд Хамтарсан багийн ахлагч, хүүхдийн ээхийн ажилтан, орон нутгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал харлуцсан байгууллага хяналт тавина.

8.6 Хуулиар үүрэг хүгээсэн төрийн байгууллага, албан хаагч, магадлан илгэмжлэгдсэн иргэн, хуулийн этгээд үйлчлүүлэгчид дэмжих, холбон зуучлах үйлчилгээ үзүүлээгүй, эсхүл шаардагдах үйлчилгээг үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол энэ тухай хүүхдийн эрхийн ажилтан тэмдэглэл үйлдэж, Төрийн албаны салбар зөөлөл, төрийн байгууллагын өс зүйн хороо, Нийгмийн ажилтны мэргэжлийн өс зүйн үндэсний болон салбар хороо, холбогдох бусад мэргэжлийн өс зүйн хороонд хүргүүлж шийдвэрлүүгнэ.

ЕС.Үйлчилгээний үр дүнгийн явцын үнэлгээ хийх

9.1 Үйлчилгээний үр дүнгийн явцын үнэлгээ нь хүүхдэд хувийн хэрэг нээснээс хойшх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг бүрт дэвшүүлсэн зорилго, зорилгод хүссэн эсэх, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлсэн эсэхэд саар бүр хамтарсан багийн дотроод хяналт, хүүхэд түүний гэр бүлд гарч буй өөрчлөлт, үйлчилгээний чанар, үр дүнгийн талаарх цагц үйл явц байна.

9.2 Гэр бүлд гэрч байгаа эерэг өөрчлөлт, дэвсгэлийг үнэлэхдээ хамтарсан багийн нарийн нийгмийн ажилтан нь дараах асуудлыг нягтлана.

9.1.1 хүүхдийн аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулах

9.1.2 Эрдэлт нөхцөл байдал буурсан арилсан эсэх

9.1.3 хүүхэд болон гэр бүлд хүчирхийллийн үзүүлэх сөрөг үр дагавруудыг амжилттай шийдвэрлэж чадаж байгаа эсэх.

9.1.4 хүүхэд, гэр бүлд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, үр дүнд хүрч чадаж байгаа эсэх.

9.1.5 гэр бүлийн хүрээнд хүссэн амжилт, үр дүн.

9.3. Гэр бүлийн эерэг өөрчлөлтийн үнэлгээг хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлтийг шинэчилж, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, эсхүл хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

АРАВ. Гэр бүлд нь эргэн нэгтгэх эсэх шийдвэр гаргах

10.1. Тусгай хамгаалалтанд байгаа хүүхдийг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд гэр бүлд нь эргэн нэгтгэж болно.

10.1.1. энэ журмын 6.2.1-т дурдсан үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдээ эцэг эх, асран хамгаалагч гэртээ ирүүлэх хүсэлтийг албан ёсоор бичгээр гарган, нийгмийн ажилтантай хамтран ажиллах хүсэлтэй байгаа;

10.1.2. Үйлчилгээний явцын үнэлгээгээр хүүхдийг гэр бүлээсээ тусдаа амьдрахад хүргэсэн шалтгаан арилсан гэж хамтарсан багийнхан дүгнэсэн бол;

10.1.3. эцэг эх нь зан үйлийн албадан сургалтанд хамрагдсан тухай нотлох баримтыг үндэслэн;

10.1.4. хүчирхийлэл үйлдэгч этгээд, тухайн гэр бүлд амьдрахаа больсон;

10.1.5. хүчирхийлэл үйлдэгч этгээд хуулийн дагуу тодорхой хугацаагаар зорчих эрхээ хязгаарлуулсан, баривчлагдсан, хоригдсон;

10.2. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн тохиолдолд Хамтарсан баг тухайн гэр бүлд улирал тутам нөхцөл байдлын үнэлгээ хийж, хоёр жил хүртэл хугацаанд хяналт тавьж, дэмжих үйлчилгээнд хамруулна.

10.3. Хүүхдийг дараах нөхцөлд гэр бүлд нь эргэн нэгтгэх боломжгүй гэж үзнэ:

10.3.1. шүүхээс эцэг эх байх эрхийг нь хязгаарласан, хассан бол;

10.3.2. эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг гэртээ буцаан авах боломжгүй нь нөхцөл байдлын үнэлгээгээр тогтоогдсон бол;

10.3.3. эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр оронгүй, тэнэмэл амьдралтай бол;

10.3.4. эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын хамааралтай, хүүхдээ хайхардаггүй, гуйлга гуйлдаг, тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхлүүлдэг бол;

10.3.5. гэр бүлийг эргэн нэгтгэх нь боломжгүй гэж үзэхэд хүргэсэн эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн хооронд хүчирхийллийн харилцаатай, зан үйлд эерэг өөрчлөлт гараагүй бол.

10.3.6. гэр бүлийнхэн нь болзошгүй хүчирхийллээс хүүхэд болон түүний дүүсийг хамгаалах чадваргүй бол;

10.3.7. Хамтарсан баг тухайн гэр бүлтэй тодорхой хугацаанд ажилласан боловч эерэг өөрчлөлт, хүчин чармайлт гарахгүй байгаа бол;

10.4. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, эсэх шийдвэрийг хамтарсан багийн хуралдаанаар хэлэлцэж, хамтын шийдвэр гаргах ба Хамтарсан багийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Арван нэг. Үйлчилгээг төгсгөж, хувийн хэргийг хаах

11.1. Хамтарсан багийн үйлчилгээний үр дүнд хүүхэд болон гэр бүлийн байдал хэвийн болсон гэж үзэж, цаашид хүчирхийлэлд өртөх эрсдэл арилсан, эсхүл хүүхэд 18 насанд хүрсэн тохиолдолд хувийн хэргийг хаана.

11.2. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга тухайн гэр бүлийн аюулын зэрэг, эрсдэлийн түвшин буурсан тухай мэдээллийг хамтарсан багийн хуралд танилцуулж, хувийн хэргийг хаах эсэх талаар хамтарсан шийдвэр гаргуулах ба шийдвэрийг хамтарсан багийн ахлагч гарын үсэг зурж, баталгаажуулна.

11.3. Хаагдсан хувийн хэрэг бусад материалын эх хувийг хамтарсан багийн нарийн бичиг дарга архивлаж хадгална.

11.4. Хаагдсан хувийн хэргийн мэдээллийг тухайн орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагын Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санд Хамтарсан багийн нарийн бичгийн дарга оруулж, бүртгүүлнэ.

Арван хоёр. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах

12.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч болсон хүүхэд нь аюулгүйн зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээгээр эрсдэлийн зэрэг дунд, өндөр гэж үнэлэгдэн, гэр бүлээсээ тусгаарлагдах шаардлагатай талаар Хамтарсан багийн шийдвэр гарсан тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд холбон зуучилна.

12.2. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

12.2.1. Төрөл садны асрамж;

12.2.2. Асралт гэр бүлийн үйлчилгээ;

12.2.3. Түр хамгаалах байр;

12.2.4. Нэг цэгийн үйлчилгээний төв;

12.2.5. Хүүхдийн халамж, асрамжийн үйлчилгээ;

12.2.6. Үрчлэлт

12.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхдийг аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний эрсдэлийн түвшингээс хамаарч дараах хувилбарт үйлчилгээнд хамруулна. Үүнд:

12.3.1. Аюулын зэргийн үнэлгээгээр "бага эрсдэлтэй" гэж үнэлэгдсэн бол, нийгмийн ажилтан дангаар болон Хамтарсан багийн гишүүдийн оролцоотойгоор хүүхэд болон эцэг эхэд сэтгэлзүйн, хуулийн, хүмүүжлийн зэрэг аргын талаар зөвлөгөө өгч хүүхдийг тэдний асрамжид үлдээж болно.

12.3.2. Хамтарсан багийн шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын захирамжаар хүүхдийг төрөл, садны асрамж эсхүл асралт гэр бүлд гэрээний үндсэн дээр хүлээлгэн өгч түр асруулж болно.

12.3.3. энэ журмын 10.1-т дурдсан үнэлгээгээр "дунд", "өндөр" эрсдэлтэй, болон энэ журмын 5.6-д дурдсан нөхцөл байдал үүссэн бол эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр хүүхдийг түр хамгаалах байранд холбон зуучилна. Энэ үйлчилгээ нь хүүхдийг хүлээн авснаас эхлэн нэг долоо хоногос гурван сар хүртэлх хугацаанд гэрээс нь тусгаарлан байрлуулж, хүүхэд, түүний гэр бүлд харьяалах хамтарсан багтай хамтран нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлнэ.

12.3.4. гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхдийг эмнэлэг, цагдаа, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан, эмнэлгийн тусламж болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан бусад үйлчилгээг нэг дор үзүүлэх нэг цэгийн үйлчилгээнд холбон зуучилна.

12.3.5. Түр хамгаалах байр, төрөл садан ба асралт гэр бүлийн асрамжид байх хугацаа дууссан, гэр бүлийн нөхцөл байдлын болон үйлчилгээний үнэлгээгээр ахиц гараагүй, гэр бүлд нь эргэн нэгтгэх боломжгүй талаар Хамтарсан багаас гаргасан шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга захирамж гаргаж, хүүхдийг халамж, асрамжийн үйлчилгээнд шилжүүлэх эсхүл үрчлүүлж болно.

12.4. Энэ журмын 10.3.5-т дурдсан үйлчилгээг хамгийн эцсийн арга хэмжээ болгож хэрэглэнэ.

12.5. Хамтарсан баг нь хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хүүхдийг холбон зуучилж, тухайн байгууллагатай хамтран хүүхэд, түүний гэр бүлийг дэмжих үйлчилгээг үргэлжлүүлнэ.

12.6. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, иргэн нь хүүхдийг байрлаж байх хугацаанд хүүхдийн болон гэр бүлд үйлчилгээний үнэлгээг тухай бүр хийж, шинээр цуглуулсан мэдээлэл, үүссэн бэрхшээл, ололт амжилт, үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээллээ хамтарсан багт хүргүүлж, хамтран ажиллана.

12.7. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, хувийн хэргийг хаах эсэх шийдвэрийг Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, иргэн, тухайн харьяалах хамтарсан баг хамтран гаргана.

Арван гурав. Журмын хэрэгжилтийн хяналт, тайлагналт

13.1. Энэхүү журмын хэрэгжилтэнд Гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

13.2. Хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлан мэдээг сар бүр харьяа аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

13.3. Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлан мэдээг сар, улирал, жилээр нэгтгэж, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

12.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлан мэдээг нэгтгэж, гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн санд оруулна.

-----oO-----



2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/АА

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний үнэлгээний маягт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/-т даалгасугай.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн А/А дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүн /цаашид "хохирогч" гэх/-д сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхэд энэ журмаар зохицуулна.

1.2. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Нийгмийн Халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.

1.3. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр хохирогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шуурхай, чанартай, хүртээмжтэй, үнэ төлбөргүй хүргэнэ.

1.4. Бүх шатны Засаг дарга нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6-д заасны дагуу хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

1.5. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг мэргэжлийн сэтгэл зүйч үзүүлнэ. Нийгмийн ажилтан хохирогчид сэтгэл зүйн анхан шатны тайвшруулах зөвлөгөө өгч, хамтарсан багтай нягт хамтран ажиллаж, цаашид мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд холбон зуучлана.

Хоёр. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтлана:

2.1.1. хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, эрхэм чанар, эрх, эрх чөлөөг хүндэтгэн нас, хүйс, яс, үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх;

2.1.2. сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

2.1.3. хохирогчийн хувийн нууцыг чандлан хадгалах. хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбостой мэдээллийг задруулахгүй байх;

2.1.4. сэтгэл зүйч нь мэргэжлийн ёс зүй болон байгууллагын дотоод журмыг баримтлах.

2.2. Сэтгэл зүйч нь үйлчилгээний явцад хохирогчийн эрхийг ямагт хүндэлж мэргэшсэн ёс зүйтэй үйлчилгээ үзүүлэхдээ дараах зарчмыг баримтлана:

2.2.1. хохирогчийг хангалттай мэдээллээр хангаж үйлчилгээнд хамрагдах эсэх талаар бие даан сонголт хийх боломжоор хангах, түүний сонголтыг хүндэтгэх;

2.2.2. хохирогчийн эрх, хэрэгцээнд суурилсан байх;

2.2.3. хохирогчийн соёлыг хүндэтгэх, мэдрэмжтэй байх, хүний хувийн орон зайдүү нэвтрэхгүй, зөвхөн хэрэгцээт мэдээлэл авах;

2.2.4. хохирогчийн сэтгэцийн гэмтэлд мэдрэмжтэй байж, сэтгэл зүйн үйлчилгээ, харилцаанд хэрхэн нөлөөлөхийг мэддэг байх

2.3 Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх байр, өрөө нь хохирогчийн сэтгэл зүйн болон бусад аюулгүй байдал, эрүүл ахуйд чийцсэн, стандартын дагуу хангагдсан байна.

2.4. Хохирогчийн мэдээллийн санг чандлан хадгагах техник, тоног төхөөрөмжтэй байна.

2.5 Хохирогчийг түүнд тохиолдсон асуудал, одоо байгаа байдал болон ирээдүйн шийдвэр, сонголтод нь буруутгахгүй нөлөөлөхгүй байна.

Гурав. Сэтгэл зүйчид тавигдах шаардлага

3.1. Сэтгэл зүйч нь дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. баклавэр зэргийг сэтгэл судлал мэргэжлээр төгссөн байх, тухайн мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, клиник сэтгэл зүй, сэтгэл засал, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх болон гэр бүлийн болон хосын асуудлаар зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн байх

3.1.2. хувь хүний сэтгэл зүйн тулгамдсан сэтгэл зүйн асуудлыг тодорхойлох, оношлох, үнэлэх зөвлөгөө, заслын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх чадвартай байх.

3.1.3. удирдагч багш, нарийн мэргэшсэн сэтгэл зүйчийн удирдлага дор нэгээс дээш жил клиник дадлага хийсэн туршлагатай байх.

3.1.4. сэтгэцийн гэмтлийн үед үзүүлэх сэтгэл заслын болон сэтгэл зүйн зөвлөгөөний арга, техникийг эзэмшсэн байх.

3.1.5. хүний эрх, жөндөрт суурилсан хүчирхийлэл, үүний дотор гэр бүлийн хүчирхийллийн сэдвээр тогтмол сургалтад хамрагдсан байх;

3.1.6. сэтгэл заслын чиглэлээр давтан сургалтанд тогтмол хамрагдсан байх;

3.1.7. клиник супервишн буюу мэргэжилтнүүдийн зөвлөгөөн, мэргэжлийн хэлэлцүүлэгт тогтмол оролцдог байх;

3.1.8. хохирогчийн тухайн цаг үеийн сэтгэл зүйн байдал, сэтгэл заслын арга техник, зарцуулсан цаг хугацааг байнга тэмдэглэн хөтөлдөг байх.

Дөрөв. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ

4.1. Сэтгэл зүйч хохирогчийн суурь шалтгааныг тодорхойлж тохирсон сэтгэл зүйн үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.2. Сэтгэл зүйч үйлчлүүлчид сэтгэл зүйн дараах үйлчилгээг үзүүлнэ:

4.2.1. хохирогчийн сэтгэл зүйн болон бие махбодийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашдын сэтгэл зүйн үйлчилгээг тодорхойлох;

4.2.2. анхан шатны тайвшруулах зөвлөгөө үзүүлэх;

4.2.3. хохирогчийн эрүүл мэнд, биеийн байдлын талаар холбогдох маягтын дагуу үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд дүгнэлт болон нотлох баримт гаргах;

4.2.4. хохирогчийг шаардлагатай богино болон урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах;

4.2.5. хохирогч тус бүрийн онцлог хэрэгцээ, хохирол, сэтгэцийн гэмтлийг харгалзан тухайн үе шатанд тохирсон сэтгэл зүйн боловсрол олгож, үйлчилгээ үзүүлэх;

4.2.6. хохирогчийг сэтгэцийн гэмтэлд дахин орох эрсдлээс урьдчилан сэргийлэх.

4.3. Хохирогчийн сайн сайхны төлөө түүний зөвшөөрөлтэйгээр хамтарсан багтай нягт хамтарч ажиллаж, бусад үйлчилгээнд холбон зуучлана.

4.4. Хохирогчийн хувийн хэргийг хөтлөх ба үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулна.

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, сэтгэцийн эмгэгтэй, ахмад настан зэрэг тусгай хэрэгцээт иргэн болон хүүхдэд тусгайлсан, мэргэшсэн үйлчилгээ үзүүлнэ. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг хүүхдэд үзүүлэхдээ хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон арга техникийг хэрэглэнэ.

4.6. Хохирогчийн гэр бүлийн гишүүдэд шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлнэ.

Тав. Хохирогчийн эрх

5.1. Хохирогч сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд сайн дураараа хамрагдана.

5.2. Хохирогч нь сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдахдаа дараах эрх эдэлнэ:

5.2.1. хувийн нууцаа хамгаалуулах;

5.2.2. чанартай, мэргэшсэн үйлчилгээ авах;

5.2.3. хүчирхийлэлд өртсөн тухайгаа баримтжуулах.

5.3. Хохирогч өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож, санал өгөх эрхтэй.

5.4. Хохирогч үйлчилгээ үзүүлж буй байгууллага болон үйлчилгээний талаар мэдээллээр хангагдах эрхтэй.

5.6. Хохирогч холбон зуучлах болон хүлээн авагч байгууллагын хамтарсан төлөвлөгөөтэй танилцаж, саналаа хэлэх, сонголт хийх эрхтэй.

5.7. Хохирогч өөрт хамааралтай мэдээллийг аль байгууллагад ямар зорилгоор дамжуулах гэж байгаа талаар мэдэх, зөвшөөрлийг бичгээр өгөх эрхтэй.

5.8. Хохирогч нь байгууллага, ажилтны гаргасан шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

Зургаа. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний гарах үр дүн

6.1. Хохирогчид зориулсан сэтгэл зүйн мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээний дараа дараах зорилгод хүрсэн байна:

6.1.1. хохирогчийн хүчирхийлэлтэй холбоотой сэтгэл зүйн хямрал багассан байх

6.1.2. хохирогч хүчирхийлэлээс үүдэлтэй сэтгэцийн гэмтлийн талаар ойлголттой болсон байх;

6.1.3. хохирогч зэрэг, даван туулах аргачлалд суралцсан байх;

6.1.4. хохирогч өөрийгөө буруутгахгүй болсон байх;

6.1.5. хохирогч өөртөө итгэх итгэл, өөрийн зан үйл, сэтгэл зүйн байдалдаа итгэлтэй болсон байх;

6.1.6. хохирогч гарч болзошгүй сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг үр дагавраас сэргийлэх сэтгэл зүйн үйлчилгээнд бүрэн хамрагдсан байх;

6.1.7. хохирогч гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголттой болсон байх;

6.1.8. хохирогч өөрийн амьдралыг цаашид хэвийн үргэлжлүүлэх сэтгэл зүйн чадварт суралцсан байх;

6.1.9. хүчирхийллийг даван туулах нийгмийн дэмжлэг нэмэгдсэн байх.

Долоо. Хориглох зүйл

7.1 Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний хүрээнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

7.1.1. шашин болон улс төрийн үзэл номлолыг сурталчлах, албадан тулгах;

7.1.2 ашгийн үйл ажиллагаа.

7.2. Сэтгэл зүйч нь ажиллах хугацаандаа болон ажлаас чөгөөлөгдсөн /халагдсан-ий дараа хохирогчийн талаар мэдээлэл хийх, нууц задруулахыг хориглоно.

7.3. Сэтгэл зүйч нь хохирогчтой мэргэжлийн хил хязгаарыг баримтлан харилцаж, түүнтэй хувийн харилцаанд орохыг, өөрийн хувийн мэдээллээ өгөхийг, хохирогчийн мэдээллийг олон нийтэд тараахыг хориглоно.

Найм. Бусад

8.1. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

8.2 Бүх шатны Засаг дарга хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээнд шаардагдах зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.1.5-д заасны дагуу төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

8.3 Сэтгэл зүйч нь ажлаа Засаг дарга, хамтарсан баг, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст зохих журмын дагуу тайлагнана.

8.4 Сэтгэл зүйч нь энэ журамд заасан зарчим, үүрэг, хориглох зүйлийг биелүүлээгүй бол Засаг дарга зохих арга хэмжээг хуулийн дагуу авна

--- одоо ---

Хөдөлмөр, нийгмийн хайгааллын сайдын 2017 оны 08 дугаар сарын 29 ны өдрийн А.А. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Хохирогчийн овог нэр	
Төрсөн он сар өдөр	
Бүртгэлийн дугаар	
Бүртгэсэн өдөр	

Хохирогчийн сэтгэл зүй, нийгэм, бие махбодийн байдлын үнэлгээ

1. Хохирогчийн одоогийн байдал /Хохирогчийн сэтгэл зүй, бие махбодийн талаар бичнэ/

Сэтгэл зүйн байдал	Бие махбодийн эрүүл мэндийн байдал	Нийгмийн асуудлууд

2. Нийгэмшлийн түүх /Хохирогчийн гарал үүсэл, өссөн гэр бүл, өөрийнх нь гэр бүлийн тухай бичнэ./

2.1. Гарал үүсэл буюу төрсөн гэр бүл:

2.2. Өссөн гэр бүл:

2.3. Одоогийн гэр бүл:

3. Гэр бүлийн харилцаа /Хохирогчийн өссөн гэр бүлийн харилцааны түүхийг бичнэ./

4. Сэтгэцийн эрүүл мэндийн байдал /Хохирогч нь хэзээ, хэдэн удаа, хаана, ямар төрлийн хүчирхийлэлд оргож байсан тухай бичнэ/

5. Хохирогчид илэрч буй сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой шинж тэмдгүүд

Сэтгэл хөдлөлийн шинж тэмдэг
(айдаас тигшлүүр эсдүүлэх, эсдүүлэхээс айсан байдал, өөрийн үнэлэмж унасан яриж гутрах, итгэл алдах гэх мэт)

Танин мэдэхүйн үйлдэл
(анхаарал төвлөрөхгүй байх, уялт бодогд аятах үймрэх, мартамхай болсох гэх мэт)

Бие мах бодид илрэх хариу үйлдэл
(ноёртуйдох, хоолны дуршил буурах эсвэл ихдэх, чирэх, салганах гэх мэт)

6. Эрүүл мэндийн байдал:

7. Архи, мансууруулах бодисын хэрэглээ

	Хэмжээ	Давтамж	Хугацаа	Анхны хэрэглээ	Сүүлчийн хэрэглээ
Тамхи					
Архи					
Мансууруулах бодис					
Бусад					

8. Хувийн бусад мэдээлэл /Хохирогчийн чөлөөт цаг хэрхэн өнгөрүүлдэг, шашин шүтлэг, даван туулсан байдал гэх мэт/

Сэтгэл зүйчийн овог нэр,
гарын үсэг, тэмдэг : _____ / _____ /

Огноо:



2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг түр хамгаалах байр байгуулан ажиллуулж байгаа төрийн, төрийн бус байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Ундрал/, Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ц.Мөнхзул/ нарт тус тус даалгасугай.



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
...А/116... дугаар тушаалын хавсралт

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан гэр бүлийн хүчирхийллийн хохирогч (цаашид хохирогч гэх)-ийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тэдний аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн тусгай байранд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтлана.

1.3. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10-т заасан стандартчлал хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан түр хамгаалах байрны стандартыг хангасан байранд үзүүлнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр түр хамгаалах байр байгуулах саналыг холбогдох үндэслэл, төсвийн тооцооны хамт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасны дагуу бүх шатны Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана.

2.2. Түр хамгаалах байрыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна.

2.3. Түр хамгаалах байрыг төрийн, төрийн бус байгууллагын харьяанд байгуулан ажиллуулж болно.

2.4. Түр хамгаалах байр байгуулан ажиллуулж буй төрийн бус байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн байна.

2.5. Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно.

2.6. Төрөгжсөн түр хамгаалах байр байхгүй тохиолдолд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг харгалзан үйлчилгээг үзүүлнэ.

2.7. Түр хамгаалах байрыг ажиглуулж буй төрийн, төрийн бус байгууллага нь түр хамгаалах байрыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээг бүрэн үзүүлнэ.

2.8. Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллагын удирдлага нь хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэхэд холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төр, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

2.9. Түр хамгаалан байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллага нь ажилтнуудаа давтан сургах, мэргэшүүлэх, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиглах үүргийг хүлээнэ.

2.10. Түр хамгаалах байрны байршил нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасны дагуу нүүц байна.

2.11. Түр хамгаалах байрны аюулгүй байдлын хамгаалалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу цагдаагийн байгууллага, эсхүл гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлнэ.

2.12. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

2.13. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлж, нэгдсэн сургалтыг зохион байгуулна.

Гурав. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

3.1. *Аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хангана:* Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

3.2. *Нууцлалыг чандлан хадгална:* Түр хамгаалах байрны байршлыг нууцлана. Хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэнэ. Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбоотой мэдээллийг задруулахыг хориглоно.

3.3. *Хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангана:* Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх бүх үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрнө. Өөртэй нь хамаатай шийдвэр гаргах үйл явцад хохирогчийн оролцоог хангана.

3.4. *Ялгаварлан гадуурхахгүй байна:* Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хохирогчдыг нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байна.

Дөрөв. Хохирогчийг түр хамгаалах байранд хүлээн авах

4.1. Хохирогчийн хүсэлт /өргөдөл/ болон цагдаагийн алба хаагчийн хийсэн аюулын зэргийн үнэлгээ, нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээ, хамтарсан багийн шийдвэр, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах шийдвэрийг үндэслэн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалан түр хугацаагаар байрлуулна.

4.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулиар үүрэг хүлээсэн ажилтан хохирогчийг түр хамгаалах байранд аюулгүй унаагаар хүргэж өгнө.

4.3. Хохирогч түр хамгаалах байранд холбогдох байгууллага, ажилтнаар хүргэгдэж ирсэн, өөрөө ирсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр хүлээн авна.

4.4. Түр хамгаалах үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хохирогч өөрөө ирсэн тохиолдолд хохирогчоос энэ журмын 4.1-т заасан баримт бичгийг шаардахгүйгээр хүлээн авна.

Тав. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ

5.1. Түр хамгаалах байр нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

5.2. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний төрлүүд нь харилцан уялдаатай, чанартай, шуурхай байна.

5.3. Түр хамгаалах байр нь хохирогчид юуны өмнө хямралын үеийн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.1.3, 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасан үйлчилгээг болон түр хамгаалах байрлуулах үйлчилгээний онцлогт тохирсон бусад үйлчилгээг үзүүлнэ. Үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

5.3.1. эмнэлгийн тусламж үйлчилгээ;

5.3.2. сэтгэл зүйн үйлчилгээ;

5.3.3. нийгмийн халамжийн үйлчилгээ;

5.3.4. хүүхэд хамгааллын үйлчилгээ;

5.3.5. эрх зүйн туслалцаа;

5.3.6. түр хамгаалан байрлуулах үйлчилгээний онцлогт тохирсон бусад үйлчилгээ

5.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээнд хамруулах;

5.4.2. эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах;

5.4.3. шаардлагатай тохиолдолд эмчийн жорын дагуу эм, бэлдмэлээр ханган үйлчлэх;

5.4.4. хэвтэн эмчлүүлэх тохиолдолд эмнэлгийн байгууллагад холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах.

5.5. Сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасан хохирогчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх журмыг баримталж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. хохирогчийн сэтгэл зүйн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

5.5.2. хохирогч асуудлаа тодорхойлох, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

5.5.3. хохирогчид бүлгийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлж хохирогч өөрт тулгамдсан асуудлыг шинэ хандлагаар харахыг дэмжих, түүнд амьдралаа илүү сайн сайхан байлгах итгэл найдварыг төрүүлэх, бие биендээ туслах чадварыг хөгжүүлэх.

5.6. Хохирогчид Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-д заасан журмын дагуу үзүүлнэ.

5.7. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29, 29, 30, 41 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

5.8. Хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.8.1. хохирогчид шаардлагатай эрх зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлэх;

5.8.2. хохирогчийн зүгээс болон холбогдох байгууллагаас шаардагдах нотлох баримт бүрдүүлэх;

5.8.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан ёсоор хохирогчид өмгөөллийн үйлчилгээг хуульд заасан журмын дагуу үзүүлэх.

5.8.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлж байгаа төрийн бус байгууллага нь хохирогчийн хүсэлтээр түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

5.9. Түр хамгаалах байрны онцлогт тохирсон бусад үйлчилгээнд дараах үйлчилгээнүүд орно:

5.9.1. нийгмийн ажлын үйлчилгээ;

5.9.2. боловсролын үйлчилгээ;

5.9.3. дэмжих бүлгийн үйлчилгээ;

5.9.4. асран халамжлах үйлчилгээ;

5.9.5. хоол хүнс, ариун цэвэр гэх мэт анхан шатны суурь хэрэгцээг хангах үйлчилгээ.

5.10. Нийгмийн ажлын үйлчилгээ нь хохирогчийг чадавхижуулахад чиглэсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.10.1. хохирогчийн аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх, зохицуулах, үйлчилгээний явц, үр дүнд хяналт тавих, үнэлгээ хийх, хохирогчийг дэмжих зэргээр кейс менежментийг хийх;

5.10.2. хохирогчийн аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хямралын үеийн болон нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

5.10.3. аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, эрсдлийг бууруулах зорилгоор аюулгүйн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх. Төлөвлөгөөг хохирогч хамгаалах байрнаас гаргах хүртэл хугацаанд тасралтгүй үргэлжлэх бүх үйл явцыг тодорхойлох ба хохирогчид тулгарсан эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалан өөрчилж байх;

5.10.4. хамгаалах байрны үйлчилгээ дуусгавар болсны дараа хохирогчийг харъяа нутаг дэвсгэрийн хамтарсан багт хүлээлгэн өгөх ба шаардлагатай урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд холбох.

5.11. Боловсролын үйлчилгээг үзүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь хэсэгт заасан боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журмыг баримтлана.

5.12. Дэмжих бүлгийн үйлчилгээ нь хохирогч хүчирхийллийг даван туулахыг дэмжиж, түүнд энэ талаар зохих мэдлэг, ур чадвар олгоход чиглэх ба дэмжих бүлгийг хохирогчийн нас, сэтгэхүйн онцлог, асуудлаас нь шалтгаалан нээлттэй болон хаалттай гэсэн 2 төрлөөр төрөлжүүлэн зохион байгуулна:

5.12.1. нээлттэй дэмжих бүлэгт шинээр гишүүнээр элсэх болон саналаараа бүлгээс гарахыг хохирогч өөрөө шийдэх ба дэмжих бүлгийн сэдэв, агуулга, үйл явц бүгд уян хатан байна;

5.12.2. хаалттай дэмжих бүлэг нь төлөвлөсөн хөтөлбөр, хугацааны дагуу гишүүд нь солигдохгүйгээр зохион байгуулагдана;

5.12.3. дэмжих бүлэг нь бүлэгт хамрагдах гишүүдийг судлах, бүлгийг зохион байгуулах, хөтөлбөр гаргах, хөтөлбөрт тусгагдсан сэдэв, агуулгын дагуу тогтмол хичээллэх ба төгсгөлд нь дэмжих бүлгийн зохион байгуулалт, гишүүдэд гарсан өөрчлөлт, үр дүнг үнэлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.13. Асран халамжлах үйлчилгээг бие даан амьдрах чадвар нь түр болон урт хугацаагаар алдагдаж, бусдын асаргаа шаардлагатай болсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, эмэгтэйчүүдэд түр хамгаалах байранд байрлан үйлчлүүлэх хугацаанд үзүүлнэ. Үйлчилгээнд хувийн ариун цэврийг хангах, хооллох зэрэг өдөр тутмын амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ орно.

5.14. Хохирогчийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээ дуусах үед түүнд дараагийн шатны урт хугацааны үйлчилгээ шаардлагатай бол бусад үйлчилгээнд холбон зуучлана. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т заасан холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг баримтлана.

Зургаа. Хохирогчийн эрх, үүрэг

6.1. Хохирогч нь түр хамгаалан байрлуулах байраар үйлчлүүлэхдээ дор дурдсан эрхтэй байна:

6.1.1. нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх;

6.1.2. аюулгүй байдал, хувийн нууцаа хамгаалуулах;

6.1.3. анхан шатны, яаралтай эмнэлгийн тусламж авах;

6.1.4. үйлчилгээ үзүүлж буй байгууллага, үйлчилгээний талаарх мэдээллээр хангагдах;

6.1.5. хуульд заасан үйлчилгээг цогцоор нь авах;

6.1.6. өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож, санал өгөх;

6.1.7. хүчирхийлэлд өртсөн тухайгаа баримтжуулах;

6.1.8. байгууллага, ажилтны гаргасан шийдвэрт гомдол гаргах.

6.2. Хохирогч нь түр хамгаалан байрлуулах байраар үйлчлүүлэхдээ дор дурдсан үүрэг хүлээнэ:

6.2.1. түр хамгаалах байрны дотоод журмыг даган мөрдөх;

6.2.2. түр хамгаалах байрны байршлыг байрлаж байх хугацаандаа болон байрлаад гарснаас хойш бусдад задруулахгүй нууцлах;

6.2.3. үйлчлүүлж байх хугацаандаа олж мэдсэн бусад хүний нууцыг задруулахгүй байх.

Долоо. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын эрх, үүрэг

7.1 Нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26-р зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй:

7.1.1. хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүх үе шатанд үйлчилгээг зохион байгуулж, кейс менежерийн үүрэг гүйцэтгэн ажиллах;

7.1.2. хамгаалах байрны багийн ажил, салбар хоорондын уялдааг хангах, зангидан зохицуулах;

7.1.3. хохирогчийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах;

7.1.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, өндөр настанд тусгайлсан үйлчилгээ, туслалцаа үзүүлэх;

7.1.5. хохирогчийн хувийн хэргийг хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах;

7.1.6. эмнэлгийн байгууллагад холбон зуучлах, анхан шатны эмнэлгийн туслалцаа үзүүлэх; үйлчилгээг дуусгавар болгох хүртэл бүх үе шатанд эрүүл мэндийн үйлчилгээг хариуцан ажиллах.

7.2. Сэтгэл зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй:

7.2.1. хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөөг хуульд заасан журмын дагуу үзүүлэх;

7.2.2. хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүх үе шатанд хямралын үеийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

7.2.3. хохирогчийг тайвшруулах, цагдаагийн болон хуулийн бусад байгууллагад өгөх мэдүүлэг, байцаалт, эмчийн үзлэг зэрэгт сэтгэл зүйн талаас нь бэлтгэх;

7.2.4. хохирогчийн сэтгэл зүйн тулгамдсан хэрэгцээний талаар дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх;

7.2.5. хохирогчийн сэтгэл зүйн тулгамдсан хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн сэтгэл заслын эмчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах;

7.2.6. хохирогчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний тэмдэглэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах.

7.3. Эрх зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй:

7.3.1. хохирогчид эрх зүйн зөвлөгөөг хуульд заасан журмын дагуу үзүүлэх;

7.3.2. хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүх үе шатны эрх зүйн зөвлөгөө, хуулийн туслалцаа үзүүлэхтэй холбогдох үүргийг хариуцан ажиллах;

7.3.3. шаардлагатай тохиолдолд хохирогчийн хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах, өмгөөллийн болон бусад үйлчилгээнд холбон зуучлах;

7.3.4. хүчирхийлэлд өртсөн болон өртөж байсан талаарх нотлох баримтыг бүрдүүлэх, өргөдөл, гомдол, нэхэмжлэлийг холбогдох хуулийн байгууллагад гаргахад арга зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлэх;

7.3.5. хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллах;

7.3.6. хохирогчид эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн тухай хувийн хэргийг хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах.

Найм. Хориглох зүйл

8.1. Хамгаалах байрны ажилтан ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөн /халагдсан/-ий дараа хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаар аливаа мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.

8.2. Хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагын ажилтан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.

8.3. Шашны суртал номлолыг дэлгэрүүлэх, ашиг олох, хууль бус үйл ажиллагааг халхавчлах зорилгоор түр хамгаалах байр байгуулах, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

8.4. Түр хамгаалах байранд хүчирхийлэл үйлдэгч нэвтрэх, аливаа хэлбэрээр хохирогчтэй холбоо тогтоох, тогтоолгохыг оролдох, хохирогчид

айдас түгшүүр үүсгэх бусад үйлдэл хийх болон түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

8.5. Түр хамгаалах байрны ажилтнууд хүчирхийлэл үйлдэгчийг нэвтрүүлэх, хохирогчтой хувийн харилцаа тогтоох, мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг зөрчихийг хориглоно.

Ес. Санхүүжилт

9.1. Түр хамгаалах байр нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх ба зардлыг улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2-т заасны дагуу халамжийн сангийн хөрөнгөөс, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

9.2. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.3-д заасан хугацаанд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

9.3. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ журмын 8.2-т заасан тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.

9.4. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцно.

9.5. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж буй төрийн бус байгууллагын санхүүжилтийг тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл, төсвийн төсөлд өгсөн саналыг үндэслэн олгоно.

9.6. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын санхүүжилтийг сар бүр хүн, өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар, улирал тутам олгоно.

9.7. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь санхүүжилтийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулж, санхүүжүүлэгч байгууллагад сар, улирлаар тайлагнана.

9.8 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь нэмэлт санхүүжилт авах зорилгоор түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд зорилтот бус хохирогч хамруулах, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, зардлыг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

9.9. Түр хамгаалах байрны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж болно.

Арав. Тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ

10.1. Түр хамгаалах байр нь үйл ажиллагааны болон санхүүгийн нэгдсэн тайланг бүтэн жилээр гаргаж, тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

10.2. Засаг дарга нь энэхүү журмын 10.1-д заасан тайланг тухай шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ.

10.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь энэхүү журмын 10.2-т заасан тайланг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.

10.4. Шаардлагатай тохиолдолд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангана.

10.5. Түр хамгаалах байр нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал тутам гаргаж, харъяаллаас хамаарч хууль зүй, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

10.6. Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллагын удирдлага ажилтнуудаа давтан сургаж, мэргэшүүлж буй байдал, түр хамгаалах байрлуулах үйлчилгээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, хяналт тавина.


10.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь шаардлагатай тохиолдолд түр хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Арван нэг. Хариуцлага

11.1. Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн этгээд, түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл өөр зориулалтаар ашигласан хуулийн этгээдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

11.2. Түр хамгаалах байрлуулах үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагаанд саад учруулсан этгээд, мөн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг түгээсэн, задруулсан этгээдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-т заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

---oOo---



**МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2012 оны 07 сарын 18 өдөр Дугаар 4/91 Улаанбаатар хот

Журам, шалгуур батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь заалт-г үндэслэн **ТУШААХ** нь:

1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуурыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуурыг мөрдөж хэрэгжүүлэх явцад хяналт, үнэлгээ хийж, үйлчилгээний төрөл тус бүрийг үзүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага, стандартын төслийг боловсруулж батлуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Д.Баярсайхан)-т даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ш.Мөнхцэрэн/, Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар /Ш.Отгонхундага/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэ тушаалыг 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Т.ГАНДИ

C:\My documents\said_tushaal_doc



ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТУШИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1, 22.2.2-т заасан үйлчилгээ (цаашид "үйлчилгээ" гэх)-г иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага (цаашид "үйлчилгээ үзүүлэгч байгууллага" гэх)-ын оролцоотойгоор үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

Хоёр. Үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг хянан шийдвэрлэх

2.1 Сум, хорооны нийгмийн ажилтан нь нийслэл, тухайн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас үзүүлж буй болон тухайн жилд үзүүлэхээр төлөвлөж буй Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.4-т заасан иргэнд тус хуулийн 18.1.4-т заасан үйлчилгээ үзүүлэхээс бусад үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын нэр, хаяг, байршил зэрэг мэдээллийг нийтэд нээлттэй ил, тод байршуулна.

2.2 Энэхүү журмын 2.1-т заасан мэдээллийг үндэслэн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өрх, иргэн энэхүү журмын 3-т заасан баримт бичгийг бүрдүүлж сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

2.3 Сум, хорооны нийгмийн ажилтан үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан 18.2.8-д зааснаас бусад өрх, иргэний бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч амьдралын нөхцөлийг нь судлан үзэж, холбогдох саналаа ажлын 10 хоногт багтаан сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

2.4 Өрх, иргэний хамрагдахыг хүссэн үйлчилгээний төрөл нийслэл, тухайн аймаг, сум, дүүргийн хэмжээнд байхгүй тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан үйлчилгээний төрөл тус бүрээр уг үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өрх, иргэний хүсэлтийг бүртгэн Амьжиргааг дэмжих зөвлөлд танилцуулж байна. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл нь ийнхүү тодорхойлсон хэрэгцээний талаарх мэдээллийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.3-т заасан саналын хамт аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.5 Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэхүү журмын 2.3-т заасны дагуу Амьжиргааг дэмжих зөвлөлийн гаргасан шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногт багтаан аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

2.6 Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү журмын 2.3-т заасан шийдвэр, баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнд хувийн хэрэг нээн баталгаажуулж, сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ.

2.7 Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр,

тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээний аль алинд нь хамрагдах тохиолдолд энэхүү журмын 3-т заасан баримт бичгийг давхар бүрдүүлэхгүй байж болно. Энэ тохиолдолд сумын нийгмийн ажилтан, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тухайн өрх, иргэнд нэг хувийн хэрэг нээнэ.

2.8 Сум, хорооны нийгмийн ажилтан энэхүү журмын 2.4-т заасан өрх, иргэнд үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн тухай мэдэгдэж, дэвтэр нээн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаар танилцуулж, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна

Гурав. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэний бүрдүүлэх баримт бичиг

3.1 Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэн хүсэлт гаргахдаа дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

3.2 Өргөдөл /маягтын дагуу/;

3.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.8-д зааснаас бусад иргэний тухайд иргэний үнэмлэх (16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ), хуулбарын хамт;

3.4 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.2-т заасан иргэний тухайд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 10.1-т заасны дагуу гаргасан холбогдох эмнэлгийн байгууллагын дүгнэлт, шийдвэр;

3.5 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.3-т заасан тохиолдолд тухайн сум, хорооны хүн амын хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны тодорхойлолт;

3.6 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.4-т заасан иргэний тухайд хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон бол энэ тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт, эсхүл мэргэжлийн нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ, тодорхойлолт;

3.7 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.5-д заасан иргэний тухайд ял шийтгэл эдэлж байгаад суллагдсан тухай холбогдох байгууллагын тодорхойлолт;

3.8 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.6, 18.2.7-д заасан иргэний тухайд холбогдох нарийн мэргэжлийн эмчийн буюу эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

3.9 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.8-д заасан тохиолдолд тухайн иргэний гэр оронгүй тэнэмэл амьдралтайг судлан тогтоосон мэргэжлийн нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ, тодорхойлолт;

3.10 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.9-т заасан тохиолдолд тухайн иргэний шилжин ирсэн тухай Засаг даргын тодорхойлолт;

3.11 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.10-т заасан тохиолдолд тухайн иргэний өрх толгойлсон тухай Засаг даргын тодорхойлолт;

3.12 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.3-т заасан үйлчилгээнд хамрагдах иргэний тухайд сэргээн засах үйлчилгээ шаардлагатайг тодорхойлсон эмчийн буюу эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

3.13 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6-д заасан үйлчилгээнд хамрагдах иргэний тухайд "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ын 2.13-т заасан тодорхойлолт;

3.14 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-т заасан хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх өрх, иргэдийн тухайд зохих шаардлагын дагуу болсворуулсан төсөл;

Дөрөв. Үйлчилгээ үзүүлэх

4.1 Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур", стандартчлал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан холбогдох стандартыг баримтлан үзүүлнэ.

4.2 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг тус хуулийн 18.6-д зааснаар сонгон шалгаруулах ажлыг энэхүү журмын 2.4-т заасны дагуу сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэл, саналыг үндэслэн тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

Тав. Бусад

5.1 Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага тус тус хяналт тавина

5.2 Хуурамчаар баримт бичиг үйлдсэн өрх, иргэн, үйлчилгээнд хамрагдах өрх иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүйгээр буюу хуурамчаар үйлдсэн, нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэргээр хууль зөрчсөн албан тушаалтан, нийгмийн ажилтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж үзүүлсэн үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ


5.3 Сумын нийгмийн ажилтан дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага нь дараахь тохиолдолд Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг харгалзан өрх, иргэний үйлчилгээнд хамрагдахыг зогсооно.

5.3.1 үйлчилгээнд хамрагдаж буй иргэн нас барсан;

5.3.2 хуурамч материал бүрдүүлэн үйлчилгээнд хамрагдсан буюу хамруулсан нь хяналт шалгалтаар тогтоогдсон;

5.4 Сум, хорооны нийгмийн ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь амжилттай хэрэгжсэн төсөл, үйлчилгээний талаарх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулна

5.5 Сум, хорооны нийгмийн ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэдийн талаарх мэдээллийг нийгмийн халамжийн нэгдсэн мэдээллийн санд оруулж холбогдох мэдээ, тайлан, судалгааг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргана.



Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур үзүүлэлт

Д/д	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний чиглэл	Хамрагдах өрх, иргэн	Үйлчилгээнд тавигдах чанарын шалгуур үзүүлэлт	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавигдах үндсэн шаардлага
1	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	1. Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох; 2. Зорилгод бүлгийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах; 3. Өдөр тутмын амьдралын дарамт, стрессийг даван туулах чадварыг бий болгох; 4. Эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх; 5. Тодорхой бэрхшээл, эрсдлээс зайлсхийх, даван туулах, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох; 6. Мэргэжлийн чиг баримж олгох;	1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуулах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/;	1. Сургалтанд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна. 2. Сургалтанд хамрагдсан иргэний тоо, давтамж зарцуулсан хөрөнгийн үр ашгит байдал. 3. Сургалтанд хамрагдсан иргэдэд ямар үр чадварууд бий болсон. 4. Сургалтанд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн үнэлгээтэй байна. 5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, бие даан амьдрах чадвар дээшилсэн эсэх талаар судалгаагаар байна.	1. Шаардлага хангасан сургалтын хөтөлбөртэй байна. 2. Сургалтын үйлчилгээ явуулах гэрчилгээтэй байна. 3. Сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсон хүчинтэй байна. 4. Сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөтэй байна. 5. Сургалтын гарын авлагатай байна. /сургагчдад зориулсан/ 6. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна. 7. Үйлчилгээ авагчдын гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна. 8. Өдөр тутмын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрсө гарын үсэг зурж баталгаажсан байна.

Зөвлөлөгч өгөх үйлчилгээ	<p>1. Хууль зүйн зөвлөлгөө өгөх</p> <p>2. Сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх.</p>	<p>1. Амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд туслгах.</p> <p>2. Түлгэр- буй сэтгэл зүйн асуудал бэрхшээлтэй нөхцөл байдалыг ойлгогч тогтоох шийдвэрлэхэд нь мэрэгжлийн тусламж дэмжлэг үзүүлэх.</p>	<p>1. Ахмад настай</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</p> <p>3. Хүчирхийлэлд өртсөн иргэн.</p> <p>4. Хорих аялагч суллагдсан иргэн.</p> <p>5. Согтуулах, махчуурах донтох явцтай иргэн</p> <p>6. Гэр орсонгүй гэнэмэл амьдралтай өрх иргэн</p> <p>7. Шидэжиг суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн иргэн</p> <p>8. Эдгээшгүй хүнд явцтай иргэн.</p> <p>9. Өвч толгойлсон эх дэцэг.</p>	<p>1. Үйлчилгээнд хамрагдах өрх иргэдийг харьца сүм, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах мэдээлэл жагсаалтанд орсон байна</p> <p>2. Үйлчилгээнд хамрагдах өрх иргэдийг давтамж зарцуулсан харьяатчид үр ажилт байдал.</p> <p>3. Үйлчилгээнд хамрагдасан иргэдийн тухай мэдээлэл хандлага төвлөмжид гарч буй өөрчлөлтүүдийн талаар үнэлгээтэй байна</p> <p>4. Үйлчилгээнд хамрагдасан иргэдийн ажил хөдөлмөөр эрхлэх сонирхол, өмч даан амьдрах чадвар дээшлэлсэн эсэх талаар үнэлгээтэй байна</p> <p>5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөөр эрхлэх сонирхол, өмч даан амьдрах чадвар дээшлэлсэн эсэх талаар үнэлгээтэй байна</p> <p>6. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн зөн үйл хандлага төвлөмжид гарч буй өөрчлөлтүүдийн талаар үнэлгээтэй байна</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна</p> <p>2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна</p> <p>3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байна</p> <p>4. Байгууллагын ноо, холбоо барих утас байршил</p> <p>5. Ажиллах цагийн хураарь дэлгэрэнгүй байна</p> <p>6. Тухайн үйлчилгээний төрөл, нөхцөлүүд тодорхой байна</p> <p>7. Үйлчилгээ авагчийн гэрлийн маяг, утасны дугаар болон мэдээллийн бүртгэлтэй байна</p> <p>8. Өдөр тутмын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна</p>
--------------------------	---	--	--	---	--

2

Сэргээн засах үйлчилгээ	<p>Эрүүл мэндийн сэргээн засах</p> <p>2. Боловсролын сэргээн засах</p> <p>3. Хөдөлмөрийн сэргээн засах</p> <p>4. Нийгэм-сэтгэл зүйн сэргээн засах</p>	<p>1. Хэл хөдөлгөөн, ахуйн, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх</p> <p>2. Эзэмшсэн мэргэжлийг нь сэргээх үр чадварыг нь сайжруулах</p> <p>3. Алдагдсан чадварыг сэргээхэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний нөлөөллийг үзүүлэх</p> <p>4. Нийгмийн зан үйл, нөгөөллийн аргуудыг эцэжлэх замаар хүмүүсийн харилцааны боломжит нөхцөлийг бүрдүүлэх.</p> <p>5. Боловсрол зээмших хөдөлгөөн эрхлэх боломжийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллагын үйл ажиллагаанд хамруулах, сэтгэл зүйн зөвлөлөгч өгөх, сэтгэл засал хийх, сэтгэл засааны дэмжлэг үзүүлэх.</p>	<p>1. Ахмад настай</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</p> <p>3. Хүчирхийлэлд өртсөн иргэн.</p> <p>4. Хорих аялагч суллагдсан иргэн</p> <p>5. Согтуулах, махчуурах донтох явцтай иргэн.</p> <p>6. Гэр орсонгүй гэнэмэл амьдралтай өрх иргэн.</p> <p>7. Шидэжиг суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн иргэн.</p> <p>8. Эдгээшгүй хүнд явцтай иргэн.</p> <p>9. Өвч толгойлсон эх дэцэг.</p>	<p>1. Үйлчилгээнд хамрагдасан иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна</p> <p>2. Үйлчилгээнд хамрагдах өрх иргэдийг харьца сүм, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах мэдээлэл жагсаалтанд орсон байна</p> <p>3. Сургалтанд хамрагдсан иргэдийн даватмаж зарцуулсан хөрөнгийн үр ажилт байдал.</p> <p>4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн эрүүл мэнд болон амьдралын чанард гарсан өөрчлөлтийн талаарх үнэлгээтэй байна.</p> <p>5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээлэл хандлага төвлөмжид гарч буй өөрчлөлтүүд талаарх үнэлгээтэй байна</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна</p> <p>2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна</p> <p>3. Эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ үзүүлдэг</p> <p>4. Мэргэжлийн боловсон хүчинтэй байна</p> <p>5. Байгууллагын ноо, холбоо барих утас байршил,</p> <p>6. Ажиллах цагийн хураарь дэлгэрэнгүй байна</p> <p>7. Тухайн үйлчилгээний төрөл, нөхцөлүүд тодорхой байна</p> <p>8. Үйлчилгээ авагчийн гэрлийн маяг, утасны дугаар болон мэдээллийн бүртгэлтэй байна</p> <p>9. Өдөр тутмын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна</p>
-------------------------	---	---	--	--	--

3

<p>Тур байр суулан асраажлах үйсчилгээ</p>	<p>1. Хүчирхийлэлд нэрвэх магдалалтан ирлэдийг усьдчилан сэргийлэх 2. Хүчирхийлэлд орсон иргэдэд стэнээртын дэгуу үйлчилгээ гээрүүлэх.</p>	<p>1. Бичиг баримжуулах, 2. Эрүүл мэндийн болон хүүгч зүйн үйлчилгээ гээрүүлэх 3. Хөгжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх 4. Хэлбэлт зуучлах, 5. Хүүхдэд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх. 6. Халуун хоол цаагаар үйлчлэх.</p>	<p>1. Хөгжлийн бэрхшээлтэй исгэн, 2. Хүчирхийлэлд орсон иргэн 3. Хорих өнгөс сүлгэдсэн иргэн, 4. Сэтгүүлэх мэрсүүрэх дөнгөх өвчтэй иргэн, 5. Цилижин суурьшсан Тийлгийн хэлэлжийн тухай хуугийн 3 * 2 т звэсэн өрхийн гиршүүч иргэн, 6. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд.</p>	<p>1 "Хэвирдгийн хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" MNS6040 2009 стандарт н дагуу хигдсэн байна 2 Тийлгийн хамгаалал, хөдөлмөрийн сэвд, хууль зүйн дотоод хэргийн сойдын 2009 оны 9 дүгээр сарын 21-ны 128/188 тоот тушаалын 2 дугаар хавсралт болох Гэр бүлийн нөхцөл байдлыг хяналтанд үндэслэн хийгдсэн байна</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна 2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл гэрчилгээтэй байна 3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байна. 4. Байгууллагын нэр, холбоо барих утас байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна 5. Тухайн үйлчилгээний төрсөл орчин, нөхцөлүүд тодорхой байна 6. Үйлчилгээ авалчдын гэрлийн хааг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна 7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна</p>
<p>4</p>					

<p>Өдрийн үйлчилгээ</p>	<p>1. Ахмад настны өдрийн үйлчилгээ үзүүлэх; 2. Хүнд нөхцөлд байгаа нүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдрийн үйлчилгээ үзүүлэх.</p>	<p>1. Соёл, урлаг биеийн тамир спортын арга хэмжээнд оролцуулах; 2. Сэргээн засах; 3. Амьдрах ухаанд сургах; 4. Зөвлөгөө өгөх;</p>	<p>1. Ахмад настны; 2. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд; 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд;</p>	<p>1. Үйлчилгээнд хамрагдсан иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. 2. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна. 3. Сургалтанд хамрагдсан иргэний тоо, давтамж зарцуулсан хөрөнгийн үр ашгийн байдал. 4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн эрүүл мэнд болон амьдралын чанарт гарсан өөрчлөлтийн талаарх үнэлгээтэй байна. 5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүд талаарх үнэлгээтэй байна.</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна. 2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна. 3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байх. 4. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна. 5. Тухайн үйлчилгээний төрсөл, орчин, нөхцөлүүд тодорхой байна. 6. Үйлчилгээ авагчдын гэрлийн хааг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна. 7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж, баталгаажсан байна.</p>
<p>5</p>					

Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ	1. Асаргаа, эрүүл мэнд, гэр ахуйн, мэдээлэл хангах, гадуур ажилд туслах гэх мэт үйлчилгээ үзүүлэх;	1. Гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх 2. Өдөр тутмын асаргааны үйлчилгээ үзүүлэх; 3. Гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх; 4. Эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах; 5. Хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах;	1. Байнгын асаргаатай ахмад настан; 2. Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд;	1. Үйлчилгээнд хамрагдсан иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. 2. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна. 3. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн талаар тооцоо. 4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн эрүүл мэнд болон амьдралын чанарт гарсан өөрчлөлтийн талаарх үнэлгээ хийсэн байна. 5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн өөртөө үйлчлэх чадвар нэмэгдсэн байна.	1. Мэргэжлийн байгууллага байна. 2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна. 3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байх. 4. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна. 5. Тухайн үйлчилгээний төрөл, орчин, нөхцөлүүд тодорхой байна. 6. Үйлчилгээ авагчдын гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна. 7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна.
------------------------------------	--	--	--	--	--

6

Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ	1. Өрх, иргэний амьдралын нөхцөл байдлыг өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлэх 2. Өрх, иргэний нөөц боломж чадаахи хэрэгцээнд тохирох үйлчилгээг туршин хэрэгжүүлэх	1. Өөрсдөө бие даан хөгжих боломжийг нь судалж, 2. Өрхийн хөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадаахийг тодорхойлж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх.	1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуулах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн 7. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн; 8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн; 9. Өрх толгойлсон эх /эцэг/;	1. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна. 2. Сургалтанд хамрагдсан иргэний тоо, давтамж зарцуулсан хөрөнгийн үр ашгийн байдал. 3. Үйлчилгээнд хамрагдсан иргэн тус бүрийн нас, хүйс, зорилтод бүлгийн чадварт тохирсон байдлаар хэрэгжсэн байна. 4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээ хийсэн байна. 5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, бие даан амьдрах чадвар дээшилсэн эсэх талаарх үнэлгээ хийсэн байна. 6. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн зан үйл, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээ хийсэн байна. 7. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хэрэгцээг тодорхойлон эрэмбэлж, нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байна.	1. Мэргэжлийн байгууллага байна. 2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна. 3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байх. 4. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна. 5. Тухайн үйлчилгээний төрөл, орчин, нөхцөлүүд тодорхой байна. 6. Үйлчилгээ авагчдын гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна. 7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна.
---	---	---	---	--	--

7

<p>Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байруулах</p> <p>8</p>	<p>1. Иргэний шинэчлэгдсэн бүртгэлд хамруулж, бичиг баримтжуулах</p> <p>2. Түр хоноглох байранд байрлуулах, халуун хоол цайгаар үйлчилэх</p> <p>3. Хөгжлийн үйлчилгээ үзүүлэх</p> <p>4. Сургалтанд хамруулж ажлын байранд зуучлах.</p>	<p>1. Бичиг баримтжуулах талаар зөвлөгөө өгөх.</p> <p>2. Амьдрах ухааны сургалтанд хамруулан, Ажилгүй иргэдийн бүртгэлд бүртгүүлэх</p> <p>4. Шаардлагатай бол мэргэжил олох сургалтанд хамруулах.</p> <p>5. Тохирсон ажлын байранд зуучлах.</p>	<p>1. Хорих ангиас суллагдсан иргэн;</p> <p>2. Согтуулах, мансуурах донтох өвчтэй иргэн;</p> <p>3. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;</p> <p>4. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн;</p> <p>5. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн;</p> <p>6. Өрх толгойлсон эх /эцэг/;</p>	<p>1. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна.</p> <p>2. Үйлчилгээнд хамрагдагсдын тоо, заруусан хөрөнгийн талаар тооцоо.</p> <p>3. Үйлчилгээнд хамрагдсан иргэн тус бүрийн нас, хүйс, зорилгод бүлгийн чадварт тохирсон байдлаар хэрэгжсэн байна.</p> <p>4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаар үнэлгээ хийсэн байна.</p> <p>5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, бие даан амьдрах чадвар дээшилсэн эсэх талаарх үнэлгээ хийсэн байна.</p> <p>6. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн зан үйл, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээ хийсэн байна.</p> <p>7. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хэрэгцээг тодорхойлон эрэмбэлж, нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байна.</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна.</p> <p>2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна.</p> <p>3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байх.</p> <p>4. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна.</p> <p>5. Тухайн үйлчилгээний төрөл, орчин, нөхцөлүүд тодорхой байна.</p> <p>6. Үйлчилгээ авагчдын гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна.</p> <p>7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна.</p>
---	--	---	--	---	---

<p>Ийгмийн халамжийн зөвлөлтэй туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн эрхэм нийтийн оролцоонд түшицлэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилго өрх иргэний нийгмийн харилцаанд төгсөн орсголжуулах, хамт олны бүлэг бүрдүүлэх, иргэдийн эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сурилах</p> <p>9</p>	<p>1. Төсөл бичих үүнийг хэрэгжүүлэх амьдрах ухааны сургалтанд хамруулах.</p> <p>2. Хамт олныг буцаа бүрдүүлж оролцоо нэмэгдүүлэх, үйлчлэрсэл үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх</p> <p>нийгэмийн харилцаанд төгсөн орсголжуулах, хамт олны бүлэг бүрдүүлэх, иргэдийн эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сурилах</p>	<p>1. Төсөл бичих чадвартар болгох</p> <p>2. Багаар ажиллах чадвартар болгох.</p> <p>3. Тухайн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай үз чадвартар болгох.</p> <p>4. Тухайн төсөлийг цааш нь өргөжүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болгох</p>	<p>1. Ахмад настай, Хөгжлийн баршээлтэй иргэн</p> <p>3. Хүчирхийлэлд өртсөн иргэн</p> <p>4. Хорих ангиас суллагдсан иргэн.</p> <p>5. Согтуулах, мансуурах донтох өвчтэй иргэн</p> <p>6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн.</p> <p>7. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн.</p> <p>8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн.</p> <p>9. Өрх толгойлсон эх /эцэг/</p>	<p>1. Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг харьяа сум, хорооны нийгмийн ажилтанд бүртгүүлж үйлчилгээ авах нэрсийн жагсаалтанд орсон байна.</p> <p>2. Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо, давтамж заацуулсан хөрөнгийн үр ашгийн байдал</p> <p>3. Үйлчилгээнд хамрагдсан иргэн тус бүрийн нас, хүйс, зорилгод бүлгийн чадварт тохирсон байдлаар хэрэгжсэн байна</p> <p>4. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн төсөл хэрэгжүүлэх үр чадавч дээшилсэн байна</p> <p>5. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, бие даан амьдрах чадвар дээшилсэн эсэх талаарх үнэлгээ хийсэн байна</p> <p>6. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн зан үйл, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээ хийсэн байна</p> <p>7. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн хэрэгцээг тодорхойлон эрэмбэлж, нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байна.</p>	<p>1. Мэргэжлийн байгууллага байна.</p> <p>2. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, гэрчилгээтэй байна.</p> <p>3. Мэргэжлийн боловсон хүчинтэй байх.</p> <p>4. Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байна.</p> <p>5. Тухайн үйлчилгээний төрөл, орчин, нөхцөлүүд тодорхой байна.</p> <p>6. Үйлчилгээ авагчдын гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэлтэй байна.</p> <p>7. Өдөр тутамын авсан үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлж, иргэн өөрөө гарын үсэг зурж баталгаажсан байна.</p>
---	---	--	--	--	---



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Хөтөлбөр, журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /Ц.Амгаланбаяр/, Цагдаагийн ерөнхий газар /Ө.Энхтөр/-т тус тус даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т даалгасугай.



САЙД

С.БЯМБАЦОГТ

DocMushaal Said. 2017 он

08 0331



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дугаар сарын 04 ны өдрийн А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон сэтгэл зүй, зан үйлийн өөрчлөлтийн хосолмол онолын загваруудыг тус тус удирдлага болгоно.

1.2. Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалт явуулах, эрхийг нь хязгаарласан орчинд сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно.

Хоёр. Хэрэгцээ, шаардлага

2.1. Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн /цаашид "оролцогч"-ийн гэх/ зан үйл, сэтгэл зүйн чиг хандлагад нөлөөлөх, дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагатай, ухамсарт иргэн болж төлөвшүүлэх, хүмүүжүүлэхийн тулд зан үйлд нөлөөлөх хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах шаардлагатай.

Гурав. Зорилго

3.1. Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын зэрэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд хариуцан зохион байгуулна.

4.2. Сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

4.3 Энэ журмын 4.1-д заасан байгууллагууд нь хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг сургах нөхцөлөөр ханган, тэдэнд дэмжлэг үзүүлж, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтад идэвхтэй оролцуулах үүргийг тус тус гүйцэтгэнэ.

Тав. Сургалтын хөтөлбөрийн зорилт

5.1. Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

5.1.1. оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах;

5.1.2. шүүхээс албадан сургалтад хамруулахаар заасан хугацааг харгалзан сургалтыг явуулах;

5.1.3. албадан сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4. сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтад тус тус тогтмол хамруулах;

5.1.6. оролцогчид сэтгэл зүйн болон амьдрах ухааны боловсрол олгон зөв бодол санаа, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, эерэг сэтгэлгээтэй болгох;

5.1.7. сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, амьдралын эрүүл хэв маяг, хэм хэмжээг төлөвшүүлэх;

5.1.8. сургалтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.

Зургаа. Сургалтын алсын хараа

6.1. Сургалтын алсын хараа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байна. Үүнд:

6.1. сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх;

6.2. сургалтыг явуулах алба хаагч нь мэдлэг чадвартай, мэргэшсэн байх;

6.3. алба хаагчийн мэдлэгийг ур чадвар болгон хувиргах замаар байгууллагын ажлыг тодорхой үр дүнд хүргэх.

6.4. Сургалтад хамрагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх.

Долоо. Сургалтын хэлбэр, хэрэглэгдэхүүн

7.1. Сургалтын хэлбэр

7.1.1. ганцаарчилсан сургалт;

7.1.2. бүлгийн сургалт;

7.1.3. хосолсон сургалт гэсэн хэлбэртэй байна.

7.2. Сургалтыг дараах хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг ашиглан зохион явуулна.

7.2.1. компьютер;

7.2.2. проектор;

7.2.3. ном, гарын авлага, бусад материал;

7.2.4. хөгжим, дүрс бичлэг;

7.3. Бясалгалын сургалтын өрөө, байрыг эрүүл ахуйн болон бусад шаардлага хангахаар тохижуулах.

Найм. Сургалтын төрөл

8.1. Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрлүүдтэй байж болно:

8.1.1. Сэтгэл зүйн сургалт:

8.1.1.а. архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар;

8.1.1.б. хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах;

8.1.1.в. уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;

8.1.1.г. харилцах ур чадвараа дээшлүүлэх;

8.1.1.д. бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;

8.1.1.е. өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;

8.1.1.ё. хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал, сөрөг үр дагавар;

8.1.1.ж. гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх

8.1.2. Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулна.

8.1.3. Бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, явуулна.

8.1.4. Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна.

8.1.5. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулна.

8.1.6. Хөтөлбөрийн 8.5-д заасан сургалтыг хослуулан явуулахдаа хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болно.

Ес. Хөтөлбөрт тусгагдсан сургалтын хугацаа

9.1. Баривчлагдсан оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтыг шүүхээс тогтоосон албадан сургалтын цагтай уялдуулан харилцан адилгүй тогтоож болно.

9.2. Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа:

д/д	Сургалтын сэдэв	Хичээлийн цаг /60 минут/
1.	Сэтгэл зүйн сургалт	16-41
	- архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар	
	- хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах	
	- уур бухимдлыг хэрхэн зохицуулах	
	- харилцах ур чадвараа дээшлүүлэх	
	- бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх	
	- өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	
2.	Эрх зүйн сургалт	5-10
	- Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль;	
	- Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль	
	- Бясагалын сургалт	
Сургалтын нийт цаг		23-56 цаг

9.3. Нэг удаагийн ганцаарчилсан болон бүлгийн сургалтын үргэлжлэх дундаж хугацаа 45 минутаас ихгүй байна. Харин шаардлагатай тохиолдолд бүлгийн сургалтыг 90 минутаас ихгүй байхаар явуулна.

Арав. Сургалтын санхүүжилт

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

10.1.1. улсын төсөв;

10.1.2. төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилт;

10.1.3. байгууллагын дотоод орлого.

Арван нэг. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

11.1. Хөтөлбөрт дараах үнэлгээг хийнэ.

11.1.1. оролцогчдод нөхцөл байдлын үнэлгээг сургалтын эхэнд үнэлсэн байх;

11.1.2. хөтөлбөр дуусмагц төгсгөлийн үнэлгээ хийсэн байх.

11.2. Хөтөлбөрийн үр дүнг тооцохдоо зан үйлийг өөрчлөх хосолмол-онолын загварыг ашиглан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж,

хөтөлбөрийн эхэн болон төгсгөлд үнэлсэн үнэлгээг харьцуулан гаргана. Зан үйл өөрчлөгдөх дараах 5 үе шатыг харгалзан үзнэ.

11.2.1. бодолгүй байх үе;

11.2.2. бодож эргэцүүлэх үе;

11.2.3. бэлтгэл үе;

11.2.4. үйлдэл хийх үе;

11.2.5. хэвших үе.

11.3. Оролцогчийн зан үйлд илрэн гарах үр дүн:

11.3.1. бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байх;

11.3.2. эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засч сайжруулахад чадварыг эзэмшсэн байх;

11.3.3. зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нэмэгдэх, эрсдэлгүй шинэ зан үйлд суралцах оновчтой шийдвэр гаргах, өөрийгөө дайчлан ажиллах чадварыг эзэмшсэн байх;

11.3.4. уур бухимдлаа хянах, бууруулах, зохистой илэрхийлэх арга замд суралцсан байна;

11.3.5. өөрийгөө бодитойгоор үнэлж, бусдад зөв зохистойгоор илэрхийлж сурах, өөртөө зөв хандаж, нийгмийн нөлөөлөл дунд биеэ зөв авч явах арга замд суралцсан байна.

11.4. Оролцогч нь зан үйлд нөлөөлөх сургалтад бүрэн хамрагдаж, гэр бүлийн хүчирхийлэлээс ангид байх ухамсар суусан байна.

11.5. Этгээд нь зан үйл нөлөөлөх албадан сургалтад бүрэн хамрагдсанаар сургалт дуусгавар болж, үр дүнд хүрсэн байна.

---oOo---



ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт /цаашид "албадан сургалт" гэх/-ыг зохион байгуулахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.2. Энэхүү журмаар хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээд /цаашид "оролцогч" гэх/-д албадан сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Албадан сургалт нь шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэсэн байна.

Хоёр. Албадан сургалтын зохион байгуулалт

2.1. Албадан сургалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д заасны дагуу хорих ял болон нийслэлд захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид "хорих анги, Баривчлах төв" гэх/, орон нутагт захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд Цагдаагийн байгууллага /цаашид "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж" гэх/ тус тус зохион байгуулна.

2.2. Сургалт хариуцсан ажилтан, багш /цаашид "сургалтын ажилтан" гэх/ шийтгэл хүлээсэн этгээдийн зөрчлийн шинж байдлаас хамаарч сургалтын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд хорих анги, Баривчлах төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийн дарга баталж, хяналт тавина.

2.3. Албадан сургалтын төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна.

2.3.1. сургалтын сэдэв;

2.3.2. сургалтын цаг;

2.3.3. сургалтын үргэлжлэх хугацаа;

2.3.4. сургалт явуулах багш.

2.4. Энэ журмын 2.1-д заасан байгууллага нь төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

Гурав. Албадан сургалтын төрөл, хугацаа

3.1. Албадан сургалт нь дараах төрөлтэй байна:

3.1.1. ганцаарчилсан;

3.1.2. бүлгийн;

3.1.1. бусад.

3.2. Албадан сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй, долоо хоногт 16 цагаас доошгүй байна.

Дөрөв. Албадан сургалтад тавигдах шаардлага

4.1. Албадан сургалт дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах танхимтай байх;

4.1.2. оролцогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх;

4.1.3. бясалгалын өрөөтэй байна.

4.2. Оролцогчийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлөөс хамаарч албадан сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулна.

Тав. Албадан сургалтад хамрагдах оролцогчийн эрх, үүрэг

5.1. Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах үүрэг хүлээнэ:

5.1.1. албадан сургалтын журмыг дагаж мөрдөх;

5.1.2. албадан сургалтын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, сургалтад бүрэн хамрагдах;

5.1.3. сургалтын ажилтан, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

5.1.4. сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах.

5.1.5. оролцогч дахин гэмт хэрэг, зөрчил гаргавал түүнээс үүдэн гарах үр дагавар, хор уршгийн талаар ойлголт эзэмшүүлсэн байх.

5.2. Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах эрх эдэлнэ:

5.2.1. сургалтын үргэлжлэх хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах;

5.2.2. сургалттай холбоотой ном, сэтгүүлийг авч ашиглах;

5.2.3. гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй этгээдийн хүсэлтээр хэлмэрч, орчуулагчийг оролцуулах;

Зургаа. Сургалтын ажилтны эрх, үүрэг

6.1. Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ:

- 6.1.1. сургалтад оролцогчдод хууль ёсны шаардлага тавих;
- 6.1.2. албадан сургалтад хамрагдаж буй этгээдийг үнэлж, дүгнэх;
- 6.1.3. аюулгүй байдлаа хангуулах.

6.2. Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:

- 6.2.1. сургалтыг хөтөлбөрийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах;
- 6.2.2. албадан сургалтад хамрагдсан оролцогчийн үнэлгээ, сургалт явуулсан тухай тайланг хорих анги, баривчлах төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийн даргад тус тус хүргүүлнэ;
- 6.2.3. албаны болон оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх;
- 6.2.4. оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх;
- 6.2.5. албадан сургалт дууссаны дараа оролцогчоос сургалтын талаарх санал авах;

Долоо. Байгууллагын эрх, үүрэг

7.1. Эрх бүхий байгууллага нь дараах эрх, үүрэг хүлээнэ:

- 7.1.1. сургалтын орчин бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах;
- 7.1.2. оролцогчдыг албадан сургалтад бүрэн хамруулах;
- 7.1.3. оролцогч нь энэ журмын 5.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол холбогдох арга хэмжээг авах;
- 7.1.4. сургалтын талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, сургалтын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ;
- 7.1.6. сургалтын талаар гадаад, дотоод байгууллагатай харилцах

Найм. Албадан сургалтад хамруулах

8.1. Эрх бүхий байгууллагын ажилтан /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч сургалтын ажилтан/ албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийг 24 цагийн дотор бүртгэлд хамруулж, түүнд сургалтад хамрагдах талаар танилцуулж, баталгаажуулна.

8.2. Энэ журмын 8.1-д заасан ажилтан албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийн сургалтад хамрагдаж буй байдал, түүний оролцоо, ирцийн талаар тэмдэглэл үйлдэнэ.

8.3. Албадан сургалтыг шүүхээс оногдуулсан шийтгэл, ялын хугацаанд багтаан явуулна.

8.4. Албадан сургалтад хамрагдах оролцогчийн талаарх бүртгэлийг нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, Баривчлах төв, аймаг, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллага хариуцан хөтөлнө.

Ес. Албадан сургалтад хамруулж дууссанд тооцох

9.1. Энэ журмын 8.1-д заасан ажилтан дараах үндэслэлээр албадан сургалтад хамруулж дууссанд тооцно:

- 9.1.1. шүүхээс тогтоосон цагийн албадан сургалтад хамрагдсан;
- 9.1.2. албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд нас барсан,
- 9.1.3. гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийтгэх тогтоол гарсан;

Арав. Хүлээлгэх хариуцлага

10.1. Албадан сургалтыг хэрэгжүүлж буй алба хаагч энэхүү журмыг зөрчсөн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд албан тушаалтны хууль ёсны шаардлага, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд /Захиргааны харицлагын тухай хууль/ заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.3. Энэ журмын 2.4-т заасан байгууллага, албан тушаалтан гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.

Арваннэг. Бусад

11.1. Албадан сургалтыг явуулах зардлыг "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр"-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу санхүүжүүлнэ.

11.2. Оролцогч сургалтын хэрэглэгдэхүүнийг эвдэж гэмтээсэн, хэвийн ажиллагааг алдагдуулсан тохиолдолд нөхөн төлүүлнэ.

---oOo---



2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/АЗ

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Холбон зуучлах үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Холбон зуучлах үйлчилгээний илгээх хуудас /Маягт 1/-ыг хоёрдугаар, "Холбон зуучлах үйлчилгээний хамтарсан төлөвлөгөө /Маягт 2/-ыг гуравдугаар, "Холбон зуучлах үйлчилгээний эргэн мэдээлэх хуудас /Маягт 3/-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/-д даалгасугай.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2017 оны А дугаар сарын 20-ны
өдрийн А/АЗ дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Холбон зуучлах үйлчилгээ гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд хүчирхийллийн улмаас учирсан, учирч болзошгүй хор уршиг, үр дагаврыг арилгах зорилгоор шаардлагатай хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа (цаашид үйлчилгээ гэнэ) үзүүлэх, холбогдох мэргэжилтэн, байгууллагатай холбож өгөх, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэх цогц үйл явцыг хэлнэ.

1.2. Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүд (цаашид хохирогч гэх)-ийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, үйлчилгээний явц, чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Энэ журам нь холбон зуучлах үйлчилгээний нийтлэг жишиг болж ашиглагдана.

1.4. Холбон зуучлах үйлчилгээний зорилго нь хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбож өгч, тэдний аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжихэд оршино.

1.5. Хохирогчтой эхэлж холбоо тогтоосон байгууллага, ажилтан нь холбон зуучлах үйлчилгээг төлөвлөх, холбогдох байгууллага болон мэргэжилтэнд шилжүүлэх, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэх зэргээр тухайн тохиолдол /кейс/ хаагдаж дуустал нь зохицуулалтыг бүрэн хийх үүрэг хүлээнэ.

1.6. Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.

Хоёр. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1. Аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хамгаална: Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

2.2. *Нууцлалыг чандлан хадгална:* Хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэнэ. Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбоотой мэдээллийг задруулахыг хориглоно.

2.3. *Хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангана:* Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх бүхий л үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрнө. Өөртэй нь хамаатай шийдвэр гаргах үйл явцад хохирогчийн оролцоог хангана.

2.4. *Ялгаварлан гадуурхахгүй байна:* Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байна.

Гурав. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үе шатууд

3.1. Холбон зуучлах үйлчилгээ нь дараах 4 үе шаттай байна.

3.1.1. хохирогчийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох;

3.1.2. хохирогчид хэрэгцээтэй үйлчилгээ, нөөц боломжийг судлах;

3.1.3. хохирогчийг хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгт холбох;

3.1.4. Үйлчилгээний чанарт хяналт тавих, эргэх холбоотой байх, үчлэх.

Дөрөв. Холбон зуучлагч байгууллага, ажилтны эрх, үүрэг

4.1. Хохирогчид хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлж чадах байгууллага, мэргэжилтний талаарх мэдээллийн санг бүрдүүлж, төрөлжүүлэн хөгжүүлж, байнга шинэчилнэ.

4.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т заасны дагуу хийсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилна.

4.3. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тухай мэдээллээр хохирогчийг хангаж, түүний санал, сонголтыг харгалзан үзнэ.

4.4. Холбон зуучлах байгууллага, ажилтантай урьдчилан холбогдож, хохирогчийн нөхцөл байдал, хэрэгцээг мэдээлж, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх боломжтой эсэхийг тодруулж, зөвшилцсөн байна.

4.5. Холбон зуучлагч байгууллага нь хүлээн авагч байгууллагадаа холбон зуучлах үйлчилгээний илгээх хуудас /Маягт 1/-ыг илгээх ба хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна.

4.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т заасны дагуу хийсэн цагдаагийн алба хаагчийн аюулын зэргийн үнэлгээ нь "дунд", "өндөр" тохиолдолд холбон зуучлагч байгууллага нь хохирогчийг аюулгүй унаагаар хүлээн авагч байгууллагад биечлэн хүргэнэ.

4.7. Холбон зуучлагч байгууллага нь хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхдийг аюулын зэргийн түвшнээс хамаарахгүйгээр аюулгүй унаагаар хүлээн авагч байгууллагад биечлэн хүргэнэ.

4.8. Хохирогчид холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхдээ хүчирхийлэл үйлдэгчээс ирэх эрсдлийг тооцоолж, аюулгүй байдлыг хангана.

4.9. Холбон зуучлагч болон хүлээн авагч байгууллага, ажилтнууд нь хохирогчид учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хамтарсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

4.10. Холбон зуучлах үйлчилгээний хамтарсан төлөвлөгөө /Маягт 2/-нд талуудын дангаар болон хамтдаа хүлээх үүрэг хариуцлага, гүйцэтгэх цаг хугацаа, хүлээж буй үр дүнг тодорхой тусгана. Үйлчилгээний төлөвлөгөөг хохирогчид танилцуулж, санал, хүсэлтийг тусгаж, оролцоог нь хангаж ажиллана.

4.11. Холбон зуучлагч байгууллага, ажилтан нь хүлээн авагч байгууллагатай эргэн холбогдож, хамтарсан төлөвлөгөөний хэрэгжилт, үйлчилгээний чанар, үйлчилгээ хоорондын холбоо, хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл солилцож, хяналт тавьж ажиллана.

4.12. Холбон зуучлах үйлчилгээний илгээх хуудас /Маягт 1/ болон холбон зуучлах үйлчилгээний хамтарсан төлөвлөгөө /Маягт 2/ нь харилцан уялдаатай ажиллах, үйлчилгээний чанарт хяналт тавих, үйлчилгээ хоорондын холбоо, явц, үр дүнг үнэлэхэд суурь баримт бичиг болж хөтлөгдөнө.

4.13. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж буй байгууллага, ажилтан нь хувь хүний нууц болон баримт, бичгийн нууцлалыг хангана.

4.14. Хохирогчийн нууцлалыг чандлан хадгалах үүднээс хохирогчийн хувийн хэрэгт код өгнө.

4.15. Байгууллага хооронд солигцож байгаа мэдээллийг мэдэх шаардлагын хүрээнд тухайн байгууллага, ажилтан зөвхөн өөрийн албан үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллийг авах, өгөхөөр хязгаарлан зохицуулна. Тухайлбал, эмнэлгийн байгууллагад хохирогчийг холбон зуучилсан бол зөвхөн хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн байдал нь ямар байгаа болон шаардлагатай оношилгоо, шинжилгээ, эмчилгээ зэрэг мэдээллийг өгнө.

4.16. Аюулын зэрэг өндөр гарснаас бусад тохиолдолд хохирогчийн зөвшөөрөлгүйгээр түүний талаарх хувийн мэдээллийг задлах эрхгүй. Холбон зуучлагч байгууллага нь аюулын зэрэг өндөр гарсан хохирогчийн хувийн мэдээллийг аль байгууллагад, ямар зорилгоор өгөх гэж байгаа талаар хохирогчид мэдэгдэж, зөвшөөрлийг нь бичгээр авна.

4.17. Байгууллага хооронд солигцож байгаа мэдээллийг мэдэх шаардлагын хүрээнд тухайн байгууллага, ажилтан зөвхөн өөрийн албан үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллийг авах, өгөхөөр хязгаарлан зохицуулна. Тухайлбал, эмнэлгийн байгууллагад хохирогчийг холбон зуучилсан бол зөвхөн хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн байдал нь ямар байгаа болон шаардлагатай оношилгоо, шинжилгээ, эмчилгээ зэрэг мэдээллийг өгнө. Хэрэв хүлээн авагч байгууллагад хохирогчийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол албан бичгээр хүргүүлнэ.

Тав. Хүлээн авагч байгууллагын эрх, үүрэг

5.1. Холбон зуучлагч байгууллагаас хохирогчийн илгээх хуудас /Маягт 1/-ыг бүрдүүлж, хүлээн авна. Үйлчилгээг дуусгавар болгохдоо холбон зуучлах үйлчилгээний эргэн мэдээлэх хуудас /Маягт 3/-ыг бөглөж, холбон зуучлагч байгууллагад хүргэнэ.

5.2. Хохирогчид тохиолдсон явдлыг олон дахин яриулж, хүчирхийллийн улмаас авсан сэтгэл зүйн гэмтэл, цочралыг дахин сэдрээхээс сэргийлэх зорилгоор холбон зуучилсан байгууллага, ажилтантай хамтран аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

5.3. Хүлээн авагч байгууллага, ажилтан нь хувь хүний нууц болон баримт бичгийн нууцлалыг хангана.

5.4. Холбон зуучлагч байгууллага нь аюулын зэрэг өндөр гарсан хохирогчийн хувийн мэдээллийг аль байгууллагад, ямар зорилгоор өгөх гэж байгаа талаар хохирогчид мэдэгдэж, зөвшөөрлийг нь бичгээр авна.

5.5. Хүлээн авагч байгууллага нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг холбон зуучлагчаас авна. Хохирогчийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол холбон зуучлагч байгууллагад албан бичгээр хандана.

5.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ хүчирхийлэл үйлдэгчээс ирэх эрсдлийг тооцоолж, аюулгүй байдлыг хангана.

5.7. Хоёр байгууллагын дунд хохирогчид шаардагдах үйлчилгээний хийдэл, давхцал гаргахгүй байх үүднээс холбон зуучлагч байгууллага, ажилтантай эргэн холбогдож, хамтарсан төлөвлөгөөний хэрэгжилт, үйлчилгээний явц, чанар, үр дүнгийн талаар мэдээлэл солилцоно.

5.8. Үйлчилгээний төрөл, хугацаанаас хамаарч үйлчилгээг дуусгавар болохоос өмнө хохирогч болон холбон зуучлагч байгууллага, ажилтанд урьдчилан мэдэгдэнэ.

5.9. Байгууллага, ажилтан нь холбон зуучлах үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

Зургаа. Хохирогчийн эрх

6.1. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан нь хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хангана.

6.2. Хохирогч өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож, санал өгөх эрхтэй.

6.3. Хохирогч нь үйлчилгээ үзүүлж буй байгууллага болон үйлчилгээний талаар мэдээллээр хангагдах эрхтэй.

6.4. Хохирогч нь холбон зуучлах болон хүлээн авагч байгууллагын хамтарсан төлөвлөгөөтэй танилцаж, саналаа хэлэх, сонголт хийх эрхтэй.

6.5. Хохирогч нь өөрт хамааралтай мэдээллийг аль байгууллагад ямар зорилгоор дамжуулах гэж байгаа талаар мэдэх, зөвшөөрлийг бичгээр өгөх эрхтэй.

6.6. Хохирогч нь байгууллага, ажилтны гаргасан шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

Долоо. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд хориглох зүйл

7.1. Хохирогчтой эхэлж холбоо тогтоосон байгууллага, мэргэжилтэн нь байгууллагынхаа үндсэн чиглэл болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад хуулиар хүлээсэн үүргийн дагуу үзүүлэх үйлчилгээгээ эхлээгүй, эсхүл дуусгалгүйгээр бусад байгууллага, мэргэжилтэнд холбон зуучлахыг хориглоно.

7.2. Үйлчилгээ үзүүлж буй ажилтан нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

7.3. Хувь хүний нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиролдолд хохирогчийн нууцыг ил болгохыг хориглоно.

---OO---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 04 дугаар сарын 20 ны өдрийн
А/Б/В дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛГЭЭХ ХУУДАС
МАЯГТ 1



Огноо: 20 __ он __ сар __ өдөр

НЭГ. ХОЛБОН ЗУУЧИЛСАН БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

1	Байгууллагын нэр, хаяг:	
2	Ажилтны овог нэр:	
3	Албан тушаал:	
4	Утасны дугаар:	
5	И-мэйл хаяг:	
6	Хүлээлгэж өгсөн бичиг баримт, бусад эд зүйл:	

ХОЁР. ХҮЛЭЭН АВАГЧ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Байгууллагын нэр, хаяг:	
3	Албан тушаал:	
4	Утасны дугаар:	
5	И-мэйл хаяг:	
6	Хүлээн авсан бичиг баримт, бусад эд зүйл:	

ГУРАВ. ХОХИРОГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ:

1	Кейсийн код (Холбон зуучлагч байгууллагын)	
2	Овог нэр:	

Холбон зуучигсан болон хүлээн авагч байгууллага хооронд мэдээлэл солилцох арга хэлбэр, давтамж

Кейс зөвлөгөөн хийх хугацаа

Оролцогчид

Холбон зуучлагч талаас

Хүлээн авагч талаас

Хамтарсан төлөвлөгөөг үнэлэх арга хэлбэр

Холбон зуучлагч

Хүлээн авагч

Овог, нэр

Овог, нэр

Овог, нэр

Гарын үсэг

Гарын үсэг

Гарын үсэг

(Тамга, тэмдэг)


(Тамга, тэмдэг)

Огноо

Огноо

Огноо

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн
4/27 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРГЭН МЭДЭЭЛЭХ ХУУДАС

МАЯГТ 3

Огноо: 20__ он __ сар __ өдөр

Кейсийн код:

Хохирогчийн овог, нэр:

1	Хүлээн авагч байгууллагын зүгээс үзүүлсэн үйлчилгээний тэмдэглэгээ:
2	Үйлчилгээ үзүүлсний дараах нөхцөл байдал:
3	Цаашид авах арга хэмжээ:

4	Бусад зөвлөмж / тайлбар:

Холбон зуучилсан:

Овог, нэр:

Гарын үсэг:

(Тамга, тэмдэг)

Огноо:

20 _он _сар _өдөр _цаг _минут

Хүлээн авсан:

Овог, нэр:

Гарын үсэг:

(Тамга, тэмдэг)

Огноо:

20 _он _сар _өдөр _цаг _минут

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар А/56 А/35

Улаанбаатар
хот


Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. "Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам"-ыг нэгдүгээр, "Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын бүртгэлийн маяг"-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /Тэргүүн комиссар Ө.Энхтөр/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/ нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар /С.Тунганагтамир/ нарт тус тус даалгасугай.



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Н.НОМТОЙБАЯР



ХОХИРОГЧИЙГ ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ УУЛЗУУЛАХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, болон 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу аюулгүй байдлын болон түр хамгаалалтад байгаа хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах харилцааг зохицуулна.

1.2.Аюулгүй байдлын болон түр хамгаалалтад байгаа хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүд нь хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах талаарх хүсэлт, зөвшөөрлийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-43.4 дэх хэсэгт заасны дагуу гарган шийдвэрлэнэ.

Хоёр.Уулзалт зохион байгуулах

2.1.Уулзалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу баг, хороо, сумын нийгмийн ажилтан зохион байгуулж, аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна.

2.2.Уулзалтын зөвшөөрлийг бичгээр үйлдэж, хамтарсан багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан, үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт хавсаргана.

2.3.Хамтарсан баг нь уулзалт болох газар, хугацааг товлож, хохирогч болон түр хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, хүчирхийлэл үйлдэгчид ажлын 1-2 хоногийн өмнө мэдэгдэнэ.

2.4.Уулзалт зохион байгуулсан, оролцсон ажилтнууд уулзалтын талаархи мэдээллийн нууцлалыг хамгаална.

2.5.Уулзалтад оролцож байгаа оролцогчид эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

2.6.Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах нэг удаагийн уулзалтын хугацааг 60 минутаас хэтрүүлэхгүй байхаар зохион байгуулна.

2.7.Уулзалтыг хохирогчид түр хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, газраас бусад холбогдох байгууллагад зохион байгуулна.

2.8.Уулзалтыг зохион байгуулж байгаа байр нь дуу чимээнээс тусгаарласан, камерын хяналттай, оролцогчийн аюулгүй байдлыг хангасан байна.

2.9.Шаардлагатай гэж үзвэл уулзалтын үеийн аюулгүй байдлын хяналтыг цагдаагийн ажилтан биечлэн хэрэгжүүлж болно.

2.10.Хяналтын камерын болон дууны бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаанд уулзалтын аюулгүй байдлыг хариуцсан цагдаагийн байгууллага

хадгалж, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад мэдээллийг саадгүй гаргаж өгнө.

2.11.Уулзалт зохион байгуулсан ажилтан хавсралтаар баталсан "Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын бүртгэлийн маяг"-ын дагуу бүртгэл хөтөлж хамтарсан баг, түр хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад хүргүүлнэ.

2.12.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д заасан тохиолдолд хохирогч, түүний хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулахыг хориглох бөгөөд энэ талаар тэмдэглэлд тусгана.

2.13.Хүчирхийлэл үйлдэгч нь согтуурсан буюу мансуурсан байдалтай тохиолдолд уулзалтыг зохион байгуулахаас татгалзана.

2.14 Уулзалтын явцад дараахь нөхцөл байдал үүсвэл шууд зогсоно.

2.14.1.Уулзалтын эхлэл болон явцад хохирогч уулзалтыг цааш үргэлжүүлэхээс татгалзсан;

2.14.2.Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлсэн;

2.14.3.Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар тулган шаардсан;

2.14.4.Хүчирхийлэл үйлдэгч уулзалт зохион байгуулж байгаа ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан бол.

2.15.Уулзалтад оролцох хохирогч болон хүчирхийлэгч үйлдэгчийн биед цагдаагийн алба хаагч үзлэг хийж, сэжигтэй зүйл илэрвэл нэвтрүүлэхээс татгалзаж тэмдэглэлд тусгана.

2.16.Хохирогчийг уулзалт зохион байгуулах байранд хүргэх, буцаах үеийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцна.

---oOo---



Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2017 оны 03 сарын 13 ны өдрийн А.С. А.Б.С. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ХОХИРОГЧИЙГ ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ
УУЛЗУУЛАХ УУЛЗАЛТЫН БҮРТГЭЛ**

Уулзалт зохион байгуулж байгууллага	байгууллага, газар, хэлтсийн албан тушаалтай, овогтой
Уулзалт эхэлсэн огноо, газарон.....сар.....өдөр.....цаг..... минут аймаг, дүүрэг
Хүчирхийллийн хохирогч овог нэр регистр нас хүйс
Хүчирхийлэл үйлдэгч овог нэр регистр нас хүйс
Уулзалтыг зөвшөөрсөн албан тушаалтан нэр хаяг:
Зөвшөөрлийн хуудасны дугаар
Уулзалтын тэмдэглэл (уулзалтын явц, нөхцөл байдлын талаар тусгана.)	
.....	
.....	
.....	
.....	
Хяналт тавьсан цагдаагийн алба хаагч	байгууллага, газар, хэлтсийн цолтой, албан тушаалтай, овогтой
Уулзалтад байлцсан нийгмийн ажилтан	байгууллага, газар, хэлтсийн албан тушаалтай, овогтой /гарын үсэг/
Уулзалтад байлцсан бусад хүн
Уулзалт дууссан цагон.....сар.....өдөр.....цаг..... минут
Уулзалтын тэмдэглэл хөтлөсөн ажилтан нэр /гарын үсэг/

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/63 / А/48 / А/106

Улаанбаатар хот

Хөтөлбөр, журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга /Д.Ганцэцэг/ нарт үүрэг болгосугай.





ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ САЙН ДУРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг тус тус удирдлага болгон сургалтын хөтөлбөр боловсруулав.

1.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, сургалт" /цаашид "сайн дурын сургалт" гэх/-д өөрийн хүсэл сонирхлын дагуу хамрагдахыг хүссэн хүн /цаашид "оролцогч" гэх/-д тодорхой хугацаанд сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг явуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно.

1.3. Сайн дурын сургалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасан төрийн бус байгууллага /цаашид "сургалтын байгууллага" гэх/ хариуцаж явуулна.

1.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн дарга нь сайн дурын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

2.1. Энэхүү хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага нь гэр бүлийн таатай уур амьсгалыг бүрдүүлэх, тэднийг гэрлэлтээ цуцлуулахаас сэргийлэх оролцогчийн зан үйл, хандлагад нөлөөлөл үзүүлэх байдлаар хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлж, иргэний үүргээ биелүүлэх ухамсартай болох, нийгэмд хариуцлагатай иргэн болж төлөвших, тэдэнд туслах чиг үүргийг хэрэгжүүлэх явдал юм.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Оролцогчийг гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүй, амьдрах ухааны боловсрол олгох, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө удирдан жолоодож тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Сургалтын хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1.1. оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын төлөвлөгөөг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай хамтран боловсруулах;

4.1.2. заасан хугацаанд сургалт явуулах;

4.1.3. сайн дурын сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.4. сургалт явуулах ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулах;

4.1.5. сургалт явуулах ажилтны ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтыг тухайн байгууллага тасралтгүй зохион байгуулж тогтмолжуулах;

4.1.6. оролцогчдод сэтгэл зүйн болон амьдрах ухааны боловсрол олгон зөв бодол санааг төлөвшүүлж, өөрийгөө удирдан жолоодох чадвартай, эерэг сэтгэлгээтэй болгох;

4.1.7. оролцогчийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, амьдралын эрүүл хэв маяг, хэм хэмжээг төлөвшүүлэх;

4.1.8. сургалтын явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг энэ хөтөлбөрийн 1.3-т заасан сургалтын байгууллага нь хариуцан зохион байгуулна.

5.2. Сургалтыг явуулж буй байгууллага, ажилтан нь оролцогчийг сургах, хөгжүүлэх, чадвар суулгах нөхцөлийг ханган дэмжлэг үзүүлэх, өөрсдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтад идэвхтэй оролцуулах үүргийг тус тус гүйцэтгэнэ.

5.3. Сургалт хариуцсан ажилтан сургалтад сайн дураар хамрагдах хүсэлт гаргасан хүнтэй сайн дурын сургалтын гэрээ байгуулж, түүнд танилцуулж, тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон түүнд нөлөөлөхүйц сургалтын төлөвлөгөөг боловсруулна.

5.4. Сайн дурын сургалтын төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна:

5.4.1. сургалтын сэдэв;

5.4.2. сургалтын цаг;

5.4.3. сургалтын үргэлжлэх хугацаа;

5.4.4. сургалт явуулах багш.

Зургаа. Сургалтад баримтлах зарчим

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчим, чиглэлийг баримтлана:

6.1.1. хууль дээдлэх;

6.1.2. хувь хүнийг хүндэтгэх;

6.1.3. нууц хадгалах;

6.1.4. хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний оролцоог хангах;

6.1.5. сургалт явуулахад эрүүл ахуйн шаардлага хангасан, таатай орчинг бүрдүүлэх.

Долоо. Сургалтын хэлбэр, хэрэглэгдэхүүн

7.1. Сургалтын хэлбэр

7.1.1. ганцаарчилсан сургалт;

7.1.2. бүлгийн сургалт;

7.1.3. бусад.

7.2. Сургалтыг дараах хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг ашиглан зохион явуулна:

7.2.1. компьютер;

7.2.2. проектор;

7.2.3. ном, гарын авлага, бусад материал;

7.2.4. хөгжим, дүрс бичлэг.

Найм. Сургалтын төрөл, сэдэв

8.1. Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрлүүдтэй байж болно:

8.1.1. Сэтгэл зүйн сургалт;

8.1.1.а. архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар;

8.1.1.б. хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах;

8.1.1.в. уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;

8.1.1.г. харилцах ур чадвараа дээшлүүлэх;

8.1.1.д. бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;

8.1.1.е. өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;

8.1.1.е. хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал, сөрөг үр дагавар;

8.1.1.ж. гэр бүлийн сэтгэл зүй;

8.1.1. з. гэр бүл төлөвлөлт;

8.1.1 и. бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын талаар.

8.2. Эрх зүйн сургалт.

8.2.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль;

8.2.2. Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль

8.2.3. шаардлагатай гэж үзсэн бусад хууль.

8.3. Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан зохион явуулна.

Ес. Хөтөлбөрт тусгагдсан сургалтын хугацаа

9.1. Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сэтгэл зүйн сургалтын цаг харилцан адилгүй байна.

9.2. Сургалтын үргэлжлэх хугацаа:

д/д	Сургалтын сэдэв	Хичээлийн цаг /60 минут/
1.	Сэтгэл зүйн сургалт	16-41
	- архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар	
	- хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах	
	- уур бухимдлыг хэрхэн зохицуулах	
	- харилцах ур чадвараа дээшлүүлэх	
	- бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх	
	- өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	
	- хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүй	
	- гэр бүлийн сэтгэл зүй	
	- гэр бүл төлөвлөлт	
	- бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын талаар	
2.	Эрх зүйн сургалт	5-10
	- Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль;	
	- Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль	
Сургалтын нийт цаг		21-51 цаг

9.3. Нэг удаагийн ганцаарчилсан болон бүлгийн сайн дурын сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй байна.

Арав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцохын тулд оролцогчид нөхцөл байдлын үнэлгээг сургалтын эхэнд болон хөтөлбөрийн төгсгөлд үнэлгээ хийсэн байна.

10.2. Хөтөлбөрийн үр дүнг тооцохдоо зан үйлийг өөрчлөх хосолмол-онолын загварыг ашиглан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж, хөтөлбөрийн эхэнд болон төгсгөлд үнэлсэн үнэлгээг харьцуулан зан үйл өөрчлөгдөх дараах 5 үе шатыг харгалзан үзнэ:

- 10.2.1. бодолгүй байх үе;
- 10.2.2. бодож эргэцүүлэх үе;
- 10.2.3. бэлтгэл үе;
- 10.2.4. үйлдэл хийх үе;
- 10.2.5. хэвших үе.

10.3. Оролцогчид гарах үр дүн:

10.3.1. бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байна;

10.3.2. эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засаж сайжруулах талаар хэрэгцээтэй чадваруудыг тодорхой хэмжээгээр хөгжүүлсэн байна;

10.3.3. зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нэмэгдэх, эрсдэлгүй шинэ зан үйлд суралцах оновчтой шийдвэр гаргах, өөрийгөө дайчлан ажиллах чадваруудыг эзэмшсэн байна;

10.3.4. уур бухимдлаа хянах, бууруулах, зохистой илэрхийлэх арга замд суралцсан байна;

10.3.5. өөрийгөө бодитойгоор үнэлж, бусдад зөв зохистойгоор илэрхийлж сурах, өөртөө зөв хандаж, нийгмийн нөлөөлөл дунд биеэ зөв авч явах арга замд суралцсан байна.

10.4. Оролцогч зан үйлд нөлөөлөх сургалтад бүрэн хамрагдсанаар сургалт дуусгавар болно.

---oOo---



1.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь өөрийн хүсэл сонирхлын дагуу зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад хамрагдах хүсэлтээ төрийн болон төрийн бус байгууллагад гаргавал энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт /цаашид "сайн дурын сургалт" гэх/ нь сайн дурын оролцогч /цаашид "оролцогч" гэх/-ийн зан үйлд нөлөөлөх, гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэж шийдвэрлэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэгдсэн байна.

Хоёр. Сайн дурын сургалтад тавигдах шаардлага

2.1. Сайн дурын сургалт дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

2.1.2. ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах тохилог орчин бүхий танхимтай байх;

2.1.3. сургалтад ашиглагдах ном, сурах бичгийн сантай байх;

2.1.4. оролцогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх.

Гурав. Сайн дурын сургалтын оролцогчийн эрх, үүрэг

3.1. Сайн дурын сургалтын оролцогч дараах үүрэг хүлээнэ:

3.1.1. сургалт хариуцсан ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

3.1.2. сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах.

3.2. Сайн дурын сургалтын оролцогч дараах эрх эдэлнэ:

3.2.1. сургалтын үргэлжлэх хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах;

3.2.2. сургалттай холбоотой ном, сэтгүүлийг өөрийн зардлаар авч ашиглах;

3.2.3. гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй этгээд өөрийн хүсэлтээр сургалтад хэлмэрч, орчуулагч оролцуулах.

Дөрөв. Сургалтын ажилтны эрх, үүрэг

4.1. Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ:

4.1.1. сургалтын хүрээнд оролцогчдод хууль ёсны шаардлага тавих;

4.1.2. оролцогчийн талаарх нөхцөл байдлын үнэлгээ хийх.

4.6.2. Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:

4.2.1. сургалтыг хөтөлбөрийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах;

4.2.2. оролцогчид сургалтыг бүрэн эзэмшүүлсэн байх;

4.2.3. оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх.

Тав. Сургалтын явц

5.1. Сайн дурын сургалтын явцад сургалтын ажилтан дараах үйл ажиллагааг явуулна:

5.1.1. хичээлийн явц, цаг, сэдвийн талаар тэмдэглэж баталгаажуулах;

5.1.2. оролцогчоор сайн дурын сургалтад хамрагдсан тухай гарын үсэг зуруулж баталгаажуулна.

5.2. Сургалтын ажилтан үр дүнг үнэлж болно.

Зургаа. Бусад

6.1. Сайн дурын сургалтыг явуулахад шаардагдах зардлыг оролцогч өөрөө бүрэн хариуцан гаргана.

6.2. Оролцогч сургалтын хэрэглэгдэхүүнийг эвдэж гэмтээсэн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан тохиолдолд нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

6.3. Оролцогч сайн дурын сургалтын явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа тасалсан бол албадан сургалтад хамрагдах үндэслэл болно.

---oOo---

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/80.1 А/.....1 А/60
132

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх эмнэлэг, төрийн болон төрийн бус байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга /Д.Ганцэцэг/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/ нарт тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 308/189/123 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД
А.ЦОГЦЭЦЭГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Н.НОМТОЙБАЯР



НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журмаар Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэн /цаашид "хохирогч" гэх/-д Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй /цаашид "нэг цэгийн үйлчилгээ" гэх/ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль болон энэхүү журмыг баримтална.

1.3.Нэг цэгийн үйлчилгээний төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.хохирогчийн аюулгүй байдлыг хангах;
- 1.3.2. хохирогчийг ялгаварлан гадуурхахгүй байх;
- 1.3.3.хохирогч төвтэй, эрхэд суурилсан үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх;
- 1.3.4.хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нэн тэргүүн ээлжинд үйлчилгээ үзүүлэх;
- 1.3.5.нууцыг хадгалах;
- 1.3.6.хохирогчийн хүсэл сонирхол, хүний эрх, нэр төрийг болон хүүхдийн эрх ашгийг дээдлэн хүндэтгэх.

Хоёр.Удирдлага, зохион байгуулалт

2.1.Нэг цэгийн үйлчилгээний төв нь эмнэлэг, төр, төрийн бус байгууллагын харьяанд ажиллана.

2.2.Нэг цэгийн үйлчилгээний төв нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс шуурхай, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлнэ.

2.3.Нэг цэгийн үйлчилгээний төвд нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулна. Бусад ажилтнуудын энэхүү журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, хамтран ажиллах боломжийг холбогдох байгууллагын удирдлага хариуцна.

2.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан, эрх зүйч болон эрүүл мэндийн ажилтан нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн эрсдэл бүхий хохирогчид богино хугацаанд шаардлагатай үйлчилгээг үзүүлж, дунд болон урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучилна.

2.5.Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн эрсдэл бүхий хохирогчид зөвлөгөө өгөх, орон нутгийн эрүүл мэнд, цагдаа, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагуудтай гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллана.

2.6.Хохирогчид сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ, яаралтай мэс засал, төрөлжсөн мэргэшлийн үзлэг, шинжилгээ, оношлогоо хийлгэх шаардлагатай гэж үзвэл нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан хохирогчийг холбогдох эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.

2.7.Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан албан үүрэгтэйгээ холбоотойгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар олж мэдсэн бол цагдаагийн байгууллагад мэдээлж, таслан зогсоох арга хэмжээг яаралтай авна.

2.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Гурав.Үйлчилгээний төрөл

3.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу нэг цэгийн үйлчилгээний төв нь хохирогчид дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 3.1.1.аюулгүй байдлын хамгаалалт;
- 3.1.2.эмнэлгийн тусламж үйлчилгээ;
- 3.1.3.сэтгэл зүйн үйлчилгээ;
- 3.1.4.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 3.1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээ;
- 3.1.6.эрх зүйн туслацгаа;
- 3.1.7.холбон зуучлах үйлчилгээ.

3.2.Энэ журмын 3.1-д заасан үйлчилгээ үзүүлэх ажилд эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйчээс гадна цагдаагийн ажилтан, эрх зүйч, шүүхийн шинжээч, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, төвийн мэргэжилтнүүд болон шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг татан оролцуулна

Дөрөв.Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудын эрх, үүрэг

4.1.Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаас гадна доор дурдсан үүрэгтэй:

4.1.1. хохирогчийг хүлээн авч бүртгэх, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатны үйл ажиллагааг зохион байгуулах;

4.1.2. нэг цэгийн үйлчилгээний төв болон салбар хоорондын уялдааг хангаж зохицуулах;

4.1.3. хохирогчийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах;

4.1.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд, өндөр настанд тусгайлсан туслалцаа үзүүлэх;

4.1.5. шаардлагатай тохиолдолд хохирогчийг нэг цэгийн үйлчилгээнээс хамгаалах байранд шилжүүлэх арга хэмжээ авах;

4.1.6. тухайн байгууллагын мэргэжилтнүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, мэдээлэх арга зүйгээр хангаж, энэ чиглэлээр сургалт сурталчилгааг зохион байгуулах;

4.1.7. хохирогчийн хувийн хэргийг хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах.

4.2. Эрүүл мэндийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаас гадна доор дурдсан үүрэгтэй:

4.2.1. хохирогчид үзлэг хийж, анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

4.2.2. хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хариуцан зохион байгуулж ажиллах;

4.2.3. хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, мэргэжлийн дүгнэлт гаргах;

4.2.4. шаардлагатай тохиолдолд хохирогчийг төрөлжсөн мэргэшлийн эмчид илгээж, эргэх холбоог ханган ажиллах;

4.2.5. нийгмийн ажилтантай хамтран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

4.2.6. осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

4.2.7. хохирогчийн бэртэл, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулахаар хүргүүлэх, нэгдсэн тайлан мэдээ гаргах.

4.3. Сэтгэл зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан сэтгэл зүйн үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлэхээс гадна доор дурдсан үүрэгтэй:

4.3.1. хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх бүхий л үе шатанд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

4.3.2. сэтгэл зүйн үйлчилгээний журмын дагуу хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

4.3.3. цагдаа, хуулийн байгууллагын мэдүүлэг, байцаалт, эмчийн үзлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд сэтгэл зүйг бэлдэх;

4.3.4. хохирогчийн сэтгэл зүйн байдлын талаар дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.3.5. хохирогчийн сэтгэл зүйн байдлыг судлан тогтоож, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн сэтгэл заслын эмчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах;

4.3.6. тухайн байгууллагын мэргэжилтнүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн онцлог, сэтгэл зүйн байдлыг харгалзан үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангаж, энэ чиглэлээр сургалт сурталчилгааг зохион байгуулах;

4.3.7. хохирогчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний тэмдэглэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах.

4.4. Эрх зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан эрх зүйн туслалцааг зохих журмын дагуу үзүүлэхээс гадна доор дурдсан үүрэгтэй:

4.4.1. хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд эрх зүйн зөвлөгөө үзүүлэх;

4.4.2. хохирогч гомдол, мэдээллээ биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан гаргахад туслах;

4.4.3. шаардлагатай тохиолдолд хохирогчийн хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах, өмгөөллийн болон бусад үйлчилгээнд холбон зуучлах;

4.4.4. хүчирхийлэлд өртсөн болон өртөж байсан талаарх нотлох баримтыг бүрдүүлэх, өргөдөл, гомдол, нэхэмжлэлийг холбогдох хуулийн байгууллагад гаргахад арга зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлэх;

4.4.5. хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллах;

4.4.6. тухайн байгууллагын мэргэжилтнүүдэд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр сургалт сурталчилгааг зохион байгуулах;

4.4.7. хохирогчид эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн тухай бүртгэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах.

4.5. Цагдаагийн алба хаагч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаас гадна доор дурдсан үүрэгтэй:

4.5.1. нэг цэгийн үйлчилгээнд дуудлагаар ажиллаж, хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийх;

4.5.2. хохирогчийг нэг цэгийн үйлчилгээнээс хамгаалах байранд шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах;

4.5.3. гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, явц, нөхцөл байдал болон хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг хохирогчид танилцуулж, тайлбарлан өгөх;

4.5.4. хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмчилгээний хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл, шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулах;

4.5.5. хохирогч, тухайн гэр бүлийн хүчирхийллийн талаарх холбоотой мэдээ, баримтыг нэг цэгийн үйлчилгээнд нэгтгэж, хамтран ажиллах.

Тав.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

- 5.1.Хохирогч нь нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхдээ дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
- 5.1.1.нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй үйлчлүүлэх;
 - 5.1.2.анхан шатны болон яаралтай эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах;
 - 5.1.3.өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож, саналаа өгөх;
 - 5.1.4.хувийн нууцаа хамгаалуулах;
 - 5.1.5.төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөгөө авч, шаардлагатай бол шүүх эмнэлгээр холбогдох журмын дагуу гэмтлийн зэргээ тодорхойлуулах, шинжилгээ хийлгэх;
 - 5.1.6.хүчирхийлэлд өртөж, үйлчилгээ авсан талаараа лавлагаа, мэдээлэл авах;
 - 5.1.7.нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээний талаар санал, гомдол гаргах;
 - 5.1.8.өөрийн болон үйлчлүүлж байх хугацаандаа олж мэдсэн бусад хүний нууцыг хангах;
 - 5.1.9.хохирогч нь нэг цэгийн үйлчилгээний төвийн дотоод журмыг мөрдөж, ажилтнуудад хүндэтгэлтэй хандах.

Зургаа.Санхүүжилт

- 6.1.Нэг цэгийн үйлчилгээ нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх ба зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 6.2.Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.3-д заасан хугацаанд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ.
- 6.3.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь энэ журмын 6.2-т заасан тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.
- 6.4.Төрөлжсөн нэг цэгийн үйлчилгээний төвийн (Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн Шинжилгээний хэлтсийг түшиглэн нэг цэгийн үйлчилгээний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төв гэх мэт) үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.
- 6.5.Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасны дагуу тооцож, санхүүжүүлнэ.
- 6.5.Нэг цэгийн үйлчилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж болно.

Долоо.Тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ

- 7.1.Нэг цэгийн үйлчилгээний төв нь үйл ажиллагааны болон санхүүгийн нэгдсэн тайланг хагас болон бүтэн жилээр гаргаж, тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.
- 7.2. Засаг дарга нь энэхүү журмын 7.1-д заасан тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ.
- 7.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь энэхүү журмын 7.2-т заасан тайланг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.
- 7.4.Шаардлагатай тохиолдолд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангана.
- 7.5.Төрөлжсөн нэг цэгийн үйлчилгээний төв нь үйл ажиллагааны болон санхүүгийн нэгдсэн тайланг улирал тутамд гаргаж, харьяаллаас хамаарч хууль зүй, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 7.6.Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тогтмол хяналт тавьж ажиллана.
- 7.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь шаардлагатай тохиолдолд нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

--- оОо ---

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/59 А/130

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-г тус тус үүрэг болгосугай.

3. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нарт тус тус даалгасугай.



Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2017 оны
А/59 А/130 дугаар хамтарсан тушаалын
хавсралт

ХОХИРОГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гарган магадлан итгэмжлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргагчийн сайн дурын үндсэн дээр явагдах ба нээлттэй, ил тод, тэгш байдал, шударга ёсны зарчимд нийцсэн байна.

1.3.Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад эрхийн акт болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.4.Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны удирдлага нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, цагдаа, хүүхдийн байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий магадлан итгэмжлэх орон тооны бус комисс /цаашид "комисс" гэх/ байна. Комиссын бүрэлдхүүнийг хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.5.Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллага нь Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жишгийн дагуу үйлчилгээний хөлс төлнө.

1.6.Хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэхэд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/330 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам"-ын холбогдох заалтыг нийцүүлэн хэрэглэж болно.

Хоёр. Комиссын чиг үүрэг

2.1. Комисс нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг батлах;

2.1.2. шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцэн, магадлан итгэмжлэх, эсэх тухай шийдвэр гаргах;

2.2. Комисс хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

Гурав. Магадлан итгэмжлэх байгууллага.

3.1. Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /"цаашид магадлан итгэмжлэх байгууллага" гэх/ хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.

3.2. Магадлан итгэмжлэх байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиг үүргийг хууль зүй, дотоод хэргийн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.2.2. магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах, магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох тухай комиссын шийдвэрийг үндэслэн батламж олгох, батламжийг хүчингүй болгох;

3.2.3. магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг хүлээн авах, хүсэлт гаргасан төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх, шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийх талаар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

3.2.4. магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал боловсруулах, магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажил, магадлан итгэмжлэгдсэн байгууллагад явцын үнэлгээ хийх зэрэгт мэргэжлийн нийгэмлэг, холбоод, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээгээр гүйцэтгүүлэх;

3.2.5. хууль зүй, хүүхэд, гэр бүл, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан мэргэжилтнүүдээс магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээч сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах, сургах;

3.2.6. хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагад шинжээчдийн багийг томилон ажиллуулах;

3.2.7. магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн халамжийн хэлтэс нь харъяалах нутаг дэвсгэртээ хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж

буй төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хууль зүйн хэлтэс, эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулах;

3.3.2. төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх болон магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргахад материал бүрдүүлэлтэд зөвлөгөө өгөх, хүсэлтийг хүлээн авч магадлан итгэмжлэх байгууллагад хүргүүлэх;

3.3.3. магадлан итгэмжлэлийн үнэлгээнд оролцох;

3.3.4. магадлан итгэмжлэгдсэн байгууллагад дунд хугацааны үнэлгээ хийж, комисст тайлагнах;

3.3.5. магадлан итгэмжлэгдсэн байгууллагын үйлчилгээний чанарын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулахад арга зүйн зөвлөлгөө өгөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;

3.3.6. магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх;

Дөрөв. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат

4.1. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь дараахь үе шаттай явагдана. Үүнд:

4.1.1. Төрийн бус байгууллага магадлан итгэмжлэлд бэлтгэж, өөрийн үнэлгээ хийх;

4.1.2. Төрийн бус байгууллагын ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийх;

4.1.3. Шинжээчдийн баг газар дээр нь үнэлгээ хийх;

4.1.4. Шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг комиссын хурлаар хэлэлцэж, төрийн бус байгууллагад магадлан итгэмжлэл олгох эсэх шийдвэр гаргах;

4.2. Төрийн бус байгууллага нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргахаас өмнө дараах бэлтгэлийг хангасан байна. Үүнд:

4.2.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагаа болон материал бүрдүүлэлтийн талаар мэдээлэл авах;

4.2.2. магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээ хийх;

4.2.3. бэлтгэл ажилд арга зүйн зөвлөлгөө авах, шалгуур үзүүлэлтээр үнэлэх аргачлалын сургалтад хамрагдах;

4.2.4. магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

Тав. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах

5.1. Энэ журмын 3.2-т заасан бэлтгэл ажлыг хангасан төрийн бус байгууллага Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргана. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага нь тухайн аймгийн нийгмийн халамжийн хэлтсээр уламжлан хүсэлтээ гаргаж болно.

5.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах байгууллага нь дараахь материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 5.2.1. магадлан итгэмжлэлд хамрагдах тухай албан хүсэлт;
- 5.2.2. төрийн бус байгууллагын гэрчилгээ, дүрмийн хуулбар;
- 5.2.3. магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлбар;
- 5.2.4. хохирогчид үзүүлэх үйлчилгээний жагсаалт, төрийн бус байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө, өмнө хэрэгжүүлсэн ажлын тайлан;
- 5.2.5. бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт;
- 5.2.6. магадлан итгэмжлүүлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт;

5.3. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй өдрийн өмнө дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах ба хүсэлтэд энэ журмын 4.2-т заасан материалаас гадна хугацаа дуусаж байгаа магадлан итгэмжлэлийн хуулбарыг хавсаргана.

Зургаа. Магадлан итгэмжлэх

6.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь төрийн бус байгууллагаас хүсэлт хүлээн авснаас хойш хуанлийн 20 өдрийн дотор ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийж, хариу мэдэгдэнэ.

6.2. Ирүүлсэн материал шаардлага хангасан бол магадлан итгэмжлэх товыг гаргаж, хүсэлт гаргасан байгууллагад 3-5 хүний бүрэлдхүүнтэй шинжээчдийн баг томилж ажиллуулна. Хэрэв материал шаардлага хангаагүй бол тухайн байгууллагад буцаана.

6.3. Томилогдсон шинжээчдийн баг төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлантай танилцаж, тухайн байгууллагын үйлчилгээний хүрээнээс хамааран ажлын 1-2 өдөр газар дээр нь үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

6.4. Шинжээчдийн баг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт тус бүрээр 100 хүртэл оноо өгөх ба оноо нь шалгуурыг хангасан хувийг илэрхийлнэ.

6.5. Шинжээчдийн баг магадлан итгэмжлэх эсэх тухай нэгдсэн дүгнэлтийг "магадлан итгэмжлэх шалгуурыг хангасан", "магадлан итгэмжлэх шалгуурыг хангаагүй" гэсэн хувилбарын аль нэгээр гаргаж, үндэслэлийг нарийн тодорхойлсон байна.

6.6. Шинжээчдийн багийн үнэлгээний нэгдсэн дүгнэлтэд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан тухайн байгууллага хамт олонд танилцуулж, зөвлөмж өгнө.

6.7. Шинжээчдийн багийн ахлагч нь магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан үнэлгээний тайлан, дүгнэлт, үнэлгээтэй холбоотой бусад баримт материалыг магадлан итгэмжлэх байгууллагад хүргүүлнэ.

6.8. Шинжээчдийн багийн нэгдсэн дүгнэлтийг комиссын хурлаар хэлэлцэж, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, эсэх тухай шийдвэр гаргана.

6.9. Магадлан итгэмжлэх байгууллага нь хөндлөнгийн шинжээч томилон шинжээчдийн багийн дүгнэлтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно. Энэ тохиолдолд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэнэ.

6.10. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангаагүй төрийн бус байгууллага 6 сарын хугацаанд магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах эрхгүй бөгөөд дээрх хугацаанд энэ журмын 3.2-т заасан бэлтгэл болон шалгуур үзүүлэлтийг хангасны дараа дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж болно.

Долоо. Магадлан итгэмжлэл олгох

7.1. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн комиссын шийдвэрийг үндэслэн магадлан итгэмжлэгдсэн батламж олгоно.

7.2. Анх удаа магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 1-3 жилийн хугацаатай, давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 2-5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэл олгоно.

7.3. Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага нь магадлан итгэмжлэлийн батламж олгосон өдрөөс хойш хуанлийн 30 өдрийн дотор шинжээчдийн өгсөн зөвлөмжийг тусгасан, чанарын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

7.4. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага нь магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дуусаад 16а түүнээс дээш жилийн дараа хүсэлтээ гаргах, "Хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр" хэрэгжүүлээгүй бол анх удаа магадлан итгэмжлэгдсэнээр үнэлнэ.

Найм. Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох

8.1. Магадлан итгэмжлэлийг дор дурдсан нөхцөлд хугацаанаас өмнө хүчингүй болгоно. Үүнд:

8.1.1. магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын үйлчилгээний технологи, эрүүл ахуй, аюулгүй байдлын хамгаалалтын нөхцөл зөрчигдсөний улмаас үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэнд хохирсон болох нь тогтоогдсон;

8.1.2. магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, эсвэл татан буугдсан, 6 сараас илүү хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон;

Ес.Маргаан шийдвэрлэх

9.1.Төрийн бус байгууллага нь шинжээчдийн багийн өгсөн дүгнэлттэй санал нийлэхгүй бол магадлан итгэмжлэх байгууллагад хүсэлт гаргаж шинжээчдийн хоёр дахь багийг томилуулж болно. Энэхүү хоёрдахь багийн дүгнэлт нь магадлан итгэмжлэх комиссын эцсийн шийдвэрийн үндэслэл болно.

9.2.Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан маргааныг комиссын хурлаар хэлэлцүүлнэ.

9.3.Төрийн бус байгууллага нь комиссын гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гомдол гаргаж болно.

-----000-----

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 07 дугаар
сарын 04 ны өдөр

Дугаар А/НОИ...А/178

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32.3 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам"-ыг нэгдүгээр, "Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээний маягт"-ыг хоёрдугаар, "Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/-т, Цагдаагийн ерөнхий газар /Ө.Энхтөр/-т, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/-т, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба /Л.Нямгэрэл/-д тус тус даалгасугай.





НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид /цаашид үйлчлүүлэгч гэнэ/ учирсан, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнд учирч болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлох, хариу үйлчилгээг төлөвлөх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. "Нөхцөл байдлын үнэлгээ" гэж үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг хэлнэ.

1.3. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.4. Нөхцөл байдлын үнэлгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 32 дугаар зүйлийн 32.1-т заасны дагуу нийгмийн ажилтан, хохирогч нь хүүхэд бол Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, шаардлагатай тохиолдолд аймаг, дүүрэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, суманд нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн /цаашид нөхцөл байдлын үнэлгээ хийсэн ажилтан гэнэ/ Хамтарсан багийн бусад гишүүнтэй хамтран хийнэ.

1.5. Нөхцөл байдлын үнэлгээ нь хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.

Хоёр. Нөхцөл байдлын үнэлгээ хийх

2.1. Холбогдох байгууллага, албан тушаалтанд хохирогч өөрөө, хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн талаар мэдээлэл ирүүлсэн тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

2.2. Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ цагдаагийн албан хаагчийн аюулын зэргийн үнэлгээг харгалзана.

2.3. Нөхцөл байдлын үнэлгээг мэдээлэл авснаас хойш яаралтай үед нэн дариу, бусад нөхцөлд 72 цагийн дотор хийнэ.

2.4. Нөхцөл байдлын үнэлгээг хийхэд тухайн гэр бүл, хүүхдийн амьдарч буй орчинд очиж хийх ба үнэлгээнд хамтарсан багийн 2-оос доошгүй хүн оролцоно.

2.5. Насанд хүрсэн үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээг "Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал"-ын үнэлгээний маягтын дагуу хийнэ.

2.6. Гэр бүлийн хүчирхийллийн Нөхцөл байдлын үнэлгээ нь шалгах, эрсдэлийг тодорхойлох, дүгнэх үе шатаас бүрдэнэ.

2.6.1. энэ журмын 2.6-д дурдсан шалгах үе шатанд ерөнхий мэдээлэл, үйлчлүүлэгч болон хүчирхийлэл үйлдэгчийн мэдээлэл, гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, хүчирхийлэл үүсэхэд нөлөөлөгч хүчин зүйлс, хүчирхийллийн хэлбэр, гэр бүлийн нөхцөл байдал, хэрэгцээний талаарх мэдээллүүд байна.

2.6.2. энэ журмын 2.6-д дурдсан эрсдэлийг тодорхойлох үе шатанд цагдаагийн албан хаагчийн аюулын зэргийн үнэлгээ, гэр бүлийн хүчирхийллийн харилцааны түүх, эрсдэлт зан үйл, үйлчлүүлэгчийн одоогийн нөхцөл байдал, аюулгүй байдлын мэдээллүүд байна.

2.6.3. энэ журмын 2.6-д дурдсан дүгнэх үе шатанд 2.6.1, 2.6.2-т заасан мэдээллийг нэгтгэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг тодруулан, хүүхэд, гэр бүлд тулгарсан асуудал, амьдралын нөхцөл ямар байдалд байгааг мэргэжлийн түвшинд багцлан, товч, тодорхой дүгнэж, чухал гэж үзсэн нийгмийн хамгааллын суурь болон нийгмийн ажлын мэргэжлийн зарим үйлчилгээг санал болгоно.

2.7. Гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүүхэд хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсэн тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг "Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягт"-ын дагуу хийх бөгөөд энэ нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

2.7.1. хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах /маягт ХХ01/;

2.7.2. хүүхэд эрх, хамгааллын хамгааллын үйлчилгээнд хүүхэд хүлээн авах /маягт ХХ02/;

2.7.3. хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ /маягт ХХ03/;

2.7.4. гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ /маягт ХХ04/;

2.7.5. аюулгүй байдлын төлөвлөгөө /маягт ХХ05/;

2.7.6. аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр гэр бүлтэй байгуулах гэрээний загвар /маягт ХХ06/

2.8. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ асуулга, ярилцлага, бичиг баримт судлах, тандалт, ажиглалт зэрэг нийгмийн ажлын судалгааны үндсэн аргуудыг ашиглах бөгөөд ярилцлагын болон үйл явцын тэмдэглэлийг давхар хөтөлнө.

2.9. Хоёр ба түүнээс дээш тооны хохирогч байвал нөхцөл байдлын үнэлгээг хохирогч тус бүрт хийнэ.

2.10. Нөхцөл байдлын үнэлгээг хийхийн өмнө үйлчлүүлэгчид түүний эрх, үүргийг танилцуулж, зөвхөн үнэн зөв мэдээлэл өгөх, үнэлгээ хийснээр тусламж үйлчилгээний төрлийг /нийгмийн ажлын мэргэжлийн болон нийгмийн хамгааллын суурь үйлчилгээ/ тодорхойлох, хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх чухал ач холбогдолтой болохыг тайлбарлаж өгнө.

2.11.Нөхцөл байдлын үнэлгээг 7 ба түүнээс дээш насны хүүхэдтэй нас, сэтгэхүйн онцлогт тохируулан харилцан ярилцаж, хэрэв хүүхэд 7 нас хүрээгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүдийг байлцуулан үнэлгээг хийх, хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүчирхийлэл үйлдсэн болон хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй бол гэр бүлийн бусад гишүүд, мэргэжилтэн, хөндлөнгийн хүнийг байлцуулан хийнэ.

2.12.Үйлчлүүлэгч хөгжлийн бэрхшээлтэй (сонсгол, хэл яриа г.м), үндэсний цөөнх, гадаадын иргэн бол дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар дамжуулан нөхцөл байдлын үнэлгээ хийж энэ тухай тэмдэглэл хэсэгт дурдана.

2.13.Нөхцөл байдлын үнэлгээг үйлчлүүлэгчид танилцуулж гарын үсэг зуруулна. Хэрэв үйлчлүүлэгч бичиг үсэгт тайлагдаагүй, хөгжлийн бэрхшээлтэй, /сонсгол, хараа, хэл яриа г.м/, үндэсний цөөнх, гадаадын иргэн бол тэмдэглэлд дурдана.

2.14.Нөхцөл байдлын үнэлгээнд тэмдэглэл, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг бусад нотлох баримтыг хавсарган он, сар, өдөр, хуудас бүрт гарын үсэг зурж, сүүлийн хуудаст харьяа байгууллагын тамга дарж баталгаажуулан харьяа сум, хороо, багийн хамтарсан багт хүргүүлнэ.

2.15.Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн ажилтан Хамтарсан багийн гишүүн биш байх тохиолдолд хийсэн үнэлгээгээ хамтарсан багт заавал танилцуулж, хүлээлгэн өгөх бөгөөд шаардлагатай бол хамтран ажиллана.

2.16.Нөхцөл байдлын үнэлгээг хийсэн ажилтан үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалж, мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлана.

2.17.Нөхцөл байдлын үнэлгээ нь үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, дуусгавар болгох үндэслэл болох ба тухай бүрт нь шинэчилсэн мэдээллээр баяжуулна.

2.18.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь нөхцөл байдлын үнэлгээ хийх эрх бүхий албан тушаалтанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

2.19.Хамтарсан багийн нарийн бичгийн дарга нөхцөл байдлын үнэлгээний талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн санд оруулна.

Гурав. Нөхцөл байдлын үнэлгээнд хориглох зүйл

3.1.Нөхцөл байдлын үнэлгээ хийх үед дараах зүйлийг хориглоно:

3.1.1.нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ үйлчлүүлэгчийг буруутгах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавих;

3.1.2.нөхцөл байдлын үнэлгээг хийх үед үйлчлүүлэгчийг хүчирхийлэл үйлдэгчтэй хамтад асуулт асуух, байлгах, уулзуулах;

Дөрөв. Бусад

4.1.Энэ журмын хэрэгжилтэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн эрх мэдлийн хүрээнд хяналт тавина.

-----oOo-----



Хувийн хэргийн дугаар: _____

1. ШАЛГАХ ҮЕ ШАТ
1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
Нөхцөл байдлын үнэлгээ нь үйлчлүүлэгчид хийж буй хэд дэх үнэлгээ болох: <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Анхны үнэлгээ <input type="checkbox"/> Үйлчилгээ үзүүлэх явцын үнэлгээ <input type="checkbox"/> Үйлчилгээг дуусгавар болгох үеийн үнэлгээ
Үнэлгээ хийж буй ажилтан: байгууллагын овогтой албан тушаалтай, Огноо: 20..... оны сарын өдөр Ярилцлага эхэлсэн цаг: Дууссан цаг: Үнэлгээ хийсэн газар:
Мэдээллийн эх сурвалж: <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Үйлчлүүлэгч хандсан <input type="checkbox"/> Цагдаагийн албан хаагч <input type="checkbox"/> Хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд /аль тохирохыг зураг/ /боловсрол, эрүүл мэнд, төрийн албан хаагч, хороо, баг, сумын холбогдох албан тушаалтан, ТББ/ <input type="checkbox"/> Иргэн мэдээлсэн <input type="checkbox"/> Хүүхэд <input type="checkbox"/> Хуулийн этгээд мэдээлсэн <input type="checkbox"/> Бусад
Мэдээллийн хэлбэр /доогуур зураг/: амаар, бичгээр, утсаар, цахимаар
1.2. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ
Овог, нэр: хүйс: Регистрийн дугаар:, Төрсөн он сар өдөр: Оршин суугаа хаяг:
Холбоо барих утас:
1.3. ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ
Овог, нэр: хүйс: Регистрийн дугаар:, Төрсөн он сар өдөр: Оршин суугаа хаяг:
Холбоо барих утас:

Сэтгэл зүйн байдал (шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийн мэргэжлийн дүгнэлтийг хавсаргана.)

- Хэвийн
- Хэвийн бус

Тайлбар:

.....

.....

Эрүүл мэндийн үйлчилгээ, тусламж авч буй эсэх:

- Үгүй
- Тийм

Тайлбар:

.....

.....

2.3.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Үйлчлүүлэгчийн орлого, хөдөлмөр эрхлэлтийн байдал:

Боловсрол:

Мэргэжил:

Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

- Ажил эрхэлдэг
- Ажилгүй
- Тогтмол орлоготой эсэх

Сарын тогтмол орлого:

Үйлчлүүлэгчийн эдийн засгийн байдал

- Бие даасан
- Хүчирхийлэл үйлдэгчээс хараат
- Бусад

Тайлбар:

.....

.....

Хүчирхийлэл үйлдэгчийн орлого, хөдөлмөр эрхлэлтийн байдал:

Боловсрол:

Мэргэжил:

Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

- Ажил эрхэлдэг
- Ажилгүй
- Тогтмол орлоготой эсэх

Сарын тогтмол орлого:

Тайлбар:

.....

.....

Үйлчлүүлэгчийн эдийн засгийн байдал

- Бие даасан
- Хүчирхийлэл үйлдэгчээс хараат
- Бусад

2.3.3. ГЭР БҮЛИЙН ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ, АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛ

Хоол хүнс:

- Хангалттай
- Хангалттай биш
- Хүнсний эрхийн бичгээр үйлчлүүлдэг
- Бусад

Тайлбар:

.....

.....

Хувцас:

- Улирлын онцлогт тохирсон хувцастай
- Улирлын онцлогт тохирсон хувцас хангалтгүй

Тайлбар:

.....

.....

Орон байр:

- Орон сууцанд амьдардаг
- Гэр хороололд амьдардаг (гэр, байшин тохирохыг зур)
- Түрээслэдэг (орон сууц, гэр, байшин)
- Айлд амьдардаг
- Зориулалтын бус орон байранд амьдардаг
- Орон гэргүй
- Бусад

Тайлбар:

.....

.....

Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө нь хэний эзэмшил, өмчлөлд байдаг:

- Дундын
- Хүчирхийлэл үйлдэгчийн
- Үйлчлүүлэгчийн
- Бусад

Тайлбар:

.....

.....

2.3.4. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

Гэр бүлийн гишүүдийн үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа:

- Бие биенээ дэмжсэн
- Үйлчлүүлэгчийг буруутгасан
- Үйлчлүүлэгчийг дэмжсэн, хамгаалсан

Харилцаагүй

Тайлбар:

.....

.....

Гэр бүлийн гишүүдийн хүчирхийлэл үйлдэгчтэй харилцах харилцаа:

- Бие биенээ дэмжсэн
- Хүчирхийлэл үйлдэгчийг дэмжсэн
- Хүчирхийлэл үйлдэгчийг буруутгасан
- Харилцаагүй

Тайлбар:

.....

.....

Хүүхэдтэй харилцах харилцаа:

- Хүүхдээ сайн асарч хүмүүжүүлдэг, яаж харилцахаа мэддэг
- Заримдаа хүүхэддээ буруу, боломжгүй шаардлага тавьдаг
- Хүүхэдтэйгээ ойлголцохгүй бол хэл амаар доромжилдог, зоддог
- Хүүхдээ зодож гэмтээж байсан, хүүхэдтэйгээ байх дургүй

Тайлбар:

.....

.....

2.3.5. НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үйлчлүүлэгч болон гэр бүлийн бусад гишүүд иргэний бичиг баримттай эсэх:

- Иргэний бичиг баримттай
- Нийгмийн даатгал хамрагддаг
- Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг
- Бичиг баримтгүй

Тайлбар:

.....

.....

Үйлчлүүлэгч нь нийгмийн дэмжлэг туслалцаа авдаг эсэх:

- Төрийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг
- Олон улсын болон бусад байгууллагаас дэмжлэг авдаг
- Халамж, дэмжлэг туслалцаанд хамрагддаггүй
- Бусад

Тайлбар:

.....

.....

Үйлчлүүлэгч хүчирхийлэл гарсан үед нэн даруй хүчний байгууллагын болон нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг эсэх:

- Тийм
- Үгүй

Хэрэв тийм бол үйлчлүүлэгч хаана амьдардаг, ямар шалтгаанаар үйлчилгээ нэн даруй авах боломжгүй тухай тодруулан бичнэ үү.

.....

.....

.....

Үйлчлүүлэгч ямар нэг шалтгаанаар (нас, хүйс, гарал үүсэл, боловсрол, эрхэлж буй ажил, эрүүл мэндийн байдал, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага зэрэг шалтгаанаар) ялгаварлан гадуурхагддаг эсэх.

1. Тийм
2. Үгүй

Хэрэв тийм бол үйлчлүүлэгчийг ямар шалтгаанаар бусдаас ялгаварлан гадуурхдаг тухай тодруулан бичнэ үү.

.....

.....

.....

2.3.6. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Үйлчлүүлэгч нь хүчирхийлэл үйлдэгчтэй хамт амьдарч байгаа эсэх:

- Хамт амьдарч байгаа
- Тусдаа амьдарч байгаа
- Салсан
- Бусад

Тайлбар:

.....

.....

Хүчирхийлэл үйлдэгч болон түүний гэр бүлийн бусад гишүүдтэй ямар харилцаатай

- Үйлчлүүлэгчийг хүчирхийлж дарамталдаг
- Айлган сүрдүүлж, заналхийлдэг
- Мөрдөж, мөшгидэг
- Хүүхдээр барьцаалж, холбоо тогтоох хэрэгсэл болгон ашигладаг
- Бусад

Тайлбар:

.....

.....

Үйлчлүүлэгч нь одоогоор аюулгүй байдлын хамгаалалт авч байгаа эсэх

- Түр хамгаалах байранд байрлаж байгаа
- Нэг цэгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа
- Төрөл садан, ойр дотны хүний түр хамгаалалтад байгаа
- Гэрч, үйлчлүүлэгчийн хамгаалалтад байгаа
- Айлаар хоноглодог
- Хамгаалалтгүй
- бусад

Тайлбар:

.....

.....

.....

2.3.7. ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ЭСЭХ

Цагдаагийн байгууллагад хандсан:

- Захиргааны арга хэмжээ авахуулсан
- Эрүүгийн хэрэг үүсгүүлсэн
- Бусад

Тайлбар:

Шүүхийн байгууллагад хандсан:

- Гэрлэлт цуцлуулах
- Хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох
- Эд хөрөнгийн маргаан шийдвэрлүүлэх
- Тодорхой эрх хязгаарлах гомдол гаргах

Тайлбар:

Хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээнд хамрагдаж буй болон цаашид хамрагдах шаардлагатай эсэх

- Тийм
- Үгүй

Тайлбар:

3. ДҮГНЭХ ҮЕ ШАТ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

3.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХАРИЛЦААНЫ ТҮҮХ /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.2. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.4. ГЭР БҮЛИЙН ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ, АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛ /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.5. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.6. НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ МЭДЭЭЛЭЛ /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.7. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ /дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

3.8. ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭ/ дүгнэлт, санал болгох үйлчилгээ/

Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн:

Нийгмийн ажилтны овог нэр:

гарын үсэг:

Он, сар, өдөр:

Байгууллагын тамга

Нөхцөл байдлын үнэлгээтэй танилцсан үйлчлүүлэгчийн овог нэр:

гарын үсэг:

Он, сар, өдөр:

Хавсаргасан материалын жагсаалт:

1. _____
2. _____
3. _____
4. _____



ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЭЛ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ
Маягт ХХ 01

Аймаг/дүүрэг:

Сум/хороо:

Он, сар, өдөр:

Мэдээлэл хүлээн авсан цаг хугацаа:

Мэдээлэл хүлээн авсан ажилтны нэр:

Мэдээлэл хүлээн авсан ажилтны албан тушаал:

Мэдээллийн эх үүсвэр:

Мэдээлэл өгсөн хүний нэр:

Хаяг:

Утас:

Мэдээлэгч нь дараах бүлгийн алинд хамаарахыг тэмдэглэнэ үү:

- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв
- Аймаг, дүүргийн ГБХЗХГазар, хэлтэс
- Эмч, эрүүл мэндийн ажилтан
- Багш, сургуулийн нийгмийн ажилтан
- Цагдаа
- Хэсгийн ахлагч
- Гэр бүлийн гишүүн
- Хамаатан садан
- Хөрш
- Хүүхэд өөрөө
- Хүүхдийн найз нөхөд
- Бусад

Мэдээлэгдсэн зөрчлийн талаарх ерөнхий агуулга:

Хүүхдийн талаар мэдээлэл:

Хүүхдийн овог, нэр:

Хүйс: эрэгтэй/эмэгтэй

Нас:

Оршин суугаа хаяг:

Ам бүлийн тоо:

Гэр бүлийн гишүүд:

Хүүхэд хамгааллын зөрчлийн хэлбэр буюу тохирох зөрчлийн өмнө чагт тэмдэг тавина уу.

- Бие махбодын хүчирхийлэл
- Үл хайхрах
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Гэмт хэрэг, зөрчлийн гэрч болсон
- Төөрсөн/хаягдсан
- Тэвчишгүй хөдөлмөрийн мөлжлөг
- Хүний наймаанд өртсөн
- Барьцаалагдсан
- Хараа хяналтгүй байгаа
- Амиа хорлохыг завдсан
- Осол гэмтэлд өртсөн
- Бусад:

Зөрчил гаргагчийн талаарх мэдээлэл:

Овог:..... Нэр:..... Нас: Хүйс: эрэгтэй/эмэгтэй

Гэрийн хаяг:.....

Ажлын газар:

Холбоо барих утас:

Зөрчил гаргагч нь үйлчлүүлэгчтэй ямар холбоо, хамааралтай, харилцаатай болох:

ариу үйлчилгээний санал (гэр бүлийн болон эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа хөглөх)

- Эмнэлэгт хүргэх
- Аюулгүй байдлын төлөвлөгөө гаргах
- Аюулгүй газар шилжүүлэх / хамаатан садны асрамжинд өгөх
- Хүчирхийлэгчийг тусгаарлуулах
- Хамгаалах байр
- Хувийн хэрэг нээх
- Бусад

Мэдээллийг өөр байгууллагад өгсөн бол:

- Аймаг/дүүргийн ГБХЗХГазар, хэлтэс
- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв
- Бусад:

Мэдээлэл дамжуулсан цаг хугацаа:

108 утсан дээр дуудлага хүлээн авсан зөвлөхийн код:

Мэдээлэл хүлээн авсан хүний гарын үсэг:

Мэдээлэгчийн гарын үсэг:

**ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮҮХЭД
ХҮЛЭЭН АВАХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ¹**
Маягт ХХ 02

Аймаг/дүүрэг:
Сум/хороо:
Бүртгэлийн дугаар:
Бүртгэсэн огноо, цаг хугацаа:

Хүүхэд хамгаалах үйлчилгээнд бүртгэгдэх болсон сэжиг, таамаглал

- Бие махбодын хүчирхийлэл
- Үл хайхрах
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Гэмт хэрэг, зөрчлийн гэрч болсон
- Төөрсөн/хаягдсан
- Хөдөлмөр эрхэлдэг
- Хараа хяналтгүй байгаа
- Амиа хорлохыг завдсан
- Осол, гэмтэлд өртсөн
- Хүний наймаанд өртсөн
- Барьцаалагдсан
- Бусад:

Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатайг хэн, хаанаас мэдээлсэн:

- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв
- Аймаг, дүүргийн ГБХЗХГазар, хэлтэс
- Сургууль, багш
- Өрхийн эмч
- Гэр бүлийн гишүүн (хэн)
- Хэсгийн ахлагч
- Цагдаа
- Иргэн/хөрш
- Хүүхэд өөрөө
- Хүүхдийн найз
- Бусад:

Та мэдээллийг өөр байгууллагад мэдэгдсэн үү?

- Тийм
- Үгүй

Мэдээлсэн бол хаана, хэнд:

- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв
- Аймаг, дүүргийн ГБХЗХГазар, хэлтэс
- Хүүхэд хамгааллын хамтарсан багт

¹Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл авах бүртгэл

- Цагдаад
- Эмнэлэгт
- Гэр бүлийн гишүүн (хэнд):
- Асран хамгаалагч (хэнд):
- Сургууль, багш.....
- Бусад:

Хүүхдийн асуудлаар холбоо барих хүний утас, хаяг (хамаатан садан эсхүл танил)

1. Овог.....Нэр: Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой:

Хаяг:..... Шаардлагатай үед холбоо барих утас:

2. ОвогНэр: Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой:

Хаяг: Шаардлагатай үед холбоо барих утас:

ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ:

Овог..... Нэр:

Нас:..... Хүйс: эрэгтэй/эмэгтэй (доогуур нь зур)

Гэрийнхэн нь дууддаг нэр:

Үндсэн харъяалал: (бүртгэлийн баримт үндэслэн)

Одоогийн оршин суугаа хаяг: (өөр газар оршин суугаа бол)

Хүүхдийн регистрийн дугаар:

Хүүхдийн гэр бүлийн талаарх мэдээлэл:

Ам бүлийн тоо:

Эцэг эх, асран хамгаалагчийн мэдээлэл:

	Хүүхдийн эцэг	Хүүхдийн эх	Асран хамгаалагч	Хүүхдэд хамгийн ойр гэр бүлийн хүн
Овог, нэр				
Боловсрол				
Хөдөлмөр эрхлэлт Ажлын газрын нэр				

Холбоо барих утас:				
Бусад мэдээлэл				

Халамжийн үйлчилгээнд хамрагдсан эсэх:

Хүүхдийн бие махбодын ерөнхий байдал (биед илрэх шинж тэмдэг, шарх сорви):

Жич: Хүүхдийн бие махбод болон сэтгэл зүйн байдалтай холбоотой гэрэл зураг, дүрс бичлэгийг хавсаргаж болно.

Сургууль, цэцэрлэгт хамрагдсан эсэх: Тийм/ үгүй

Тийм бол тохирох хариултыг дугуйлна уу?

- Сургууль
 Цэцэрлэг
 Бусад, тайлбар

Багшийн..... нэр:.....

Холбогдох утас:

Сургуулийн нийгмийн ажилтны нэр: Холбогдох утас:

Үгүй бол:

Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй шалтгаан:

Хүүхдийн зан төлөвийн ерөнхий байдал: (Анхны ажиглалтаар илрэх биеэ авч явж байгаа байдал, гаргаж буй зан үйл)

Хүүхдэд эрүүл мэндийн яаралтай тусламж шаардлагатай эсэх:

- Тийм (тийм бол кейс төлөвлөгөөнд оруулах)
 Үгүй

Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө/заслын үйлчилгээ шаардлагатай эсэх:

- Тийм (тийм бол үйлчилгээний төлөвлөгөөнд оруулах)
 Үгүй

Зөрчил гаргасан гэж мэдээлэгдсэн хүний талаарх мэдээлэл:

Овог Нэр: Нас:..... Хүйс: эрэгтэй/эмэгтэй
Гэрийн хаяг:

Ажлын газар:

Холбоо барих утас:

Хүүхэдтэй ямар холбоо, хамааралтай, харилцаатай болох:

Өөр үйлчилгээнд холбон зуучлах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх:

- Тийм
 Үгүй

Тийм бол хаашаа, хэнд холбон зуучлах

- Хамгаалах байр
 Цагдаа
 Эмнэлэг
 Хороо
 Халамжийн төв
 ТББ.....
 Бусад:

Эрсдлийн үнэлгээ хийх шаардлагатай эсэх:

- Тийм
 Үгүй бол шалтгааныг

тайлбарлах:.....

Засаг даргад танилцуулсан хугацаа: 201_он__сар__өдөр__цаг__мин

Бүртгэлийн дугаар: _____

Бүртгэл хөтөлсөн ажилтны овогнэр:

Гарын үсэг:

Албан тушаал:, Огноо:

Хавсралтаар:

1.
2.

ХҮҮХДИЙН ЭРСДЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Маягт XX 03

Бүртгэлийн дугаар:Огноо: 20__ он __ сар __ өдөр

Аймаг/ дүүрэг:

Сум/хорооны нэр:

Үнэлгээ хийсэн цаг, үргэлжилсэн хугацаа:

Үнэлгээ хийсэн ажилтны овог нэр, албан тушаал:

Хэсэг 1: Доорх шалгууруудын аль нэг нь байгаа бол эрсдэлтэй гэж үзэн хувийн хэрэг нээж хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.1. Хүүхдэд бие махбодын ноцтой гэмтэл бэртэл илэрсэн. Тийм
 Үгүй

Тайлбар:

2. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй сэжиг илэрсэн. Тийм
 Үгүй

Тайлбар:

3. Хүүхэд 0-6 настай бөгөөд гэр бүлд нь хүүхдэд анхаарал, халамж тавьж байгаа хүн байхгүй. Тийм
 Үгүй

Тайлбар:

4. Хүүхэд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд гэр бүлд нь хүүхдэд анхаарал, халамж тавьж байгаа хүн байхгүй Тийм
 Үгүй

Тайлбар:

5. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч сэтгэцийн эмгэг өвчний улмаас бусдын болон өөрийн амь насанд аюултай үйлдэл гаргаж байсан. Тийм
 Үгүй

Тайлбар:

6. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бусад хүчин зүйл байгаа эсэх. Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү. Тийм
 Үгүй

Тайлбар:

7. Эцэг эх, асран хамгаалагч нь мансууруулах бодис, согтууруулах ундааны хэт хамааралтайн улмаас хүүхдэд анхаарал, халамж тавих чадвараа алдсан Тийм
 Үгүй

Тайлбар:

8. Өмнө нь энэ хүүхдийн хамгааллын талаар зөрчил гарч байсны улмаас холбогдох байгууллагуудад хандаж үйлчилгээ авч байсан Тийм
 Үгүй

Тайлбар:

9. Хүүхэд, түүний гэр бүл нийгмийн болон хүүхэд хамгааллын үйлчилгээнээс хол, үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал Тийм
 Үгүй

Тайлбар:

Хэсэг 2: Доорх шалгууруудын аль нэг нь байгаа бол хувийн хэрэг нээж хамгааллын шуурхай үйлчилгээг хамтарсан багаар үзүүлнэ.1. Хүчирхийллийн улмаас хүүхэд гэрээсээ зугатааж, оргож байсан. Тийм
 Үгүй

Тайлбар:

2. Хүүхэд амиа хорлох, биеэ гэмтээх оролдлого хийж байсан нь мэдээлэгдсэн. Тийм
 Үгүй

Тайлбар:

3. Хүчирхийлэгч нь хутга, мэс, зэвсгийн чанартай зүйл ашиглан Тийм
 Үгүй

хүүхдийг айлган сурдуулдэг.	
Тайлбар:	
4. Хүчирхийлэгч нь хүүхдийг бусдаас тусгаарлах, хорих зэрэг үйлдэл гаргасан.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тайлбар:	
5. Хүүхэд сургууль завсардсан.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тайлбар:	
6. Хүүхэд ажиллуулахыг хориглосон хүнд хөдөлмөр эрхэлдэг.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тайлбар:	
7. Хүүхэд гэмт хэрэгт холбогдсон.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тайлбар:	
8. Хүүхэд өнчирч асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгож амжаагүй.	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тайлбар:	
Хэсэг 3: Эрсдэлд чиглэсэн арга хэмжээ ба үйлчилгээ	
<ul style="list-style-type: none"> ○ Хүүхдийг эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнд холбож өгөх ○ Хүчирхийлэгчийг яаралтай тусгаарлаж хүүхдийг гэрт нь үлдээж аюулгүй байдлыг нь хангах ○ Садан төрлийн асрамжинд түр хугацаагаар шилжүүлж аюулгүй байдлыг нь хангах ○ Хамтарсан багаар гэр бүлд шууд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх ○ Хүүхдийг хамгаалах байранд түр байршуулах ○ Хүүхэдтэй зүй бус харьцсан этгээдэд хуулийн дагуу хариуцлагын арга хэмжээ авах 	

○ Бусад:					
Тайлбар:					
Хэсэг 4: Тухайн гэр бүлд байгаа бусад хүүхдийн талаарх мэдээлэл					
№	Хүүхдийн нэр	Нас	Хүйс	Хүчирхийлэлд өртсөн эсэх	Эрсдлийн үнэлгээ хийх шаардлагатай эсэх
Гэр бүлд байгаа бусад хүүхдүүдэд эрсдлийн үнэлгээ хийх шаардлагатай бол тусад нь хийх бөгөөд тэдгээр хүүхдийн нэрийг бичнэ үү.					
-					
-					
-					
-					
-					
-					
Хэсэг 5: Эрсдлийн үнэлгээний дүгнэлт:					
Үнэлгээ хийсэн нийгмийн ажилтны нэр, гарын үсэг: _____ / _____ /					

Үнэлгээнд оролцсон хамтарсан багийн гишүүдийн овог нэр, албан тушаал, гарын үсэг:

1. _____ / _____ /
 2. _____ / _____ /
 3. _____ / _____ /
 4. _____ / _____ /
 5. _____ / _____ /

Засаг даргын нэр, гарын үсэг: _____
 / _____ /

Жич: Эрсдлийн үнэлгээг дахин хийхээр товлож буй хугацаа:
 Үнэлгээ хийж дууссан огноо : 201_ оны сарын _-ны өдөр

Хавсаргасан материалын жагсаалт:

1. _____
2. _____
3. _____
4. _____

ГЭР БҮЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Маягт XX 04

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Гэр бүл хэд дэх удаагаа үнэлгээ хийж буй:	
Бүртгэлийн дугаа:	
Үнэлгээ хийж буй нийгмийн ажилтны нэр:	
Огноо: 20 оны сарын өдөр	
Ярилцлага эхэлсэн цаг: Дууссан цаг:	
Үнэлгээг хийсэн газар:	
ЭЦЭГ ЭХИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Эцгийн овог, нэр:	
Регистрийн дугаар:	
Гэр бүлийн байдал:	
<input type="checkbox"/> Гэрлээгүй	Гэрлэсэн бол: гэрлэлтээ бүртгүүлсэн / бүртгүүлээгүй
<input type="checkbox"/> Гэрлэсэн: (зур)	
<input type="checkbox"/> Салсан	
<input type="checkbox"/> Бэлэвсэн	
<input type="checkbox"/> Тусдаа байдаг	
<input type="checkbox"/> Хамтран амьдардаг	
<input type="checkbox"/> Бусад:	
Эхийн нэр:	
Регистрийн дугаар:	
Гэр бүлийн байдал:	
<input type="checkbox"/> Гэрлээгүй	Гэрлэсэн бол: гэрлэлтээ бүртгүүлсэн / бүртгүүлээгүй
<input type="checkbox"/> Гэрлэсэн: (зур)	
<input type="checkbox"/> Салсан	
<input type="checkbox"/> Бэлэвсэн	
<input type="checkbox"/> Тусдаа байдаг	
<input type="checkbox"/> Хамтран амьдрагч	
<input type="checkbox"/> Бусад:	
ХҮҮХДИЙГ ЭЦЭГ, ЭХЭЭС ӨӨР ХҮН АСРАН ХАЛАМЖИЛДАГ БОЛ	
Асран халамжлагчийн овог, нэр:	
Гэрийн хаяг:	
Холбоо	барих утасны дугаар:

.....

Бусад мэдээлэл:

ЯАРАЛТАЙ ЭСХҮЛ ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ХОЛБОО БАРИХ

Хэн:

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой болох:

Утасны дугаар:

Гэрийн хаяг:

ГЭР БҮЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гэр бүлийн гишүүдийн тоо:

Гэр бүлийн гишүүдийн мэдээлэл: (Эцэг эхээс бусад одоогийн гэр бүлийн гишүүд)

Хүүхэдтэй ямар хамааралтай	Овог, нэр	Хүйс	Нас	РД	Хүчирхийлэлд өртдөг эсэх

Бусад мэдээлэл:

Хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тоо: _____

Хэн, хүүхэдтэй ямар хамааралтай	Боловсрол	Мэргэжил	Хөдөлмөр эрхлэлтийн байдал (тэтгэвэр, группт, гэх мэт)	Ажлын газрын нэр	Эрхэлж буй ажил

Гэр бүлийн сарын орлогын хэмжээ:

ГЭР БҮЛИЙН УДМЫН ЗУРАГ БУЮУ ГЕНОГРАММ²(зур)

.....

ГЭР БҮЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

1. Гэр бүлийн үндсэн хэрэглээ

1.1. Хүүхэд өдрийн физиологийн хэрэгцээгээ хангах хоол тэжээлийг иддэг эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	1.2. Нөхцөл байдлыг үнэлэх үед хүүхэд тухайн улирлынхаа хувцасыг өмссөн байсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
--	--

Тайлбар:

2. Амьдрах орчин, нөхцөл

2.1. Орон байрны нөхцөл: <input type="checkbox"/> Орон сууцанд амьдардаг <input type="checkbox"/> Гэр хороололд амьдардаг	2.2. Амьдарч буй газрын эрүүл ахуйн нөхцөл: <input type="checkbox"/> Цэвэр, эмх цэгцтэй, дулаан
---	--

² Гэр бүлийн удмын зураг буюу генограмм нь гэр бүлийн гишүүдийн хоорондын холбоо, харилцааг тусгай зураас, тэмдэглэлээр харуулна.

<input type="checkbox"/> гэр <input type="checkbox"/> байшин <input type="checkbox"/> Түрээслэдэг <input type="checkbox"/> орон сууц <input type="checkbox"/> гэр <input type="checkbox"/> байшин <input type="checkbox"/> Айлд амьдардаг <input type="checkbox"/> хамаатан <input type="checkbox"/> хамаатан бус <input type="checkbox"/> Зориулалтын бус орон байранд амьдардаг бол (орон байрыг тодорхойлж бичнэ үү) <input type="checkbox"/> Орон гэргүй	<input type="checkbox"/> Эмх цэгцгүй, бохир /эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц биш/ <input type="checkbox"/> Эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр бохир, ариун цэврийн шаардлага хангаагүй, хүйтэн <input type="checkbox"/> Бусад:
Тайлбар:	
3. Эрүүл мэнд (Эмч бөглөнө)	
3.1. Хүүхдийн эрүүл мэндийн байдал:	3.2 Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдал: (Тохирох хариултын ард гэр бүлийн гишүүдийн нэрийг бич)
<input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Өсөлт хоцрогдолтой <input type="checkbox"/> Тураалтай <input type="checkbox"/> Суурь өвчтэй <input type="checkbox"/> Халдварт <input type="checkbox"/> өвчтэй /...../ <input type="checkbox"/> Бусад: <input type="checkbox"/> Хөгжлийн бэрхшээлтэй <input type="checkbox"/> Төрөлхийн <input type="checkbox"/> Олдмол	<input type="checkbox"/> Биеийн эрүүл мэнд хэвийн <input type="checkbox"/> Сэтгэцийн эрүүл мэнд хэвийн <input type="checkbox"/> Архаг хууч өвчтэй <input type="checkbox"/> Сэтгэл мэдрэлийн хүнд өвчтэй <input type="checkbox"/> Халдварт өвчтэй <input type="checkbox"/> Хөгжлийн бэрхшээлтэй <input type="checkbox"/> Төрөлхийн <input type="checkbox"/> Олдмол <input type="checkbox"/> Бусад: /...../
Тайлбар:	
4. Хүүхдийн боловсрол	
4.1.	4.2
<input type="checkbox"/> ЕБС/СӨБ-д хамрагдсан (доогуур зур) <input type="checkbox"/> ЕБС/СӨБ-д хамрагдаагүй (доогуур зур) <input type="checkbox"/> Завсардсан <input type="checkbox"/> Албан бус сургалтад хамрагддаг <input type="checkbox"/> Мэргэжлийн сургалтад хамрагддаг <input type="checkbox"/> Хүүхэд харах үйлчилгээнд хамрагддаг <input type="checkbox"/> Хувилбарт үйлчилгээнд	Сургууль <input type="checkbox"/> цэцэрлэгийн нэр: Анги <input type="checkbox"/> бүлгийн нэр: Анги удирдсан багшийн нэр: Анги удирдсан багштай харилцах утас: Сургуулийн нийгмийн ажилтны нэр:

хамрагддаг <input type="checkbox"/> Бусад	Сургуулийн нийгмийн ажилтантай харилцах утас:
Тайлбар:	
5. Халамжийн үйлчилгээ (Тэтгэвэр, тэтгэмж гэх мэт)	
5.1 Халамжийн үйлчилгээнд хамрагддаг эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
Тайлбар:	
6. Гэр бүлийн гишүүдийн харилцаа	
6.1. Насанд хүрэгч – насанд хүрэгчийн хоорондын харилцаа:	6.2. Хүүхэд - хүүхдийн хоорондын харилцаа:
<input type="checkbox"/> Бие биенээ дэмжсэн <input type="checkbox"/> Эерэг боломжийн <input type="checkbox"/> Зөрчилтэй <input type="checkbox"/> Сөрөг муу нөлөө үзүүлэх	<input type="checkbox"/> Бие биенээ дэмжсэн <input type="checkbox"/> Эерэг боломжийн <input type="checkbox"/> Зөрчилтэй <input type="checkbox"/> Сөрөг муу нөлөө үзүүлэх
6.3. Насанд хүрэгч –хүүхдийн хоорондын харилцаа:	6.4. Хүүхэд хүмүүжүүлэх арга:
<input type="checkbox"/> Бие биенээ дэмжсэн <input type="checkbox"/> Эерэг боломжийн <input type="checkbox"/> Зөрчилтэй <input type="checkbox"/> Сөрөг муу нөлөө үзүүлэх	<input type="checkbox"/> Эерэг, дэмжсэн, үр дүнтэй <input type="checkbox"/> Эерэг боломжийн <input type="checkbox"/> Тохиромжгүй, үр дүнгүй <input type="checkbox"/> Сөрөг, зөрчилтэй, хүч хэрэглэсэн /тайлбарт нэмэх/
Гэр бүлийн харилцааны талаарх тайлбар:	

ХҮҮХЭДТЭЙ ХОЛБООТОЙ ОРЧНЫ ЗУРАГЛАЛ- ЭКО ЗУРАГЛАЛ ³	
7. Албан болон албан бус дэмжлэг, туслалцаа авч байсан түүх:	
7.1. Хамаатан, садан төрлийн холбоо: <input type="checkbox"/> Төрсөн ах, дүү, хамаатан, садан <input type="checkbox"/> Хамаатан, садан байхгүй <input type="checkbox"/> Бусад:	7.2. Хөршүүд эсвэл гэр бүлийн найзууд: <input type="checkbox"/> Хөршүүд <input type="checkbox"/> Гэр бүлийн найзууд <input type="checkbox"/> Бусад:
7.3. Орон нутгийн төрийн байгууллага <input type="checkbox"/> Хороо, сум, баг <input type="checkbox"/> Сургууль, цэцэрлэг <input type="checkbox"/> Бусад:	7.1. ТББ-ууд болон бусад <input type="checkbox"/> Үндэсний ТББ, <input type="checkbox"/> Олон улсын ТББ, <input type="checkbox"/> Сүм, шашны байгууллагаас <input type="checkbox"/> Бусад:
Тайлбар: (эх сурвалж)	
8. Гэр бүлийн гишүүд хорт зуршил (архи, тамхи, мансууруулах бодис) хэрэглэдэг эсэх:	
9. Гэр бүлийн давуу тал:	

³ Хүүхэдтэй холбоотой орчны зураглал буюу эко-зураглал нь хүүхэд, түүний гэр бүлийн гишүүд нь тэдэнтэй холбоотой хувь хүн, бүлэг, байгууллага, олон нийттэй ямар харилцаа холбоотойг тусгай тэмдэглэл, зураасаар харуулсан зураглал.

10. Ерөнхий дүгнэлт

Дахин гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай эсэх

- Тийм
 Үгүй

Тийм бол нөхцөл байдлын үнэлгээг дахин хийх хугацаа:

БАТАЛГААЖУУЛСАН:

Үнэлгээ хийсэн ажилтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга:

..... /...../

Гэр бүлийн гишүүдийг төлөөлж, нөхцөл байдлын үнэлгээнд оролцсон хүний нэр, гарын үсэг:

Хүүхэдтэй ямар хамаатай болох:

.....

Хавсралтаар:

- Хамтарсан багийн гишүүдийн дүгнэлтийг хавсаргаж болно.
- Бусад

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ⁴
Маягт XX 05

Аймаг/дүүрэг:
Сум/хороо:
Бүртгэлийн дугаар:
Он, сар, өдөр:

ХУВИЛБАР 1: ХҮҮХДИЙН ЭЦЭГ, ЭХ БОЛОН ГЭР БҮЛИЙН БУСАД ГИШҮҮДТЭЙ ХАМТРАН БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Аюултай нөхцөл	Тухайн нөхцөлд шуурхай авах арга хэмжээ	Хэн, хэн юу хариуцах	Нэмэлт тайлбар
1.				
2.				
3.				
4.				

ХУВИЛБАР 2: ХҮҮХЭДТЭЙ ХАМТРАН БОЛОВСРУУЛАХ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Аюултай нөхцөл	Хүүхэд юу хийх	Хэнд, хаашаа хандах	Нэмэлт тайлбар
1.				
2.				
3.				

Төлөвлөгөөнд оролцсон хүний нэр, гарын үсэг:

.....
.....
.....

⁴Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаага тодорхой бичнэ.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР ГЭР БҮЛТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Бид аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулахад оролцож, уг төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үйлчилгээ үзүүлэгч байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллахыг хүлээн зөвшөөрч байна.

Аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хуулийн дагуу хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хамтран ажиллаж, хэрэгжүүлнэ.

Эцэг, эх, асран хамгаалагчийн нэр: Төхиолдол хариуцсан нийгмийн ажилтан: _____

Он, сар, өдөр: _____ Он, сар, өдөр: _____

Жич: Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд нийгмийн ажилтан хүүхэд, гэр бүлийн гишүүдэд дараах асуудлыг тайлбарлаж, ярилцана.

- Хүүхдийн эрхийн тухай тайлбарлана.
- Хүүхэд хамгааллын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замууд, хариу үйлчилгээг хэрхэн авах талаар зөвлөгөө өгнө.
- Хүүхэд өөрөө оролцох эрхтэйг тайлбарлаж өгнө.
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга замуудыг хэлэлцэнэ.
- Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, зөрчлийн тухай хууль гэх мэт хуулийн холбогдох заалтуудыг танилцуулна.

Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээгээр (Маягт ХХ03) хүүхдийг гэрээс нь түр тусгаарлах шаардлагатай гэж тогтоогдоогүй бол аюулгүй байдлын төлөвлөгөөг хүүхдийн эцэг, эх болон гэр бүлийн бусад гишүүдтэй хамтран боловсруулж, тэдэнтэй гэрээ байгуулна.

Мөн7-оос дээш настай хүүхэд өөрийгөө хэрхэн хамгаалах тухай нийгмийн ажилтантай хамтран аюулгүй байдлын төлөвлөгөөг гаргахад нь мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.

Анхаар! Аюулгүй байдлын төлөвлөгөөг эцэг эх, гэр бүлийн гишүүд мэдэх нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц байвал эцэг эх болон гэр бүлд танилцуулахгүй мөн гэрээ байгуулахгүйг анхаарна уу.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 10 дугаар
сарын 04-ны өдөр

Дугаар А/22...А/259/Д/3201

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Хамтарсан багийн үйлчилгээнд хэрэглэх багц маяг"-ыг хоёрдугаар, үйлчлүүлэгчтэй байгуулах "Нууцын гэрээ"-ний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зөвлөл, салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/, Цагдаагийн газар /хэлтэс/, Эрүүл мэндийн газар /төв/, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/-т, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

5. Энэ журам гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны А/328 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ,
ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь сум /аймгийн төвийн сумын баг/, нийслэлийн хорооны түвшинд Хамтарсан багаас Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, түүний үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамтарсан баг нь Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж гарсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

1.3. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр бөгөөд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг үзүүлнэ.

1.4. Хамтарсан баг нь гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн хүчирхийллээс, хүүхдийг гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрх ашиг нь хөндөгдсөн үед нийгмийн ажлын мэргэжлийн цогц үйлчилгээг анхан шатанд үзүүлэх үүрэгтэй.¹

1.5. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасны дагуу бүх насны хохирогчийг хамгаалан эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөө, холбон зуучлах үйлчилгээг холбогдох журмын дагуу үзүүлнэ.

1.6. Хамтарсан баг Хүүхэд хамгааллын тухай 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйл болон 17.1.4 дэх заалтын дагуу нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлж хүүхэд, гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах, нөхөн сэргээх

¹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2

шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэн, үйлчилгээний үр дүнг хянаж, тайлагнана.

Хоёр. Хамтарсан багийг байгуулах, дэмжих үйл ажиллагаа

2.1 Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн орон нутагт ажиллах хамтарсан багийг өрхийн эмч /эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сум/ баг-ийн хорооны нийгмийн ажилтан/ нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн, хэлэмжийн, хүүхэд гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, шаардлагатай бол цэцэрлэгийн арга зүйч, хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байгуулах тухай тогтоол гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.²

2.2. Хамтарсан багийг сум, хороо/баг-ийн Засаг дарга /цаашид- багийн ахлагч гэх/ ахалж, багаа тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.3. Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар суманд Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн, хороонд хөгжлийн нийгмийн ажилтан, багт багийн нийгмийн ажилтан /цаашид нарийн бичиг гэнэ/ ажиллана.

2.4. Хамтарсан баг шаардлагатай тохиолдолд хуульч, өмгөөлөгч, сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа, иргэний бүртгэлийн ажилтан болон хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүчирхийллийг судлах асуудлаар мэргэшсэн байгууллага, мэргэжилтний дэмжлэг, тусалцааг авна.

2.5. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг хянах, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар шийдвэр гаргана.

2.6. Хамтарсан багийн үйл ажиллагаанд сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хүүхдийн төлөө зөвлөл мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавих, чиглэл өгөх үүрэг хүлээнэ.

2.7. Аймаг, дүүрэг, нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэр бүл, хүн амын бүлэг, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн судлаач, зөвлөх бүхий мэргэжил, арга зүйн дэмжих баг ажиллуулж болно.

2.8. Хүүхдийн эрхийн ажилтан, Хүүхдийн элч хамтарсан багийн үйл ажиллагаанд хондлогийн хяналт тавьж ажиллана.

2.9. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хохирогчийг түр хамгаалах байр, хариу үйлчилгээний нэгж нь хамтарсан багтай хүчирхийллийн тохиолдол бүрт харилцан

² Гэр бүлийн хүчирхийлэлдэй дэмжих тусалцаагийн 18.4.5

уялдаатай ажиллаж, зарчмын санал, мэдээ мэдээлэл, удирдамж, хүсэлт ирүүлэх зэргээр хамтран ажиллана.

2.10. Хамтарсан багт ажиллахад хувь гишүүний, багийн гишүүний хамтын болон удирдлагын үүрэг ногдоно. Хамтарсан багийн гишүүн ажлаас гарах, өөрчлөгдөх үед ажлын мэдээллийг нууцлах, үл задруулах үүрэг хүлээх ба тухайн албан тушаалд шинээр томилогдсон хүн, уг гишүүний үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Гурав. Хамтарсан багийн зохион байгуулалт, гишүүдийн үүрэг

3.1. Хамтарсан багийн зохион байгуулалт

3.1.1. Хамтарсан баг ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайлангаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.1.2. Хамтарсан багийн гишүүдийн харьяалах тус тусын байгууллагад тухайн гишүүний үйл ажиллагааны талаар мэдээлэл, тайланг Багийн ахлагч хүргүүлж болно.

3.1.3. Хамтарсан багийн хурал төлөөлсөн болон шуурхай хэлбэртэй байна. Төлөөлсөн хурал нь тогтсон цаг хугацаанд, шуурхай хуралдаан нөхцөл байдлыг үндэслэн зарласнаар явагдана. Ажлын бус цагт зарласан хурал, уулзалтыг багийн ахлагчид заавал танилцуулж, зөвшилцөх, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

3.1.4. Багийн хуралдаан 51-ээс дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөр байна.

3.1.5. Хамтарсан багийн шийдвэр хурлын тэмдэглэлээр баталгаажна. Тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурсан байна. Хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын холбогдох баримт бичгийн хувийг хавсаргаж болно.

3.2. Хамтарсан багийн гишүүдийн үүрэг

3.2.1. Хамтарсан багийн гишүүд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид заасан тус тусын чиг үүргийг биелүүлж ажиллана.

3.2.2. Багийн ахлагч багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, багийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааны санхүүжилтийг өргөжүүлэх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

3.2.3. Нарийн бичиг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасан үүргийг хүлээхээс гадна багийн гишүүдийн чиг үүргийг хуваарилах, оролцоо, үр дүнг хянах үүрэг хүлээнэ.

3.2.4. Хамтарсан багийн гишүүд мэргэжлийн ёс зүйг баримтлан, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.2.5. Хамтарсан багийн гишүүд орон нутагтаа үйлчилгээний зураглал гаргаж, дутагдаж байгаа үйлчилгээг бий болгох, хэрэгжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

3.2.6. Хамтарсан багийн гишүүд болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, эрсдэлийг бууруулах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргийн дагуу зохих талуудтай хамтран ажиллана.

3.2.7. Хамтарсан багийн гишүүн сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч нь Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд зааснаас гадна хүүхдийн боловсролын үйлчилгээний гасралтгүй байдлыг хангана.

Дөрөв. Хамтарсан багийн үйлчилгээ

4.1. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ:

4.1.1. Хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зорчил гарахад хүргэж болох эрсдэлийг бууруулах, тохиолдлыг эрт илрүүлэх, хохирлыг багасгах, хамгаалах арга замыг бэхжүүлэх, олон нийт, байгууллага, зорилтот бүлэг, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулна.

4.1.2. урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах;

4.1.3. хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

4.1.4. гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

4.1.5. нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд, гэр бүлийн гишүүд хүчирхийлэл, гэмт хэрэг, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох;

4.1.6. хүүхэд хүмүүжүүлэх зэрэг аргыг эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нарт сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохих талуудтай хамтран зохион байгуулах;

4.2. Хариу үйлчилгээ:

4.2.1. хариу үйлчилгээ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасан үйлчилгээ байна.

4.2.2. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг сум, хорооны нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

4.2.3. Ажлын бус цагаар эмнэлэг болон цагдаагийн байгууллагад ирсэн холбогдох дуудлага, мэдээлэлтэй нийгмийн ажилтан шуурхай танилцан, бүртгэлд оруулна.

4.2.4. Хамтарсан баг зорилтот дуудлага, мэдээллийг шалган хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлтэй хүүхэд, иргэн, гэр бүлд аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээг хийнэ.

4.2.5. Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн яаралтай үед нэн даруй, бусад нөхцөлд 72 цагт багтаан үйлчилгээг маягтын дагуу төлөвлөж, үзүүлнэ.

4.2.6. Хамтарсан багийн гишүүн тухайн хүүхэд, иргэн, гэр бүлийг үйлчилгээнд хамруулах саналаа төлөвлөж, холбогдох үндэслэлийн хамт бэлтгэн багийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.2.7. Үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ, үйлчилгээний явц, ярилцлагын тэмдэглэл, үйл явцын тэмдэглэл, нотлох бусад баримтыг хавсарган үйлчилгээг баримтжуулж, нууцлалыг хадгална.

4.2.8. Хамтарсан багийн гишүүн үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авсны үндсэн дээр үйлчилгээнд гэрэл зураг авах, дуу дүрсний бичлэг хийх зэргээр баримтжуулна.

4.2.9. Нарийн бичиг Хамтарсан багийн үйлчилгээний мэдээллийн сангаас хувийн хэргийн дугаар авч, үйлчилгээний мэдээллийг оруулна.

4.2.10. Нарийн бичиг үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр зогсоох, үйлчилгээний үр дүнг үнэлэх, хувийн хэргийг хаах үед холбогдох баримтыг хавсарган, хянаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

Тав. Хамтарсан багийн үйл ажиллагааны санхүүжилт

5.1. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөө, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.2. Хамтарсан багийн үйлчилгээний зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.3-т заасан хугацаанд тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ.

5.3. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.

5.4. Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг орон нутгийн салбар зөвлөл санхүүжүүлж болно.

5.5. Энэ журмын 4.2.1-т заасан үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

5.6. Энэ журмын 5.5-т заасан зардлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санхүүжүүлэх аргачлал, жишиг зардлыг тооцож мөрдөж болно.

5.7. Үйл ажиллагаа, санхүүгийн тайланг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу тайлагнана.

Зургаа. Үйлчилгээний нууцлал

6.1. Үйлчлүүлэгчийн тулгарсан асуудал, үйлчилгээний холбоотой мэдээллийг нууцлахыг хүссэн зүйл өөрт нь эсхүл бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байх. хамтарсан багийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болохоос бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн нууцлалыг хуулийн дагуу хадгалах үүрэг хүлээнэ.


6.2. Хамтарсан баг үйлчилгээ үзүүлэхдээ "Нууцын гэрээ"-г хамтарсан багийн хуралдаанд оролцож буй, үйлчилгээ үзүүлэх явцад хамтарч буй байгууллага, хувь хүнтэй байгуулна.

6.3. Энэ журмын 6.2-т заасан гэрээ байгуулаагүйгээс хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл олон нийтэд задарсан тохиолдолд уг асуудлыг хамтарсан багаар хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

Долоо. Бусад зүйл

7.1. Хамтарсан багийн үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12.2.4 дахь заалтын дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22.1.1, 22.1.3, 22.1.4, 22.1.5, 22.1.6, 22.1.7 дахь заалтын дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт, шинжилгээ, үнэлгээ, шаардлагатай гэж үзвэл зохих тал хөндлөнгийн үнэлгээ хийнэ.

---ooOoo---



ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
Маягт ХБ 01

Тохиолдолын дугаар:
Он сар өдөр:
Нийгмийн ажилтны нэр:
Үйлчилгээний ерөнхий зорилго:

Д/д	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах хүн	Нөөц	Биелэлт
1	Зорилт 1						
2	Зорилт 2						
3	Зорилт 3						

Үйлчилгээний үр дүнд үйлчлүүлэгч, гэр бүлд гарсан ахиц, өөрчлөлт: /товч/
.....
.....
.....

Үйлчилгээний төлөвлөлтөд оролцсон :
..... /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /
..... /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /
..... /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /

Үйлчилгээг төлөвлөсөн багийн гишүүд:
..... /...../

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

Нэр:..... Албан тушаал

(гарын үсэг)

ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Маягт ХБ 02

Ярилцлага хийсэн газар: Огноо:

Ярилцаж буй хүний нэр:

Үйлчилүүлэгчтэй ямар хамаатай болох:

Ярилцлагын дугаар: _____

Ярилцлагын хэлбэр: бичлэг утсаар цахим хэлбэрээр

Эхэлсэн ___цаг ___мин

Үргэлжилсэн хугацаа: ___цаг ___мин ___сек

Ярилцлагын зорилго _____

Ярилцлагын тэмдэглэл:

--

Ярилцлага хийх явцад төрсөн нийгмийн ажилтны сэтгэгдэл:

--

.....

Цаашид үзүүлэх шаардлагатай үйлчилгээ:

Ярицлага өгөлчийн үзэж байгаагаар:

.....

Нийгмийн ажилтны үзэж байгаагаар:

.....

Дууссан _____ цаг _____ мин

.....
 /Албан тушаал/

.....
 /гарын үсэг/

.....
 /гарын үсгийн тайлал/

ҮЙЛ ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ

Маягт ХБ 03

Хувийн хэргийн код:

Огноо:

Үйл явцын нэр:

Үйл явц болсон газар:

Үйл явц өрнөсөн шалтгаан:

Үйл явцад оролцсон хүмүүс:

Оролцогчид үйл явцад ямар үүрэг гүйцэтгэсэн:

Үйл явцын тэмдэглэл:

Үйл явцын талаарх нийгмийн ажилтны дүгнэлт:

.....
 /Албан тушаал/

.....
 /гарын үсэг/

.....
 /гарын үсгийн тайлал/

ТОХИОЛДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ МАЯГТ
 Маягт ХБ 04

2 хувь үйлдэнэ.

Хувийн хэргийн код: _____ Огноо: 20__ он __ сар __ өдөр

Хаанаас: Сум/хорооны нэр:

Хааш нь: Шилжүүлэх сум /хороо/ байгууллага:

Тохиолдлын талаарх товч дүгнэлт:

Шилжүүлэх болсон шалтгаан:

Хэрэгцээ, шаардлагатай үйлчилгээний арга зүйн зөвлөмж:

Тохиолдлыг шилжүүлэх тухай мэдээлэл гэр бүлийн гишүүдэд хүрсэн эсэх
 Үйлчлүүлэгчийн ар гэр : Тийм Үгүй

..... /Албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /

Утас:

Хамаатан, төрөл саданд : Тийм Үгүй

..... /Албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /

Утас:

Хавсралтаар:

1.
2.

Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага нь Тохиолдлыг хүлээн авсан
 тохиолдлын талаарх мэдээллийг үндсэн /Албантушаал/
 үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагадаа
 БУЦАХ МАЯГТ-аар хүргүүлнэ.

Хувийн хэрэг шилжүүлсэн: /гарын үсэг/
 /Албантушаал/

..... Гарын үсгийн тайлал.
 /...../
 Харилцах
 утас:

Гарын үсгийн тайлал:
 /...../
 Харилцах утас:

ХУВИЙН ХЭРГИЙГ ХААХ

Маягт ХБ 05

Хувийн код: _____

Огноо: 20__ оны ____ сарын ____ өдөр

Үйлчилгээний төлвөлөгөө хэрэгжсэн байдал:

№	Хамруулсан үйлчилгээ	Хугацаа	Гарсан үр дүн, биелэлт	Үйлчлүүлэгчийн гарын үсэг

Хувийн хэргийг хаах болсон шалтгаан:

Хувийн хэргийг хаах талаар үйлчлүүлэгчийн бодол, сэтгэгдэл:

Хувийн хэргийг хаах талаар гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчийн бодол, сэтгэгдэл:

Дүгнэлт

Үйлчилгээ үзүүлсэн нийт хугацаа ____/жил, ____сар, ____өдөр/

Хянасан: Засаг дарга _____ /

Хявсан: Нийгмийн ажилтан _____ /

Танилцсан: Хамтарсан багийн гишүүн _____ /

Танилцсан: Гэр бүлийн гишүүн, эцэг, эх, асран хамгаалагч _____ /



НУУЦЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү гэрээг Хувь хүний нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 6 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.1.2, 23 дугаар зүйлийн 23.6, 35 дугаар зүйлийн 35.5, 42 дугаар зүйлийн 42.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтад заасан хувь хүний болон хүүхдийн нэр төр, мэдээлэл, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийг хүндэтгэх үүднээс Нэг талаас: _____ дүүргийн _____ -р хороо/сум/багийн хамтарсан багийн хуралдаанд оролцож буй _____ /цаашид А тал гэх/ _____ / РД/ -тай тал, нөгөө талаас: _____ дүүргийн _____ -р хороо/сум/багийн хамтарсан багийн ахлагч, Засаг дарга _____ нар /цаашид Б тал гэх/ харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээ нь хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж буй иргэний эрхийг хүндэтгэн Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хувь хүний нууцыг чандлан хадгалах зорилготой.

Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1. Хамтарсан багийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хувь хүний талаарх мэдээллийг гадагш задруулахгүй байх;

2.2. Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн эсхүл зайлшгүй мэдээлэх шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хамтарсан багийн гишүүдэд шуурхай өгнө.

2.3. Мэдээлэл өгсөн хүн мэдээллийн үнэн зөв эсэхийг бүрэн хариуцна.

2.4. Хамтарсан багийн хуралдаанд зөвхөн өөрт хамаатай асуудал хэлэлцэх үед оролцох ба бусад асуудал хэлэлцэх үед оролцохгүй.

2.5. Хамтарсан багийн хуралдаанд оролцохдоо үйл ажиллагааг баримтжуулан авч үлдэх, бичлэг хийх, зураг авах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх.

Гурав. Б талын эрх үүрэг

3.1 Үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдээлэл авах, дэмжлэг үзүүлэх зорилгоор А талыг хамтарсан багийн хуралдаанд оролцуулна.

3.2 Үйлчилгээний явцад үйлчлүүлэгчийн нууцлахыг хүссэн зүйл нь өөрт нь эсхүл бусад хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байгаа, хамтарсан багийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж болзошгүй тохиолдолд Б тал үйлчлүүлэгчийн нууцийг хадгалж, хамгаалах боломжгүй тухай А талд урьдчилан мэдэгдэнэ.

3.3 А талд хуралдааны ерөнхий зарчмыг танилцуулан, эрх, үүрэг, оролцоог нь тайлбарлаж өгсөн байна.

3.4 Хамтарсан багийн өөр бусад асуудлыг хэлэлцэх, өөр тохиолдол үед А талыг оролцуулахгүй байна.

3.5 Б тал нь А талын нууцлалыг хамгаалж, хадгалах үүрэгтэй.

Дөрөв. Гэрээний хариуцлага

4.1 Энэхүү гэрээ нь хоёр талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээнд заасан зүйлийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Б талыг төлөөлөн:	А талыг төлөөлөн:
.....
дүүргийн хороо/сум/багийн	дүүргийн.....
хамтарсан багийн ахлагч:	хороо/сум/ багийн хамтарсан багийн
нэр:	хуралд оролцсон:
.....	нэр:.....
Гарын үсэг	Гарын үсэг
.....
Огноо:	РД:
.....	Хаяг:
.....
.....	Утас:
.....

----oOo----

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 2 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар А/22, А/31
...12...

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн Ерөнхий газар /Тэргүүн комиссар Ө.Энхтөр/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын ерөнхий прокурорын орлогч /Төрийн хууль цаазын шадар зөвлөх Б.Амгаланбаатар/-д даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ
М.ЭНХ-АМГАЛАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон энэ журмыг баримтална.

1.3. Хуульд заасан эрх бүхий албан тушаалтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил болон эрүүгийн хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хангахад хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцлалыг хамгаалах, шуурхай байх, хамтран ажиллах, хүчирхийллийг үл тэвчих зарчмыг баримтална.

1.5. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, прокурор нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

1.6. Прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн хохирогчийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллагын Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн эрх бүхий алба хаагч хэрэгжүүлнэ.

Хоёр. Цагдаагийн байгууллагаас хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээ

2.1. Цагдаагийн төв байгууллага нь холбогдох газар, хэлтсээр дамжуулан хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.1.1. цагдаагийн алба хаагчаас гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэхдээ хохирогчтой харилцах аргачлал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2.1.2. гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх маягт, хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн талаар мэдээллийн санг бүрдүүлэх тэмдэглэл, загвар, маягыг боловсруулан, батлуулж мөрдөх;

2.1.3. хохирогчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай үйл ажиллагаа, техник хэрэгслийн талаархи төсвийг боловсруулж, бусад үйл ажиллагаатай уялдуулах;

2.1.4. цагдаагийн алба хаагчид хуульд заасан арга, тодорхой ажиллагаа, техник, хэрэгслийг ашиглан тухайн үйлдэл нь гэр бүлийн хүчирхийлэл мөн эсэхийг аль болох богино хугацаанд үйлдлийн шинж чанараар нь таних ур чадварыг сургалтаар эзэмшүүлэх.

Гурав. Гомдол, мэдээллийг шалгах явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах

3.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь тусгай дугаарын утас болон жижүүрийн шуурхай албаны утсаар гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлагыг хүлээн авахдаа хохирогч өөрөө буюу бусдаар дамжуулан, эсхүл хөрш айл, хүчирхийллийн талаар мэдсэн хүн дуудлага өгсөн эсэхийг шалгаж, тэмдэглэх бөгөөд дуудлага хүлээн авах алба хаагчид дуудлага хөтлөх бүртгэлийн загварыг мөрдүүлж, хэвшүүлнэ.

3.2. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй мэдээллийг /цаашид "гомдол, мэдээлэл" гэх /цагдаагийн алба хаагчид утсан харилцаагаар өгч байх явцад дуудлага тасарсан, эсхүл түүнийг үгүйсгэсэн шинжтэй мэдээллийг өөр хүн өгсөн тохиолдолд дуудлага хаанаас ирсэн болон хохирогчийн байгаа газрын байршлыг тогтоох, хаягаар нь тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчаар шалгуулах арга хэмжээг нэн даруй авна.

3.3. Гомдол, мэдээлэл нь хохирогчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учруулах шинжтэй бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг даруй авч, хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ.

3.4. Гомдол, мэдээлэл нь илтэд гэмт хэргийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл журмын дагуу хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулна.

3.5. Тодорхой нэг хаягаас эсхүл нэг буюу хэд хэдэн хүнээс ирүүлж байгаа гомдол мэдээллийг хянаж, эрсдэлтэй гэж үзвэл газар дээр нь биечлэн шалгана.

3.6. Гомдол, мэдээллийг амаар болон бичгээр, өөрийн биеэр, эсхүл утсан харилцаагаар хүлээн авсан дуудлагыг хуульд заасан журмын дагуу шалгахад хоёроос доошгүй цагдаагийн алба хаагч дурдсан хаяг, байршилд очих бөгөөд цагдаагийн алба хаагч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид албадлага хэрэглэхэд тактикийн ач холбогдолтойг харгалзан үзнэ.

3.7. Хохирогч болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгахдаа хүн тус бүртэй биечлэн уулзах, тодорхой орон байр, өрөө, гэр, майхан, урц, хашаанд нэвтэрч шалгах, хуульд заасны журмын дагуу үзлэг хийх гэх мэтээр ил харагдах нөхцөл байдлыг бодитой үнэлнэ.

3.8. Гомдол, мэдээлэл өгсөн хүний мэдээллийг заавал нууцлана. Хөрш айл болон зэргэлдээ оршин суугчаас гаргасан гомдол, мэдээлэлд мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.9. Цагдаагийн алба хаагч нь гомдол, мэдээллийн тухай шалгалтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэл мөн эсэхийг тухайн нөхцөл байдалд газар дээр нь ажиглалт хийх, хохирогчийн биед үүссэн ил харагдах гэмтэл, шарх, хувцасны урагдал байгаа эсэхийг шалгах, гомдол мэдээлэл гаргагчтай харилцан ярилцах хэлбэрээр явуулна.

3.10. Хохирогчоос гадна гэр бүлийн хүчирхийлэлд тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа бусад хүн тухайлбал, хамтран амьдрагч, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тодорхой шалтгаанаар гэр, орон байранд хамт амьдарч байгаа бусад хүн хохирсон эсэхийг давхар шалгана. Ингэхдээ хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах арга хэмжээг авна.

3.11. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг үнэлж, шалгасан нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нь тухайн мэдээлэл гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагад мэдээлж, хамтран ажиллана.

3.12. Цагдаагийн алба хаагч нь Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээ мэдээллийг шалгах эрх бүхий хүүхдийн эрхийн ажилтны цуглуулсан баримт сэлт, нөхцөл байдлын үнэлгээ зэрэг нь мэдээллийг шалгахад ач холбогдолтой гэж үзвэл тэднээс гаргуулан авна.

Дөрөв. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар шийдвэр гаргах

4.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн буюу үйлдэгдсэн байж болох орчинд, эсхүл хохирогчийн байгаа газарт хүрэлцэн очиж хийнэ.

4.2. Аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотных нь хүний хамгаалалтад өгөх шийдвэрийн аль нэгийг гаргана. Нэг цэгийн үйлчилгээ болон хамгаалах байр байхгүй тохиолдолд ойр дотны хүний хамгаалалтад өгөх шийдвэрийг гаргаж болно.

4.3. Цагдаагийн алба хаагч нь хүчирхийлэл үйлдэгчийг хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг таслан зогсоох арга хэмжээ авна. Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах бодит нөхцөл үүссэн тохиолдолд хуульд заасан албадлагыг тухайн нөхцөл байдалд тохируулан сонгож хэрэглэнэ.

4.4. Аюулын зэргийн үнэлгээгээр эрсдэл өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол цагдаагийн алба хаагчаас тухайн хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа нийгмийн ажилтанд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

4.5. Цагдаагийн алба хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар дараахь арга хэмжээг авна. Үүнд:

4.5.1. хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллийг бичгээр өгөх;

4.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.8-д заасны дагуу хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах;

4.5.3. шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн хүн, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын

хамгаалалтын арга хэмжээг цагдаагийн байгууллагын Гэрч, хохирогчийг хамгаалах нэгж хэрэгжүүлнэ.

4.5.4. гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмчилгээний хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна.

4.6. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн нөхцөл байдал, эрсдлийг тухайн газар дээр нь үнэлж үзсэний үндсэн дээр шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах арга хэмжээг хуульд заасны дагуу гүйцэтгэнэ.

4.7. Хэрэв хүүхэд өөрийн хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын эрсдэлийн зэрэг дунд болон өндөр нөхцөл байдал тогтоогдвол цагдаагийн алба хаагч нь хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх арга хэмжээг авна.

Тав. Зөрчлийн хэрэг бүртгэлт болон эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хохирогчийг хамгаалах

5.1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч /цаашид "алба хаагч" гэх/ прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг урьд нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэлд холбогдон шалгагдсан, шүүхээс эрхийг нь хязгаарласан, цагдаагийн байгууллагын хяналтад байгаа, хүч хэрэглэн бусдад гэмтэл учруулах гэмт хэрэг, танхайрах зөрчил үйлдэж байсан эсэхийг тодруулж, учруулж болох эрсдэлийг харгалзан үзнэ.

5.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч оргон зайлсан болон цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, хохирогчид аюул занал учруулж байгаа, эсхүл тийм нөхцөл байдал үүсгэхээр бол таслан сэргийлэх арга хэмжээг шат дараалан хүндрүүлж авах, цагдан хорих саналыг прокурорт танилцуулна.

5.3. Алба хаагч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үйлчилгээг хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.4. Алба хаагч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүчирхийлэл үйлдэгчээс хохирогчид нөлөөлөх үндэслэл үүссэн гэж үзвэл сэжигтэн, яллагдагчид таслан сэргийлэх болон албадлагын арга хэмжээ авахуулахаар прокурорт санал хүргүүлэх, эсхүл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

5.5. Алба хаагч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээ, албадлагын бусад арга хэмжээ авагдсан тохиолдолд өөрөө биечлэн тухайн баг, хороо хариуцсан цагдаагийн алба хаагчид мэдэгдэж, хяналт тавиулна.

5.6. Гэр бүлийн хүчирхийллийн эрүүгийн хэрэгт нэг мөрдөгчөөр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа гүйцэтгүүлэх, мөрдөгчийг солихгүй байх зэргээр хувь хүний нууц, аюулгүй байдлыг хангаж буй эсэхэд тухайн нэгжийн шууд удирдах дарга хяналт тавьж ажиллана.

5.7. Аюулын зэргийн үнэлгээгээр зөрчил гаргагч, эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хохирогчид бодит байдлаар аюул занал учруулах үндэслэлтэй бол хохирогчийн зөвшөөрснөөр шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн эрх бүхий нэгж өөрт нь болон амьдарч байгаа гэр, орон сууцанд нь дохиоллын систем, дуут мэдээлэл дамжуулагч суурилуулан хяналт тавьж, хамтран ажиллана.

5.8. Алба хаагчаас зөрчил гаргагчид зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад болон захиргааны журмаар баривчлах шийтгэлийг эдэлж дууссаны дараа цаашид гарах үр дагавраас хамаарч шат дараалан авах арга хэмжээний талаар сануулна.

5.9. Алба хаагчаас эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан д хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад болон тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ял эдэлж дууссаны дараа цаашид гарах үр дагавраас хамаарч шат дараалан авах арга хэмжээний талаар сануулна.

5.10. Прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах шийдвэрийг хууль болон энэхүү журамд заасан үндэслэл, журмын дагуу авсан эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлэх, хуульд заасан тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчөөс гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагад зөвлөсүгэй.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн
42.9 дугаарын тушаалын хавсралт

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан эрх зүйн туслалцаа нь эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнээс бүрдэх бөгөөд үнэ төлбөргүй байна.

Хоёр. Эрх зүйн зөвлөгөө

2.1.Эрх зүйн зөвлөгөөг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага мөн хамтарсан баг биечлэн болон утсаар цахим /мэйлээр, вэб сайтын тусламжийн булан/ хэлбэрээр үзүүлнэ.

2.2.Хэрэв хохирогч хүүхэд эрх зүйн зөвлөгөөг биечлэн авах хүсэлт гаргасан бол хүсэлтийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан энэ журмын 2.1-д заасан холбогдох байгууллагад хандаж, эрх зүйн зөвлөгөө биечлэн үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

2.3.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 0-7 настай бол түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төлөөлөх этгээд, 7 ба түүнээс дээш настай бол өөрийн саналыг харгалзан үзнэ.

2.4.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд 107, 108 дугаарын утсаар эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгнө.

2.5.Эрх зүйн зөвлөгөөг цахим хэлбэрээр үзүүлэхдээ хохирогчид тухайн нөхцөл байдалд тохирсон үйлчилгээгээр үйлчлүүлэх эрх зүйн боломжтойг зөвлөнө.

2.6.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу бүх шатны Засаг дарга хохирогч хүүхдэд эрх зүйн зөвлөгөөг цахим хэлбэрээр үзүүлэх ажлыг харъяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

2.7.Эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн байгууллага, албан тушаалтан хохирогч хүүхдийн мэдээллийг нэг бүрчлэн авч мэдээллийн сан үүсгэн, баталгаажуулна.

2.8.Хохирогч хүүхдэд эрх зүйн зөвлөгөө үзүүлэхдээ дараахь зүйлийг анхаарна:

- 2.8.1.хохирогч хүүхэдтэй зөв харьцаж, хүндэтгэлтэй хандах;
- 2.8.2.хүүхдийн сэтгэл зүй, насны онцлогт тохирсон асуултыг энгийн үгээр ойлгомжтой асуух;
- 2.8.3.хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, тусалж дэмжих;
- 2.8.4.хүүхдийг буруутгасан аливаа асуулт, үйлдэл гаргахгүй байх.

2.7.Эрх зүйн зөвлөгөө нь хохирогч хүүхдийн хэрэгцээнд нийцсэн байх бөгөөд хүүхэдтэй хүнлэг бус харилцах, нэр төрийг нь гутаан дормжлох, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

Гурав. Өмгөөллийн үйлчилгээ

3.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд заасан өмгөөллийн үйлчилгээ авах эрхтэй.

3.2.Цагдаагийн алба хаагч, төрийн бус байгууллага болон хамтарсан багийн гишүүн, нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид эрх зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд өмгөөллийн үйлчилгээ авах талаар санал болгоно.

3.3.Энэ журмын 3.2-т заасан албан тушаалтан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, өмгөөлөгчтэй холбон зуучлах ажлыг зохион байгуулна.

3.3.Өмгөөлөгч нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлнө.

3.4.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд өмгөөллийн үйлчилгээ авахад хамтарсан багийн гишүүн, сургуулийн нийгмийн ажилтан, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн ёсны төлөөлөгчийн аль нэг заавал хамт байлцана.

3.5.Өмгөөлөгч нь өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас дэмжлэг авч болно.

3.6.Өмгөөлөгч нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчтэй ураг садан болон ажил төрлийн холбоотой бол гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхээс сайн дураар татгалзах үүрэгтэй.

3.7.Өмгөөлөгч нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа олж мэдсэн үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалах бөгөөд ашиг олох, нэр хүндийг гутаах болон бусад хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

3.8. Өмгөөлөгчийн буруутай үйл ажиллагаанаас болж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд дахин хохирсон тохиолдолд хамтарсан багийн гишүүн, сургуулийн нийгмийн ажилтан, төрийн бус байгууллагын ажилтан өмгөөлөгчийн талаарх гомдлыг холбогдох байгууллагад гаргах эрхтэй.

Дөрөв. Эрх зүйн туслалцаа үзүүлэх төрийн бус байгууллагын чиг үүрэг

4.1.Төрийн бус байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.хохирогч хүүхдэд ямар туслалцаа авах боломжтойг нэг бүрчлэн тайлбарлаж, үнэн зөв мэдээлэл өгөхийг хүүхдэд ойлгуулах;

4.1.2.гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;

4.1.3."Хүүхдийн тусламжийн утас 108", "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид зөвлөгөө өгөх 107" утсыг сурталчлах, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах;

4.1.4.гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангахдаа хуульд заасны дагуу төлөөлөх;

4.1.5.хуульд заасан эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг байгууллага, албан тушаалтантай холбох.

4.2.Төрийн бус байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт сурталчилгаа явуулахдаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг санаатай болон санамсаргүй байдлаар мэдээлэхгүй байх үүрэгтэй.

4.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага нь хохирогч болон хүчирхийлэгчийн талаар мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.

Тав. Бусад

5.1. Хуульд заасан эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан эрх зүйн туслалцааны талаарх мэдээллийг гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр тус бүрээр улирал тутам нэгтгэж, дүн шинжилгээ хийж цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

---000---



**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"-ыг 1 дүгээр, "Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал"-ыг 2 дугаар, "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /тэргүүн комиссар Ө.Энхтөр/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/ нарт тус тус даалгасугай.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн
1437 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.



АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Аюулын зэргийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.3. Аюулын зэргийн үнэлгээг цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан газарт очиж хийнэ.

1.4.Аюулын зэргийн үнэлгээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг шуурхай авах болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх үндэслэл болно.

1.5.Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1."Аюулын зэргийн бага эрсдэл" гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийн зөвшөөрөлгүй уулзах, харилцаа тогтоохыг оролдсон, сэтгэл санааны дарамтад оруулсан, хүүхдийн хүмүүжилд хохирол учруулсан, эдийн засгийн дарамтад оруулсан нөхцөл байдлыг;

1.5.2."Аюулын зэргийн дунд эрсдэл" гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүдийг айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгөсөн, ятгасан нөхцөл байдлыг;

1.5.3."Аюулын зэргийн өндөр эрсдэл" гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн амь насанд нь бодитой заналхийлсэн, бие махбодид гэмтэл учруулсан, эсхүл учруулж болзошгүй, хүчирхийлэл даамжирсан, байнгын дарамтад байлгасан, хүчирхийлэл үйлдэгч нь гадны биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, эсхүл хэрэглэж болзошгүй, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг, хохирогч насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, жирэмсэн, эсхүл өөр бусад шалтгааны улмаас өөрийгөө хамгаалах чадвар хязгаарлагдмал нөхцөл байдлыг.

Хоёр. Аюулын зэргийн үнэлгээ хийх

2.1.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг удаа дараа ирүүлсэн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг тохиолдол бүрт хийнэ.

2.2.Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ хохирогчид учирсан, учирч болзошгүй эрсдэл болон орчны эрсдлийн хүчин зүйлсийг харгалзана.

Тайлбар: Орчны эрсдлийн хүчин зүйлс гэдэгт: Хохирогчийн амьдарч буй газар, орон нутаг нь төвөөс алслагдмал, дэд бүтэц хөгжөөгүй, нийтийн тээврийн үйлчилгээнээс хол, эсхүл үнэ хөлс нь өндөр, харилцаа холбоо барих боломжгүй

нөхцлөөс гадна хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах боломжийг хязгаарлаж байгаа бусад эрсдлийн хүчин зүйлсийг ойлгоно.

2.3.Аюулын зэргийн үнэлгээг "Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээний маягт, аргачлал"-ын дагуу хийх ба үнэлгээ хийх аргачлал дахь онцгой нөхцөл байдлууд нь эрсдлийн түвшний өсөлтөд шууд хамаарна.

2.4.Хүүхдийн аюулын зэргийн үнэлгээг "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, аргачлал"-ын дагуу хийх ба үнэлгээ хийх аргачлал дахь онцгой нөхцөл байдлууд нь эрсдлийн түвшний өсөлтөд шууд хамаарна.

2.5.Аюулын зэргийн үнэлгээний маягт нь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг тодорхойлох асуултуудаас бүрдэх ба цагдаагийн алба хаагч маягтыг зөвхөн өөрөө бөглөж, аргачлалын дагуу үнэлнэ.

2.6.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдлийг таслан зогсоож, хүчирхийлэл үйлдэгчийг хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдээс тусгаарлан хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсны дараа хохирогчоос асуулгын дагуу тодруулж, хүчирхийлэл үйлдэгдсэн орчин, эсхүл үйлдэгдсэн байж болох орчны нөхцөл байдлыг судлан үнэлгээ хийнэ.

2.7.Дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч нь 2 ба түүнээс дээш тооны хохирогч байгаа тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг тус бүрт нь хийнэ.

2.8.Аюулын зэргийн үнэлгээг хийхийн өмнө хохирогчийн эрх, үүргийг болон нөхцөл байдлыг үнэн зөв хариулах талаар тайлбарлан өгч, үнэлгээ хийгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээ, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг сонгоход чухал ач холбогдолтойг тайлбарлаж өгнө.

2.9.Аюулын зэргийн үнэлгээг хохирогчтой харилцан ярилцах хэлбэрээр хийх ба хохирогчийг буруутгах, нэг талыг баримтлах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавихыг хориглоно.

2.10.Цагдаагийн алба хаагч гарын үсэг зурж баталгаажуулсан аюулын зэргийн үнэлгээг хохирогчид танилцуулж гарын үсэг зуруулна. Хохирогч бичиг үсэгт тайлагдаагүй, хөгжлийн бэрхшээлтэй (сонсгол, хараа, хэл яриа г.м), үндэсний цөөнх, гадаадын иргэн зэрэг монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хохирогч өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд гарын үсэг зурахгүй байж болно. Энэ тохиолдолд цагдаагийн алба хаагч тэмдэглэлд тусгана.

2.11.Хохирогч хүүхэд 14 насанд хүрээгүй бол аюулын зэргийн үнэлгээг түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид танилцуулж, гарын үсэг зуруулна. Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хохирогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй бол гарын үсгийг зуруулалгүйгээр энэ тухай тэмдэглэлд тусгана.

2.12.Аюулын зэргийн үнэлгээгээр эрсдэл "өндөр" гэж тогтоогдсон хохирогчийн саналыг харгалзахгүйгээр сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэн, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалж, аюулгүй байдлыг шуурхай хангана.

2.13.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажилласан цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг холбогдох материалын хамт шийдвэрлүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгнө.

2.14.Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан аюулын зэргийн үнэлгээ, холбогдох материалын хамт хүлээн аваад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг нэн даруй авна.

2.15.Хүүхдэд хийсэн аюулын зэргийн үнэлгээгээр "дунд" болон "өндөр" эрсдэлтэй нь тогтоогдсон тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр харьяа гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллах арга хэмжээ авах ба хүүхдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан түр хамгаалалтаар хангана.

Гурав.Бусад

3.1.Энэ журмын хэрэгжилтэнд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

--- оОо ---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн
А/37- дугаар тушаалын 2 дугаар хавсралт:



АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ				
Байгууллагацагдаагийн газар, хэлтсийналбан тушаалтай, цолтой овогтой			
Огноо, газарон..... сар ... өдөр ...цаг... минутаймаг, дүүрэг			
Хүчирхийллийн хохирогчовог.....нэр регистр нас хүйс			
Хүчирхийлэл үйлдэгчовог.....нэр регистр нас хүйс			
Асуултын өмнөх "Тийм" эсвэл "Үгүй" гэсэн баганад оноо тавих ба "тийм" гэсэн хариултад "1"оноо, "үгүй" гэсэн хариултад "0" оноо тавина				
№	Хүчирхийллийн аюулын зэргийг үнэлэх асуулт	Тийм	Үгүй	Тэмдэглэл
1.	Хохирогч нь: <input type="checkbox"/> хөгжлийн бэрхшээлтэй, <input type="checkbox"/> өндөр настан, <input type="checkbox"/> өвчний улмаас асаргаанд байгаа, <input type="checkbox"/> хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй, <input type="checkbox"/> жирэмсэн, <input type="checkbox"/> бага насны хүүхдээ асарч байгаа. <input type="checkbox"/> бэлгийн цөөнх <input type="checkbox"/> бусад			
2	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч амиа хорлох сэдэл төрсөн, эсхүл оролдлого хийж байсан эсэх.			
3	Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг нийгмийн харилцаанаас тусгаарладаг эсэх: <input type="checkbox"/> эцэг, эх, хамаатан садан, найз нөхөдтэйгээ харилцахыг хязгаарладаг <input type="checkbox"/> гадаад орчинтой заавал хүчирхийлэл үйлдэгчээр дамжуулан харилцдаг <input type="checkbox"/> бусад			
4	Хүчирхийлэл үйлдэгч хохирогч болон түүний гэр бүлийн бусад гишүүдийг эдийн засгийн дарамт, хараат байдалд оруулдаг эсэх: <input type="checkbox"/> эд зүйл, эсхүл гэр бүлийн эд хогшлыг эвдэж устгадаг <input type="checkbox"/> эвдэж устгахаар сүрдүүлдэг <input type="checkbox"/> өр зээлд оруулах (тавиулах),			

	<input type="checkbox"/> хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халддаг <input type="checkbox"/> цалин, орлогыг хянадаг, захиран зарцуулах эрхийг хязгаарладаг <input type="checkbox"/> бусад			
5	Хохирогчийн эсрэг галт зэвсэг, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэн хүчирхийлэл үйлддэг, эсхүл үйлдэхээр заналхийлдэг эсэх.			
6	Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн амь насыг хөнөөнө гэж сүрдүүлэх, эсхүл оролдлого хийж байсан эсэх: <input type="checkbox"/> багалзуурдах, амьсгал боох, <input type="checkbox"/> түлэх, <input type="checkbox"/> усанд живүүлэх <input type="checkbox"/> морь, машинаар хөөх, авто тээврийн осолд оруулахыг завдах <input type="checkbox"/> хорт бодис хүчээр уулгах <input type="checkbox"/> согтууруулах болон мансууруулах бодис хүчээр хэрэглүүлэх <input type="checkbox"/> Бусад			
7	Хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдэд учруулах бие махбодын хүчирхийлэл даамжирч эмнэлгийн тусламж авахад хүргэсэн гэмтэл учруулж байсан эсэх, <input type="checkbox"/> хүнд <input type="checkbox"/> хүндэвтэр <input type="checkbox"/> хөнгөн			
8	Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг байнга мөрдөж мөшгидөг эсэх: <input type="checkbox"/> араас нь дагах эсвэл мөрдөх <input type="checkbox"/> мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглаж мөрдөх <input type="checkbox"/> Бусад			
9	Хүчирхийлэл үйлдэгч согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх: <input type="checkbox"/> согтуурсан, мансуурсан байдалтай байгаа, <input type="checkbox"/> согтуурах, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэдэг, <input type="checkbox"/> согтуурах мансуурах донгийн эсрэг эмчилгээнд явж байгаа болон явж байсан <input type="checkbox"/> бусад			
10	Хүчирхийлэл үйлдэгч хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүдийг гутаан доромжилдог эсэх: <input type="checkbox"/> байнга шүүмжилдэг, <input type="checkbox"/> аливаа үйлдлийг нь буруутгадаг, <input type="checkbox"/> хараах, зүхэх, хашгичих <input type="checkbox"/> нэр хоч өгдөг <input type="checkbox"/> үгүйсгэдэг <input type="checkbox"/> бусад			

11	Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдээс урьд өмнө холбогдох байгууллагуудад хандаж гэр бүлийн хүчирхийллийн талаар дуудлага, мэдээлэл өгч, хандаж байсан эсэх. <input type="checkbox"/> цагдаа, хуулийн байгууллага <input type="checkbox"/> эрүүл мэндийн байгууллага <input type="checkbox"/> төрийн захиргааны байгууллага <input type="checkbox"/> төрийн бус байгууллага <input type="checkbox"/> олон улсын байгууллага <input type="checkbox"/> бусад			
12	Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг хууль бус эсхүл хүсээгүй зүйл хийлгэдэг, хийхийг шаарддаг эсэх: <input type="checkbox"/> хулгай, дээрэм, залилан хийлгэх <input type="checkbox"/> биеийг нь үнэлүүлэх <input type="checkbox"/> хүүхэд болон асрамжинд байгаа хүнээ хүчирхийлэл үйлдэхийг хохирогчоос шахаж шаардах <input type="checkbox"/> согтууруулах, мансууруулах бодис хүчээр хэрэглүүлэх <input type="checkbox"/> бусад			
13	Хохирогч болон бусад гэр бүлийн гишүүдийг бэлгийн хүчирхийлэл, дарамтад оруулж байсан эсэх: <input type="checkbox"/> хүсээгүй үед хүчээр бэлгийн харилцаанд оруулдаг <input type="checkbox"/> хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлддэг <input type="checkbox"/> гаж, ёс бусаар бэлгийн харилцаанд оруулдаг, орохыг шаарддаг <input type="checkbox"/> хүсээгүй жирэмслэлт, үр хөндүүлэхийг шаарддаг <input type="checkbox"/> бэлгийн сэдэлтэйгээр зураг, дүрс бичлэг хийж, нийтэд ил болгохоор сүрдүүлэх <input type="checkbox"/> бусад			
14	Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг гаргасан гомдлоосоо татгалзаж байсан эсэх, <input type="checkbox"/> гомдлоо буцааж авахыг тулгадаг, <input type="checkbox"/> худал амлалт өгдөг <input type="checkbox"/> ямар нэг зүйлээр барьцаалдаг <input type="checkbox"/> өөрийг нь гэмт хэрэгтэн болгох гэх мэтээр сүрдүүлдэг <input type="checkbox"/> бусад			
15	Хүчирхийлэл үйлдэгч нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд стресс, сэтгэл санааны хямралд орж байсан эсэх: <input type="checkbox"/> урт хугацааны ажилгүйдэл, ажлаас гэнэт халагдсан <input type="checkbox"/> ойр дотны хүн нь нас барсан, <input type="checkbox"/> санхүүгийн хямрал, өр зээл, мөрийтэй тоглоомд донтсоны улмаас санхүүгийн хямралд орсон <input type="checkbox"/> бусад			
	Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг эрхшээлдээ оруулахын тулд ямар нэг			

16	зүйлээр барьцаалдаг эсэх <input type="checkbox"/> хүүхдээр дамжуулан аливаа үйлдэлд ашигладаг <input type="checkbox"/> гэр бүлийн бусад гишүүдийг ашигладаг, эсхүл барьцаалдаг. <input type="checkbox"/> санхүүгийн хараат байдалд байлгадаг <input type="checkbox"/> бусад			
17	Төв, суурингаас алслагдсан, тусламж авах боломжгүй газар, эсхүл үдэш, оройн цагаар хүчирхийлэл үйлдэгддэг эсэх.			
18	Хүчирхийлэл үйлдэгч өөрийнхөө амийг хорлоно гэж сүрдүүлдэг, эсхүл оролдлого хийж байсан эсэх.			
20	Өнгөрсөн нэг жилийн хугацаанд хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс салах оролдлого хийж байсан эсэх, энэ байдлаас болоод эргээд сүрдүүлэг заналхийлэлд өртдөг эсэх Хүчирхийлэл үйлдэгч сэтгэцийн өвчтэй эсэх: <input type="checkbox"/> сэтгэцийн өвчний түүхтэй эсэх <input type="checkbox"/> сэтгэцийн эмчилгээ хийлгэж байгаа, байсан эсэх <input type="checkbox"/> бусад			
Нийлбэр оноо				
Эрсдлийн түвшин				
<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр				
ДҮГНЭЛТ:				
ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТЭМДЭГЛЭЛ:				
Аюулын зэргийн үнэлгээ хийсэн: Цагдаагийн алба хаагч / / гарын үсэг				
Аюулын зэргийн үнэлгээтэй танилцсан: Хохирогч / / гарын үсэг				



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн
1/37 дугаар тушаалын 2 дугаар хавсралт:

ХОХИРОГЧИЙН АЮУЛЫН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Хохирогчийн аюулын зэргийг үнэлэх аргачлал нь хүчирхийллийн хохирогчдод амь нас, эрүүл мэндэд учрах эрсдлийг бодитой, шуурхай үнэлэхэд зааварчилга болно. Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээ нь хариу үйлдлийн менежмент үзүүлэхүйц мэдээллийг цуглуулсан, нарийн мэргэжлийн түвшинд хийгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдлийг таслан зогсоож, хүчирхийлэл үйлдэгчийг хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдээс тусгаарлан, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсны дараа хохирогчоос асуулгын дагуу тодруулах байдлаар үнэлгээг хийнэ.

Дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч нь 2 ба түүнээс дээш тооны хохирогч байгаа тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг тус бүрт нь хийнэ.

Үнэлгээний асуултуудыг шууд асуухаас зайлсхийж, харилцан ярилцах байдлаар тодруулж, үнэлгээг хийнэ. Хэрэв хохирогчийн хариулт тодорхой бус бол илүү лавласан асуултууд асууна. Жишээ нь: "Энэ талаараа та дахиад жаахан дэлгэрүүлж ярина уу?" эсвэл "Та үүнийг дахиад жаахан тайлбарлана уу?" гэх мэт.

Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ 20 асуулт тус бүрд "тийм" эсвэл "үгүй" гэсэн баганад оноо тавих ба "тийм" гэсэн хариулт тус бүрт 1 оноо, "үгүй" гэсэн хариулт тус бүрт 0 оноо тавина.

Жич: "тийм" гэж хариулсан тохиолдолд тухайн хариултыг тодруулах зорилгоор (дөрвөлжи) тэмдэглэгээтэй асуултыг нэмэлтээр тодруулж байгаа тул тусгайлан оноо өгөхгүй болно.

Үнэлгээг гаргаж дууссаны дараа "тийм" гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, 0-6 оноог "бага", 7-12 оноог "дунд", 13-аас дээш оноог "өндөр" гэж үнэлэх ба нийлбэр оноо гэсэн хэсэгт оноог бичиж, тохирох үнэлгээг зурж баталгаажуулна.

Тэмдэглэл хэсэгт: Тухайн хохирогчийн биеийн хэлэмж, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, хохирогчийн биед учирсан бэртэл, гэмтэл болон тухайн орчны нөхцөл байдал (Хохирогчийн амьдарч буй газар, орон нутаг нь төвөөс алслагдмал, дэд бүтэц хөгжөөгүй, нийтийн тээврийн үйлчилгээнээс хол, эсхүл үнэ хөлс нь өндөр, харилцаа холбоо барих боломжгүй нөхцлөөс гадна хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах боломжийг хязгаарлах бусад эрсдлийн хүчин зүйлс) гэх мэт ажиглалтыг тэмдэглэж, баримтжуулна.

Үнэлгээг нийлбэр оноогоор дүгнэхдээ:

1. Аюулын зэргийн үнэлгээ "бага" тохиолдолд дараахь хариу арга хэмжээг авна. Хохирогчийн шийдвэрийг нэн тэргүүнд харгалзан үзэх ба хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгч, хохирогчийн эрхийг хамгаалах арга хэмжээ авна.

2. Аюулын зэргийн үнэлгээ "дунд" тохиолдолд дараахь хариу арга хэмжээг авна. Хохирогчийн хүсэлтийг харгалзан үзэж гэрт нь байх, эсхүл хүчирхийлэл үйлдэгчтэй хамт байх шийдвэрийг нь хүндэтгэж үзнэ. Хохирогч өөрөө хүсвэл харьяа хорооны

нийгмийн ажилтан болон хамтарсан багт нь мэдэгдэж, цаашид хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдэд хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгч, хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгнө.

3. Аюулын зэргийн үнэлгээ "өндөр" тохиолдолд дараах хариу арга хэмжээг авна.

Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалахаар нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, шаардлагатай тохиолдолд төрөл садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгөх арга хэмжээг авна. Хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

Онцгой тохиолдол: Аюулын зэргийн үнэлгээ нь нийлбэр оноогоор "бага", "дунд" гэж гарсан ч доорхи тохиолдлуудад аюулын зэргийн үнэлгээг "өндөр" гэж тодорхойлж хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч, хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалах арга хэмжээ авна. Үүнд:

- хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй,
- хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, эсхүл ашиглаж болзошгүй,
- хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хэрэглэсэн
- хохирогчийг байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан. тохуурхан даажигнасан, тарчлаасан,
- хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн,
- хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан тохиолдолд аюулын зэргийн нийлбэр оноо бага гэсэн ч "дунд" болон "өндөр" гэж үнэлнэ.

Мөн хохирогчийг

- байнга зодсон,
- харгис хэрцгий хандсан,
- догшин авирласан,
- хүчирхийлэл үйлдэгч зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэсэн, даамжирсан,
- хохирогч нэн даруй хууль сахиулах байгууллага, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй тохиолдлууд орно.

Үнэлгээний дүгнэлт хэсэг: Нийлбэр оноо, цагдаагийн алба хаагчийн ерөнхий дүгнэлт болно. Үнэлгээнд тусгагдаагүй эрсдэлт хүчин зүйлсийг тэмдэглэнэ. Дэлгэрэнгүй байж болно.

Цаашид анхаарах зүйлийн тэмдэглэл хэсэгт:

Хохирогчийг хамгаалах талаар цаашид анхаарах асуудал, нэн тэргүүнд үзүүлэх үйлчилгээг санал болгосон тэмдэглэл байна.

---oOo---



ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ				
Байгууллагацагдаагийн газар, хэлтсийналбан тушаалтай, цолтой овогтой			
Огноо, газарон..... сар өдөрцаг... минутаймаг, дүүрэг			
Хүчирхийллийн хохирогч хүүхэдовог.....нэр регистр нас хүйс			
Хүчирхийлэл үйлдэгчовог.....нэр регистр нас хүйс			
Асуултын өмнөх "Тийм" эсвэл "Үгүй" гэсэн баганад оноо тавих ба "тийм" гэсэн хариултад "1" оноо, "үгүй" гэсэн хариултад "0" оноо тавина				
№	Хүчирхийллийн аюулын зэргийг үнэлэх асуулт	Тийм	Үгүй	Тэмдэглэл
1	Хохирогч хүүхэд нь: <input type="checkbox"/> хөгжлийн бэрхшээлтэй <input type="checkbox"/> хөгжлийн хоцрогдолтой <input type="checkbox"/> өвчний улмаас асаргаанд байгаа <input type="checkbox"/> бага насны <input type="checkbox"/> бэлгийн цөөнх <input type="checkbox"/> Бусад			
2	Хүүхэд нь хүчирхийлэл үйлдэгчтэй ямар холбоотой эсэх: <input type="checkbox"/> төрсөн хүүхэд <input type="checkbox"/> дагавар хүүхэд <input type="checkbox"/> өргөмөл хүүхэд <input type="checkbox"/> бусад			
3	Хүүхдийг байнга буруутгадаг, сэтгэл санааны дарамт учруулдаг эсэх: <input type="checkbox"/> нэр, хоч өгөх <input type="checkbox"/> үг хэлээр доромжлох, харааж зүхэх <input type="checkbox"/> гадуурхах <input type="checkbox"/> байнга хяналт тавих <input type="checkbox"/> бусадтай харьцуулах <input type="checkbox"/> айлган сүрдүүлэх <input type="checkbox"/> гутаах, дорд үзэх <input type="checkbox"/> бусад			

4	<p>Хүүхдийн эсрэг үл хайхрах байдал гаргадаг эсэх:</p> <p><input type="checkbox"/> хоол, хүнс, хувцас хунараар гачигдуулдаг</p> <p><input type="checkbox"/> дулаан, орон байраар гачигдуулдаг</p> <p><input type="checkbox"/> хичээлийн хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйлсээр гачигдуулдаг</p> <p><input type="checkbox"/> эмнэлэгийн тусламж, эрүүл мэндийн хэрэгцээг хангадаггүй</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
5	<p>Хүүхдийн бие махбодид ноцтой гэмтэл илэрсэн, хүчирхийллийн давтамж ойртсон эсэх:</p> <p><input type="checkbox"/> зодохоор айлгасан, сүрдүүлсэн</p> <p><input type="checkbox"/> зодсон</p> <p><input type="checkbox"/> бэртэж гэмтээсэн</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
6	<p>Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй нөхцөл байдалд байгаа эсэх:</p> <p><input type="checkbox"/> хүчээр бэлгийн харилцаанд оруулдаг, орохыг шаарддаг</p> <p><input type="checkbox"/> хүүхдийн дэргэд бэлгийн сэдэлтэй үйлдэл хийдэг</p> <p><input type="checkbox"/> бэлгийн сэдэлтэйгээр зураг, дүрс бичлэг үзүүлэх, үзэхийг шаарддаг</p> <p><input type="checkbox"/> бэлгийн хүчирхийллийн улмаас хүсээгүй жирэмслэлт, үр хөндүүлж байсан</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
7	<p>Хүчирхийлэл үйлдэгч хүүхдийг нийгмийн харилцаанаас тусгаарладаг эсэх:</p> <p><input type="checkbox"/> эцэг, эх, хамаатан садан, найз нөхөдтэйгээ харилцахыг хязгаарладаг</p> <p><input type="checkbox"/> хичээл, сургуулиас нь завсардуулсан</p> <p><input type="checkbox"/> хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаанд явахыг хориглодог (дугуйлан, сургалт, дамжаа)</p> <p><input type="checkbox"/> гадаад орчинтой харилцуулдаггүй, эсхүл заавал хүчирхийлэл үйлдэгчээр дамжуулан харилцдаг</p> <p><input type="checkbox"/> гэрийн хорионд байлгадаг</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
8	<p>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд амиа хорлох сэдэл төрсөн, эсхүл оролдлого хийж байсан эсэх:</p>			
9	<p>Хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүчирхийлэл үйлдэгчээс хүүхдийг хамгаалах чадвартай эсэх:</p> <p><input type="checkbox"/> хөгжлийн бэрхшээлтэй,</p> <p><input type="checkbox"/> өвчний улмаас асаргаанд байгаа,</p> <p><input type="checkbox"/> бага насны хүүхдээ асарч байгаа</p> <p><input type="checkbox"/> жирэмсэн</p> <p><input type="checkbox"/> согтуурах, мансуурах бодис хэрэглэдэг</p>			

	<p><input type="checkbox"/> өөрөө хүчирхийллийн хохирогч</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
10	<p>Хүчирхийлэл үйлдэгч согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг, хэрэглэсэн эсэх:</p> <p><input type="checkbox"/> согтуурсан, мансуурсан байдалтай байгаа</p> <p><input type="checkbox"/> согтуурах, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэдэг</p> <p><input type="checkbox"/> согтуурах мансуурах донгийн эсрэг эмчилгээнд явж байгаа болон явж байсан</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
11	<p>Дуудлагаар очих үед хүүхдийн байдал:</p> <p><input type="checkbox"/> гэмтэж бэртсэн</p> <p><input type="checkbox"/> айсан, түгшсэн</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
12	<p>Хохирогч хүүхдийн амь насыг хөнөөнө гэж сүрдүүлэх, эсхүл оролдлого хийж байсан эсэх:</p> <p><input type="checkbox"/> багалзуурдах, амьсгалыг нь боох,</p> <p><input type="checkbox"/> түлэх,</p> <p><input type="checkbox"/> усанд живүүлэх</p> <p><input type="checkbox"/> морь, машинаар хөөх, авто тээврийн осолд оруулахыг завдах</p> <p><input type="checkbox"/> хорт бодис хүчээр уулгах</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
13	<p>Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч хүүхдийг хүсээгүй зүйл, эсхүл хууль бус зүйл хийлгэдэг, эсхүл хийхийг шаарддаг эсэх:</p> <p><input type="checkbox"/> хулгай, дээрэм, залилан гэх мэт гэмт хэрэг хийлгэх</p> <p><input type="checkbox"/> биеийг нь үнэлүүлэх</p> <p><input type="checkbox"/> бусдад хүчирхийлэл үйлдэхийг шахаж шаардах, тулгах</p> <p><input type="checkbox"/> согтууруулах, мансууруулах бодис хүчээр хэрэглүүлэх</p> <p><input type="checkbox"/> гуйлга гуйлгах</p> <p><input type="checkbox"/> хүнд хөдөлмөр эрхлүүлэх</p> <p><input type="checkbox"/> бусад</p>			
14	<p>Хүчирхийллийн улмаас хүүхэд гэрээсээ дайжиж байсан эсэх.</p>			
15	<p>Хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс хүүхдэд учруулах бие махбодын хүчирхийлэл даамжирч эмнэлгийн тусламж авахад хүргэсэн гэмтэл учруулсан, учруулж байсан эсэх,</p> <p><input type="checkbox"/> хүнд</p> <p><input type="checkbox"/> хүндэвтэр</p> <p><input type="checkbox"/> хөнгөн</p>			
16	<p>Хүүхдийн талаар урьд өмнө доорхи байгууллагуудад хандаж, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл, дуудлага өгч байсан, хандаж байсан эсэх:</p> <p><input type="checkbox"/> цагдаа, хуулийн байгууллага</p> <p><input type="checkbox"/> эрүүл мэндийн байгууллага</p> <p><input type="checkbox"/> төрийн захиргааны байгууллага</p>			

	<input type="checkbox"/> төрийн бус байгууллага <input type="checkbox"/> олон улсын байгууллага <input type="checkbox"/> бусад			
17	Хүчирхийлэл үйлдэгч хүүхдийг барьцаалж гэр бүлийн бусад гишүүдийг олох, уулзах арга хэрэгсэл болгодог эсэх: <input type="checkbox"/> хүүхдээр дамжуулан аливаа үйлдэлд ашигладаг <input type="checkbox"/> санхүүгийн хараат байдалд байлгадаг <input type="checkbox"/> бусад			
18	Хүчирхийлэл үйлдэгч нь өөрийгөө хянах чадваргүй, хэрцгий, догшин ширүүн зан авиртай эсэх			
19	Хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдийн эсрэг галт зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэн хүчирхийлэл үйлддэг, заналхийлдэг эсэх.			
20	Төв, суурингаас алслагдсан, тусламж авах боломжгүй газар, эсхүл үдэш, оройн цагаар хүчирхийлэл үйлдэгддэг эсэх.			
Нийлбэр оноо				
Эрсдлийн түвшин				
<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр				
Дүгнэлт:				
ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТЭМДЭГЛЭЛ:				
Аюулын зэргийн үнэлгээ хийсэн: Цагдаагийн алба хаагч //гарын үсэг				
Аюулын зэргийн үнэлгээтэй танилцсан: Хохирогч /...../гарын үсэг Хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч /...../гарын үсэг Байлцсан: Хөндлөнгийн хүн /..... /гарын үсэг				

----oOo----



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
 2017 оны 2-дугаар сарын 14-ний өдрийн
 А/37 дугаар тушаалын 3 дугаар хавсралт:

ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН АЮУЛЫН ЭРСДЛИЙН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Хохирогч хүүхдийн аюулын зэргийг үнэлэх аргачлал нь хүчирхийллийн хохирогчдод амь нас, эрүүл мэндэд учрах эрсдлийг бодитой, шуурхай үнэлэхэд зааварчлага болно.

Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн үнэлгээнд хүүхдийг өөрийн гэсэн эрхтэй хувь хүн гэдгийг харгалзах нь чухал.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдлийг таслан зогсоож, хүчирхийлэл үйлдэгчийг хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдээс тусгаарлан, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсны дараа хохирогч хүүхдээс асуулгын дагуу тодруулах байдлаар үнэлгээг хийнэ.

Дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч нь 2 ба түүнээс дээш тооны хохирогч хүүхэд байгаа тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг тус бүрт нь хийнэ.

Үнэлгээ хийгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээ, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг сонгоход чухал ач холбогдолтойг тайлбарлаж өгнө.

Аюулын зэргийн үнэлгээг 7 ба түүнээс дээш насны хүүхэдтэй харилцан ярилцаж, хийнэ. Хэрэв хүүхэд 7 нас хүрээгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүдийг байлцуулан үнэлгээг хийх, хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүчирхийлэл үйлдсэн, болон хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй бол гэр бүлийн бусад гишүүд, мэргэжилтэн, хөндлөнгийн хүнийг байлцуулан хийнэ.

Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээ нь хариу үйлдлийн менежмент үзүүлэхүйц мэдээллийг цуглуулсан, нарийн мэргэжлийн түвшинд хийгдсэн байх ёстой.

Хүүхэд таньж мэдэхгүй, албаны хүнтэй ярилцахдаа айж эмээж сандрах тохиолдол илэрдэг. Энэ тохиолдолд хүүхдийг тайвшруулсны дараа ярилцаж, үнэлгээ хийнэ.

Цагдаагийн алба хаагч нь ярилцах үедээ хүүхдэд айдас, сүрдүүлэг төрүүлэхээс зайлсхийсэн нөхцөлийг бүрдүүлж, дуу хоолойны өнгө зөөлөн, хүүхдэд хүндэтгэлтэй байдлаар харилцахыг анхаарна.

Үнэлгээний асуултыг шууд асуухаас зайлсхийж, албан ёсны ярилцлага хэлбэрээр бус хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, соёлын ялгааг харгалзан, харилцан ярилцах хэлбэрээр явагдана. Хүүхдийг буруутгах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавихыг хориглоно.

Хэрэв хүүхдийн хариулт тодорхой бус бол илүү лавласан, тодруулсан асуултыг асууж болно. Хүүхэд хариулж мэдэхгүй, эргэлзэж байгаа тохиолдолд тодруулах асуултуудаас жишээ татаж асууж, ярилцана. Жишээ нь: 7-д байгаа Нийгмийн харилцаанаас тусгаарладаг уу? гэсэн асуултад "Хичээл сургуульдаа тогтмол явж чаддаг уу? Найз нөхөдтэйгөө чөлөөт цагаараа уулзах, тоглох боломж байдаг уу?" гэх мэт.

Аюулын зэргийн үнэлгээг хийж буй цагдаагийн алба хаагч нь тухайн гэр бүл дэх хүчирхийллийн мөн чанар, онцлогийг ойлгож, үнэлгээний явцад ажиглагдсан орчны нөхцөл байдал, бусад мэдээлэлд тулгуурлан бодит дүгнэлтийг гаргана.

Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ 20 асуулт тус бүрд "тийм" эсвэл "үгүй" гэсэн баганад оноо тавих ба "тийм" гэсэн хариулт тус бүрт 1 оноо, "үгүй" гэсэн хариулт тус бүрт 0 оноо тавина.

Жич: "тийм" гэж хариулсан тохиолдолд тухайн хариултыг тодруулах зорилгоор (дөрвөлжин) тэмдэглэгээтэй асуултыг нэмэлтээр тодруулж байгаа тул тусгайлан оноо өгөхгүй болно.

Үнэлгээг гаргаж дууссаны дараа "тийм" гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, 0-6 оноог "бага", 7-12 оноог "дунд", 13-аас дээш оноог "өндөр" гэж үнэлэх ба нийлбэр оноо гэсэн хэсэгт оноог бичиж, тохирох үнэлгээг зурж баталгаажуулна.

Тэмдэглэл хэсэгт: Тухайн хүүхдийн биеийн хэлэмж, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, хүүхдийн биед учирсан бэртэл, гэмтэл болон тухайн орчны нөхцөл байдал гэх мэт ажиглалтыг тэмдэглэж, баримтжуулна.

Тодруулах асуултыг бататгаж, хариултыг тэмдэглэл хэсэгт дэлгэрэнгүй бичнэ. Энэ мэдээлэл нь хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг төлөвлөх суурь мэдээлэл болно гэдгийг анхаарна уу?

Үнэлгээг нийлбэр оноогоор дүгнэхдээ:

1. Аюулын зэргийн үнэлгээ "бага" тохиолдолд дараахь хариу арга хэмжээг авна. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хохирогч хүүхэд түүний гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан сум, баг хорооны нийгмийн ажилтанд заавал мэдэгдэнэ.

Хүүхэд болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хуульд заасан эрх, үүргийг тайлбарлаж, цаашид үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгч, хохирогчийн эрхийг хамгаалах арга хэмжээ авна.

2. Аюулын зэргийн үнэлгээ "дунд" болон "өндөр" тохиолдолд дараахь хариу арга хэмжээг авна.

Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүй хүүхдийг түр хамгаалалтаар хангана. Ингэхдээ нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх, эсхүл энэ арга хэмжээг авах боломжгүй бол эцэг, эх, төрөл садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд, эсхүл хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх арга хэмжээг яаралтай авна.

Хохирогч хүүхэд долоо, түүнээс дээш настай бол эцэг, эх, төрөл садангийн болон бусад хүн, өөр гэр бүлийг сонгоход түүний саналыг харгалзана. Энэ талаараа хүүхдийн байгууллага, ажилтанд мэдээлнэ. Хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

Онцгой тохиолдол: Аюулын зэргийн үнэлгээ нь нийлбэр оноогоор "бага", "дунд" гэж гарсан ч доорхи тохиолдлуудад аюулын зэргийн үнэлгээг "өндөр" гэж тодорхойлж хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч, хохирогч хүүхдийг хамгаалах арга хэмжээ нэн тэргүүнд авна. Үүнд:

- хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй
- хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй,
- хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй,

- хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтанд оруулсан, эсхүл оруулж болзошгүй
- хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хэрэглэсэн
- хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй,
- өвчний улмаас асаргаанд байдаг, хөгжлийн бэрхшээлтэй, бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд аюулын зэргийн нийлбэр оноо "бага" гэсэн ч "дунд" болон "өндөр" гэж үнэлнэ.

Мөн хүүхдийг:

- байнга зодсон,
- харгис хэрцгий хандсан,
- догшин авирласан,
- хүчирхийлэл үйлдэгч зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэсэн,
- хохирогч нэн даруй хууль сахиулах байгууллага, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй бол аюулын зэргийн үнэлгээг "өндөр" гэж үнэлнэ.

Үнэлгээний дүгнэлт хэсэг: Нийлбэр оноо, цагдаагийн алба хаагчийн ерөнхий дүгнэлт болно.

Үнэлгээнд тусгагдаагүй эрсдэлт хүчин зүйлсийг тэмдэглэнэ. Дэлгэрэнгүй байж болно.

Цаашид анхаарах зүйлсийн тэмдэглэл хэсэгт:

Хүүхдийг хамгаалах талаар цаашид анхаарах асуудал, нэн тэргүүнд үзүүлэх үйлчилгээг санал болгосон тэмдэглэл байна.

---oO---

ТАНИЛЦУУЛГА

"Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"-ын талаар

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу "нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн түвшинг тодорхойлох" харилцааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан баталсан 128/188 дугаартай тушаалаар зохицуулж иржээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга) -ийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт "Аюулын зэргийн үнэлгээ хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу журмын төслийг шинэчлэн боловсруулав.

Тус журмыг боловсруулахад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хууль зүйн сайдын 2014 оны А/112, 113, 114, 204, Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 тушаалаар баталсан Гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний журмууд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2009 оны 128/188 дугаар тушаалаар баталсан "Нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох заавар, маяг", Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэргийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2009 оны 308/189/129 тоот тушаалаар баталсан "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам", Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хариу үйлчилгээний маяг"-ийг ашигласан болно.

Мөн журмыг төслийг дотоодын эрх зүйн актыг үндэслэхээс гадна Вьетнам Улсын хууль сахиулах, шүүх байгууллагын алба хаагчдад зориулсан "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариуцага тооцох" гарын авлага, Канад, АНУ-д ашигладаг аюулын зэргийн үнэлгээг үнэлэх гарын авлага, Шинэ Зелланд Улсын цагдаагийн байгууллагад ашигладаг Одора буюу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны заавар, ОХУ-ын хуулийн байгууллагуудад ашигладаг "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" гарын авлага, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/ -ын сургалтын гарын авлага, материал зэргийг ашиглалаа.

Аюулын зэргийн үнэлгээг нийт 20 асуулгатайгаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон насанд хүрээгүй этгээдэд тус тус боловсруулсан. Асуулга тус бүрт тийм, үгүй гэсэн хариулт өгч, "тийм" гэсэн хариулт бүрт 1 оноо, "үгүй" гэсэн хариулт бүрт 0 оноо байхаар тооцон нэмж бага, дунд, өндөр гэсэн ангиллаар аюулын зэргийн түвшинг тогтооно. Энэхүү аюулын зэргийн үнэлгээг цагдаагийн алба хаагчаас хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход ашиглана.

Тус журмыг баталсантай холбогдуулан "Нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох заавар, маяг"-ыг баталсан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2009 оны 128/188 дугаар тушаалыг хүчингүй болгоно.

--- ооо ---



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1."Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам"-ыг 1 дүгээр, холбогдох маягтуудыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/ нарт, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /Ө.Энхтөр/-т тус тус даалгасугай.

САЙД  С.БЯМБАЦОГТ



ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ ТҮР ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа талаархи мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "хүүхэд" гэж Монгол Улсын олон улсын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар;

1.3.2. "хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.8-д зааснаар;

1.3.3. "нэг цэгийн үйлчилгээний төв" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.3-т зааснаар;

1.3.4. "гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4-т зааснаар;

1.3.5. "түр хамгаалах байр" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5-д зааснаар.

1.4. Цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийг хамгаалах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.

Хоёр. Хүүхдийг түр хамгаалалтаар хангахад баримтлах нийтлэг журам

2.1. Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа талаархи мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга нь Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтаар хангахдаа хүүхэд учирсан болон учирч болзошгүй эрсдэлд хийсэн аюулын зэргийн үнэлгээг үндэслэнэ.

2.2. Аюулын зэргийн үнэлгээгээр "дунд" болон "өндөр" эрсдэлтэй гэж тогтоогдсон, эсхүл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан дараахь нөхцөл байдал байна гэж үзвэл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлаж, бодит аюул, заналхийлэл арилах хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авна:

2.2.1. хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, үйлдэж болзошгүй;

2.2.2. хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;

2.2.3. хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;

2.2.4. хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;

2.2.5. хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг бол.

2.3. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд долоогоос доош настай бол хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагаас төлөөлөгч томилж оролцуулна.

2.4. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд долоо, түүнээс дээш настай, аюулын зэргийн үнэлгээ "бага" тохиолдолд түр хамгаалалтад авахдаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэгт заасны дагуу түүний саналыг харгалзана.

2.5. Цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга нь хүүхдийг хамгаалах зорилгоор ямар арга хэмжээг хэрэгжүүлэх гэж байгаагаа хүүхэд өөрт нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүдэд урьдчилан мэдэгдэж, дараахь зохицуулалтыг тайлбарлана:

2.5.1. хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах арга хэмжээ авсан нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй талаархи Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн зохицуулалт;

2.5.2. түр хамгаалалтаар хангах арга хэмжээ авагдсан хүүхэдтэй хүчирхийлэл үйлдэгчийн уулзах, харилцах эрх хязгаарлагдах талаархи Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийн зохицуулалт;

2.5.3. Хүүхдийг түр хамгаалалтад авсан нь хүчирхийлэл үйлдэгч хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй талаархи Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.9 дахь хэсгийн зохицуулалт.

2.6. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтад авахдаа түүний бичиг баримт, сургалтын хэрэгсэл, шаардлагатай хэрэглээний эд зүйлийг гаргуулж, баримтаар хүлээж авна.

2.6. Шаардлагатай бол тухайн гэр бүлд амьдарч байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгчтэй хамаарал бүхий бусад хүүхдийг түр хамгаалалтад хамруулна.

2.7. Цагдаагийн алба хаагч, сум, багийн Засаг дарга хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх мэдээллийг сум, баг, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

2.8. Хүүхдийн түр хамгаалалтаар хангах арга хэмжээг цагдаагийн алба хаагч, сум, багийн Засаг дарга, харьяа сум, баг, хороо, боловсролын нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлнэ.

2.9. Түр хамгаалалтаар хангаж байгаа байгууллага, хувь хүн нь хүүхдийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, цаашид авах арга хэмжээний талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Гурав.Хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх

3.1.Энэ журмын 2.2-т заасан нөхцөл байдал байна гэж үзвэл цагдаагийн ажилтан, сум, багийн Засаг дарга нь мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т заасны дагуу хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлан түр хамгаалалтад авч, нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх ажлыг зохион байгуулна.

3.2.Хүүхдийн бие махбодид гэмтэл учирсан болон яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай бол эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

3.3.Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд аюулгүй байдлыг нь хангаж хүргэнэ.

3.4.Хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байранд хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж хүлээлгэн өгнө.

3.5.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх мэдээллийг сум, баг, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

3.6.Цагдаагийн алба хаагч, эсхүл сум, багийн Засаг дарга нь иргэн, байгууллагад хүүхдийг хүлээлгэн өгөхдөө Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэгт заасны дагуу баталгаажуулна.

3.6.Хүүхдийг түр хамгаалалтад авч байгаа нэг цэгийн үйлчилгээний төв нь MNS Монгол Улсын стандарт, түр хамгаалах байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартад тавигдах шаардлагыг тус тус хангасан байна.

Дөрөв. Хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх

4.1.Цагдаагийн алба хаагч, сум, багийн Засаг дарга нь хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх арга хэмжээг авах боломжгүй бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1.2-т зааснаар эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.

4.2.Хүүхэд долоо, түүнээс дээш настай, аюулын зэргийн үнэлгээ "бага" бол хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд шилжүүлэн өгөхдөө өөрийнх нь саналыг харгалзан үзнэ.

4.3.Хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүргэх гэж байгаа талаараа хүүхдэд өөрт нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүдэд урьдчилан мэдэгдэж, тайлбарлаж өгнө.

4.4.Хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлийн түр хамгаалалтад өгөхдөө Цагдаагийн алба хаагч, эсхүл сум багийн Засаг дарга аюулгүй байдлыг хангаж хүргэнэ.

4.5.Хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүлээлгэн өгөхдөө хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж, тухайн хүнд эрх, үүргийг бичгээр сануулна.

4.6.Хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан түр хамгаалалтад авсан хүн нь албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлж, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, мэдээллийг задруулахгүй байх үүргийг хүлээж ажиллана.

4.7.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүргэсэн талаарх мэдээллийг сум, баг, хорооны нийгмийн ажилтанд заавал өгч, түр хамгаалалтын арга хэмжээг боловсролын нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлж, хяналт тавина.

4.8.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж байсан хүнд хүлээлгэн өгөхийг хориглоно.

Тав.Хүүхдийг асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх

5.1.Цагдаагийн ажилтан болон сум, багийн Засаг дарга нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлан түр хамгаалалтад авч, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасны дагуу хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх ажлыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан, нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.

5.2.Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

5.3.Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад аюулгүй байдлыг нь хангаж хүргэнэ.

5.4.Цагдаагийн ажилтан болон сум, багийн Засаг дарга нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүргэх гэж байгаа талаараа асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад урьдчилан мэдэгдсэн байна.

5.5.Хүүхдийг хүлээлгэн өгөхдөө хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж, тухайн байгууллагад эрх, үүргийг бичгээр сануулна.

5.6.Хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан түр хамгаалалтад авсан асрамж, халамжийн байгууллага нь хүүхдэд үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллана.

5.7.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын түр хамгаалалтад өгсөн талаарх мэдээллийг сум, баг, хорооны нийгмийн ажилтанд заавал өгч, түр хамгаалалтын арга хэмжээг боловсролын нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлж, хяналт тавина.

Зургаа. Хүүхдийн байгууллага, ажилтанд мэдээлэх

6.1.Хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга нь хүүхдийн байгууллага, ажилтанд нэн даруй мэдээлнэ.

6.2.Хүүхдийн байгууллага, ажилтан нь тухайн хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний талаар цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг даргад эргэж мэдээлнэ.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн
А/39 дугаар тушаалын 2 дугаар хавсралт:

Маягт №1

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН, ЭСХҮЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛД БАЙГАА ХҮҮХДИЙГ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛОН ТҮР ХАМГААЛАХ БАЙР, ХҮҮХДЭД АСРАМЖ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ ТӨРИЙН, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ МАЯГТ

НЭГ. ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Байгууллагын нэр, хаяг:	
3	Албан тушаал:	
4	Утасны дугаар:	
5	И-мэйл хаяг:	

ХОЁР. ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭН АВСАН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Байгууллагын нэр, хаяг:	
3	Албан тушаал:	
4	Утасны дугаар:	
5	И-мэйл хаяг:	
6	Хүлээлгэж өгсөн бичиг баримт, бусад эд зүйл:	

ГУРАВ. ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Нас хүйс:	
	Регистрийн дугаар:	
3	Гэрийн хаяг: (үндсэн болон одоо амьдарч буй)	
4	Сургууль, анги:	
5	Ам бүл, гэр бүлийн гишүүд:	
6	Хүүхдэд туслах хүмүүсийн мэдээлэл:	
7	Утасны дугаар:	

ДӨРӨВ. ХҮҮХДЭД ТУСЛАХ ОЙР ДОТНЫ ХҮМҮҮСИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Хүүхдэд туслах хүмүүсийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил	Гэрийн хаяг	Утасны дугаар
1.					
2.					
3.					
4.					

ТАВ. ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1	Аюулын зэргийн үнэлгээ:	<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр
2	Хүчирхийллийн хэлбэр:	
3	Хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирсан эсэх:	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол ямар хохирол учирсан талаарх мэдээлэл:
4	Хүүхдийн сэтгэл зүйл байдал:	
5	Хэний зүгээс хүчирхийлэлд өртсөн:	
6	Хүчирхийлэл үйлдэгчийн овог нэр:	
7	Хүчирхийлэл үйлдэгчийн нас хүйс:	
8	Хүчирхийлэл үйлдэгчийг таньж мэдэх гадаад төрх, онцлог шинж тэмдэг:	
9	Хүчирхийлэл үйлдэгчид хуулийн хариуцлага хүлээлгэсэн эсэх:	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрвээ тийм бол ямар хуулийн хариуцлага авсан талаарх мэдээлэл:

ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, АНХААРАХ АСУУДЛУУД

Хүлээлгэн өгсөн ажилтны овог нэр, албан тушаал
_____ нэр _____ (гарын үсэг)
_____ Албан тушаал

Хүлээн авсан ажилтны овог нэр, албан тушаал
_____ нэр _____ (гарын үсэг)
_____ Албан тушаал

Огноо: _____

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
А/35 дугаар тушаалын 2 дугаар хавсралт:



Маяг 2

**ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН, ЭСХҮЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛД
БАЙГАА ХҮҮХДИЙГ ЭЦЭГ, ЭХ, ТӨРӨЛ, САДАНГИЙН БОЛОН БУСАД ХҮН, ӨӨР ГЭР
БҮЛД ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ МАЯГТ**

НЭГ. ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Байгууллагын нэр, хаяг:	
3	Албан тушаал:	
4	Утасны дугаар:	
5	И-мэйл хаяг:	

ХОЁР. ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭН АВСАН ТӨРӨЛ, САДАНГИЙН БОЛОН БУСАД ХҮН, ӨӨР ГЭР
БҮЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Нас хүйс:	
3	Хүүхэдтэй ямар хамаатай болох:	
4	Регистрийн дугаар:	
5	Гэрийн хаяг: (үндсэн болон одоо амьдарч буй)	
7	Ажлын хаяг:	
8	Ам бүл, гэр бүлийн гишүүд:	
9	Утасны дугаар1: Утасны дугаар2:	
10	Хүлээлгэн өгсөн бичиг баримт, бусад эд зүйлс:	

ГУРАВ. ХҮҮХДЭД ТУСЛАХ ОЙР ДОТНЫ ХҮМҮҮСИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Хүүхдэд туслах хүмүүсийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил	Гэрийн хаяг	Утасны дугаар
1.					
2.					
3.					
4.					

ДӨРӨВ. ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

1	Овог нэр:	
2	Нас хүйс:	
	Регистрийн дугаар:	
3	Гэрийн хаяг: (үндсэн болон одоо амьдарч буй)	
4	Сургууль, анги:	
5	Ам бүл, гэр бүлийн гишүүд:	
6	Утасны дугаар:	

ТАВ. ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1	Аюулын зэргийн үнэлгээ:	<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр
2	Хүчирхийллийн хэлбэр:	
3	Хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирсан эсэх:	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол ямар хохирол учирсан талаарх мэдээлэл:
4	Хүүхдийн сэтгэл зүйл байдал:	
5	Хэний зүгээс хүчирхийлэлд өртсөн:	
6	Хүчирхийлэл үйлдэгчийн овог нэр:	
7	Хүчирхийлэл үйлдэгчийн нас хүйс:	
8	Хүчирхийлэл үйлдэгчийг таньж мэдэх гадаад төрх, онцлог шинж тэмдэг:	
9	Хүчирхийлэл үйлдэгчид хуулийн хариуцлага хүлээлгэсэн эсэх:	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрвээ тийм бол ямар хуулийн хариуцлага авсан талаарх мэдээлэл:
10.	Хүүхдэд түр хамгаалалтын арга хэмжээний талаар мэдээлэл өгч, эрх, үүргийг нь тайлбарласан тухай тэмдэглэл	

ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, АНХААРАХ АСУУДЛУУД

Хүлээлгэн өгсөн ажилтны овог нэр, албан тушаал

_____ нэр _____ (гарын үсэг)
 _____ Албан тушаал
 Хүлээн авсан ажилтны овог нэр, албан тушаал
 _____ нэр _____ (гарын үсэг)
 _____ Албан тушаал
 Огноо: _____



**ХАМГААЛАХ БАЙРАНД ХҮҮХЭД ХҮЛЭЭЖ АВСАН
 БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

1. Үйлчлүүлэгчийн код:
2. Ирсэн өдөр:
3. Гарсан өдөр:
4. Хүргэж ирсэн болон зуучилсан байгууллага, иргэний мэдээлэл:

Утас:

д/д	Товч анкет	
1.	Овог, нэр	
2.	Нас, хүйс, регистрийн дугаар	
3.	Гэрийн хаяг, утасны дугаар	
4.	Хүүхдийн эрүүл мэндийн ерөнхий байдал	
5.	Сургууль, цэцэрлэгт хамрагдсан эсэх	
6.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан байдал	

5. Үйлчлүүлэгчийн ам бүл

№	Гэр бүлийн гишүүдийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			

6. Үйлчлүүлэгчид туслах ойр орчны хүмүүсийн мэдээлэл

№	Гэр бүлийн гишүүдийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил	Гэрийн хаяг	Утас
1.					
2.					
3.					
4.					

7.Түр хамгаалах байранд ирж байсан эсэх

1. Тийм <input type="checkbox"/> 2.Үгүй <input type="checkbox"/>				
Хэдэн удаа ирсэн	Өмнө ирсэн огноо	Хэнтэй хамт ирсэн	Ямар асуудлаар ирсэн	Ямар үйлчилгээнд хамрагдсан
	1.			
	2.			
	3.			
	4.			
	5.			

8.Бусад байгууллагын хамгаалах байранд очиж байсан эсэх.

1. Тийм <input type="checkbox"/> 2.Үгүй <input type="checkbox"/>				
Хэдэн удаа ирсэн	Өмнө ирсэн огноо	Хэнтэй хамт ирсэн	Ямар асуудлаар ирсэн	Ямар үйлчилгээнд хамрагдсан
	1.			
	2.			
	3.			
	4.			
	5.			

9.Хүчирхийлэгчийн овог нэр, нас, хүйс

.....

.....

10.Хүчирхийллийн илрэл:

.....

.....

11. Нэн тэргүүнд ямар хэрэгцээг нь шийдвэрлэх шаардлагатай байна вэ?

1/.....

.....

2/.....

.....



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
А/39 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ДУУСГАХ,
БУСАД БАЙГУУЛЛАГАД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ МАЯГТ**

20... оны... сарын... өдөр

Үйлчлүүлэгчийн тухай мэдээлэл	
1. Үйлчлүүлэгчийн код.....	5. Ирсэн өдөр.....
2. Үйлчлүүлэгчийн овог.....	6. Гарсан өдөр.....
3. Үйлчлүүлэгчийн нэр.....	7. Гэрийн хаяг.....
4. Регистрийн дугаар.....	8. Утасны дугаар.....
	9. Иргэний харьяалал.....

10. Үйлчлүүлэгчийн одоогийн нөхцөл байдал /Биед ил харагдах гэмтэл, өвчин зовиур, сэтгэл санааны байдал/

.....

.....

.....

А.Түр хамгаалах байрнаас үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээ

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээнд хамрагдсан хугацаа
1.	<input type="checkbox"/> Аюулгүй байдлыг нь хамгаалах, түр байрлуулах	
2.	<input type="checkbox"/> Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	
3.	<input type="checkbox"/> Нотлох бичиг баримт бүрдүүлэх	
4.	<input type="checkbox"/> Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	
5.	<input type="checkbox"/> Өглөө, өдөр, оройн хоол хүнсээр хангах	
6.	<input type="checkbox"/> Анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	
7.	<input type="checkbox"/> Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	
8.	<input type="checkbox"/> Чиг сэтгэлийн бүлгийн ярилцлагад оролцох	
9.	<input type="checkbox"/> Хуулийн зөвлөгөө өгөх эрх зүйн туслалцаа үзүүлэх	
10.	<input type="checkbox"/> Мэдээ мэдээллээр хангах	
11.	<input type="checkbox"/> Бусад.....	

Б. Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэсэн байдал

.....

.....

В.хүлээж авсан

тэмдэглэл:

Г. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд цаашид яаж анхаарч ажиллах талаарх тэмдэглэл
Нийгмийн ажилтан:

Хэсгийн байцаагч:

Бусад:

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТАН

/

/

ХҮЛЭЭН АВСАН:

/

/

ТАНИЛЦУУЛГА

"Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтаар хангах журам"-ын талаар


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтаар хангах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу журмын төслийг боловсруулав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга нь хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг нэн тэргүүнд хамгаалах зорилгоор хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх, энэ арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд эцэг, эх, төрөл, садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх, хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх үүрэгтэй.

"Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам"-ын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа.

Энэхүү журам батлагдснаар хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулгүй байдал бүрэн хамгаалагдах боломж бүрдэнэ.

---oOo---



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 10 сарын 12 өдөр Дугаар А/394 Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, 38 дугаар зүйлийн 38.2, 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хоёрдугаар, "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зөвлөлд журамд заасан хугацаанд мэдээ, тайланг илгээхийг Гэмтэл согог судлалын үндэсний төв /Т.Мөнхсайхан/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан саналыг үндэслэн нэг цэгийн болон сэтгэл заслын үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгаж байхын Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртоогоо/-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал, Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ  А.ЦОГЦЭЦЭГ

081273

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 10 сарын 12-ны өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийлэлд бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хэлбэрээр өртсөн хохирогч /цаашид "хохирогч" гэх/-ийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор илрүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хувь хүний нууцын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөн хэрэгжүүлнэ.
- 1.3. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөрдөн ажиллана.

Хоёр. Хохирогчийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулах зохион байгуулалт

- 2.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн, яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд, иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан түргэн тусламж, цагдаагийн байгууллагын тусгай дугаарын утас болон жижүүрийн шуурхай албаны утсаар мэдэгдэн аль ойр эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээг авахаар хандана.
- 2.2. Эрүүл мэндийн байгууллага хохирогчид журмын 2.1-д заасан мэдээллийг ямар хэлбэрээр өгснөөс үл хамааран Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.7-д заасан үйлчилгээг нэн даруй үнэ төлбөргүй үзүүлнэ.
- 2.3. Яаралтай тусламжаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хохирогчийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага стандарт, зааврын дагуу үзүүлнэ.
- 2.4. Хамгаалалтын арга хэмжээ авсан хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд тухайн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг

цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байрны оршин байгаа аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2.5. Тухайн эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний хамрах цар хүрээ, оношилгоо, эмчилгээний хүчин чадлаас давсан, лавлагаа шатны тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд холбогдох журмын дагуу шилжүүлнэ.

2.6. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, жирэмсэн, ахмад настай хохирогчдын онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.7. Хамгаалалтад авсан эрх бүхий байгууллагын дуудлага, хүсэлтийн дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллага болон нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байранд үзүүлнэ.

2.8. Хамгаалалтад байгаа эрх бүхий байгууллага хохирогчийг эрүүл мэндийн байгууллагад хүргэх, томилогдсон эмнэлгийн мэргэжилтнийг нэг цэгийн үйлчилгээний төв хамгаалах байранд очих, тусламж, үйлчилгээг үзүүлэх, буцаж ажлын байранд хүргэх үйл ажиллагааг бүрэн хариуцан, аюулгүй байдлыг бүрэн хангана.

2.9. Хамгаалалтад авсан хохирогч эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд хамгаалалтад авах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага нь эмч, эмнэлгийн ажилтан болон хохирогчид тохирсон хамгаалалтын арга хэмжээг авна.

2.10. Насанд хүрсэн хохирогчийн амь насанд нь аюултайгаас бусад тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өөрөө авахаас татгалзсан тохиолдолд "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг"-ийг хохирогчоор бөглүүлж, баримтжуулна.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын эрх, үүрэг:

3.1. Хохирогчийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, цагдаагийн байгууллага иртэл түр хамгаалан аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад байгууллагынхаа тасаг, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах;

3.2. Эрүүл мэндийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн болзошгүй эрсдэл учирсан хохирогчийн эрүүл мэндээ хамгаалуулах өргөдөл, гомдол, мэдээллийг биечлэн болон бусдаар дамжуулан гаргах нөхцөлөөр хангах, тэргүүн ээлжинд шийдвэрлэх, мэдээллийг нууцлах, задрахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах;

3.3. Эрүүл мэндийн байгууллагад байрлах нэг цэгийн үйлчилгээний нэгжийг удирдлага зохион байгуулалтаар ханган, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой зардлыг холбогдох журмын дагуу тооцож байгууллагын төсөвт тусгуулах арга хэмжээ авах;

3.4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, осол, гэмтэл, өвчлөлд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөөллийг судлах, хүчирхийллийн шалтгаант осол, гэмтэл, өвчлөлийг бууруулахад чиглэсэн зөвлөмж, мэдээллийг түгээх,

3.5. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаантай осол гэмтэл, өвчлөлийг "Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас" маягтын дагуу мэдээллийн сан үүсгэх;

3.6. Эрүүл мэндийн байгууллага өөрийн хөдөлмөрийн дотоод журам, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, нууцлалыг хамгаалах, мэдээлэл өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, багаар ажиллах үүргийг тусгах;

3.7. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаантай осол гэмтэл, өвчлөлийг бүртгэх хуудсыг бөглөх зааварчилгаа, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн арга зүйн сургалтыг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.8. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг тогтмолжуулах;

3.9. Хохирогчийн нууцыг хадгалах, хамгаалах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлэх;

Дөрөв. Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг:

4.1. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлсэн тохиолдолд болон иргэний хамгаалуулах хүсэлтийг үндэслэн нэн даруй эрүүл мэндийн байгууллагын оршин байгаа орон нутаг дүүргийн цагдаагийн байгууллагад амаар, бичгээр, утсаар, цахим хэлбэрээр мэдэгдэх;

4.2. Хохирогчийг цагдаагийн албан хаагч ирэх хүртэлх хугацаанд түр тусгаарлан хамгаалах арга хэмжээ авах;

4.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний улмаас эрүүл мэндээ хамгаалуулах иргэний хүсэлт, хүчирхийллийн болзошгүй эрсдэл учирсан байх магадлалтай гэж үзвэл нас хүйс харгалзахгүй, бичиг баримт шаардахгүй, дугаар, харъяалал харгалзахгүй, харгалзан авч яваа хүнээс тусгаарлан үзлэг хийх;

4.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, цагдаагийн байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах;

4.5. Албан үүргээ гүйцэтгэж байсантай холбоотойгоор олж мэдсэн хохирогчийн талаарх мэдээлэл, хамгаалах байрны байршлын нууцлалыг ханган, задруулахгүй байх;

4.6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, мэдээлэх, баримтжуулах, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажилтантай хамтран ажиллах, ур чадварыг эзэмших, дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтад хамрагдах;

4.7. Хохирогчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар холбогдох журмын дагуу шүүх, цагдаагийн болон зуучлагч байгууллага, албан тушаалтантай мэдээлэл солилцох;

Тав. Хохирогчийн эрх, үүрэг:

5.1. Эрүүл мэндээ хамгаалуулахаар гаргасан гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлүүлэх

5.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуумжид үнэн зөв хариулах.

Зургаа. Тайлан, мэдээ солилцох урсгал

6.1. Эрүүл мэндийн байгууллага:

1. Эрүүл мэндийн байгууллагад байрлах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалт, хүчирхийллийн шалтгаант осол, гэмтэл, өвчлөлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны талаарх бичгэн тайланг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Осол гэмтлийн тандалт, мэдээллийн үндэсний нэгжид хагас, бүтэн жилээр цахим болон цаасаар илгээнэ.

2. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаантай осол гэмтэл, өвчлөлийг "Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас"-аар бүртгэн, эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж буй цахим программаар мэдээллийн санг үүсгэн, үүссэн мэдээллийн санг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Осол гэмтлийн тандалт, мэдээллийн үндэсний нэгжид хагас, бүтэн жилээр цахимаар илгээнэ.

3. Хагас жилийн мэдээг хагас жилийн сүүлийн өдрөөр, жилийн мэдээг жилийн сүүлийн өдрөөр тасалбар болгон хагас жилийн дараа сарын 05-ны дотор, жилийн мэдээг дараа оны 01 дүгээр сарын 05-ны дотор нэгтгэн илгээнэ.

6.2. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Осол гэмтлийн тандалт, мэдээллийн үндэсний нэгж:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын бичгэн тайлан болон гэр бүлийн хүчирхийллийн шалтгаант өвчний тоон мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагад байрлах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалт, хүчирхийллийн шалтгаант осол, гэмтэл, өвчлөлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны талаарх бичгэн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж Эрүүл мэндийн яаманд цахимаар болон бичгээр хүргүүлнэ.

2. Хагас жилийн мэдээг тухайн жилийн 07 дугаар сарын 07-ны дотор, жилийн мэдээг дараа оны 01 дүгээр сарын 07-ны дотор нэгтгэн илгээнэ.

6.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, мэдээллийн сангаас осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судалж, холбогдох мэдээ судалгааг хагас, бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд цахим болон бичгээр хүргүүлнэ.

2. Хагас жилийн мэдээг хагас жилийн дараа сарын 10-ны дотор, жилийн мэдээг дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор нэгтгэн илгээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж болно.

6.5. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон бусад байгууллага хооронд холбогдох журмын дагуу солилцоно.



Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Сэтгэлзүйн цочмог хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг /айдсын эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэг/ - т өртсөн хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

1.3 Сэтгэл заслын үйлчилгээг сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн эсхүл сэтгэл заслаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмч үзүүлнэ.

1.4 Хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөн хэрэгжүүлнэ.

1.5 Сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн нэр төр, эрхийг хүндэтгэн нас, хүйс, яс, үндэс, нийгмийн гарал, боловсрол шашин шүтлэг, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй байх;
- Үйлчлүүлэгчийн амь нас эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах;
- Үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах, нууцыг чандлан хадгалах;
- Үйлчлүүлэгчидтэй үр дүнтэй харилцаа үүсгэх
- Үйлчлүүлэгчийг тэвчээртэй сонсох
- Үйлчлүүлэгч бүрийг хувь хүн талаас нь сайн ойлгох
- Үйлчлүүлэгчдэд тохирсон зөвлөгөө өгөх
- Үйлчлүүлэгчтэй эргэх холбоо үүсгэх

Хоёр. Хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

2.1 Үйлчлүүлэгчийн оршин сууж буй нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага /сум, өрхийн эрүүл мэндийн төв/ нь сэтгэцийн тулгамдсан асуудал буюу сэтгэлзүйн цочмог хариу урвалууд илэрсэн, тус журмын 1.2-т заасан

хохирогчид сэтгэц зан үйлийн эмгэгийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж, сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.

2.2 Шаардлагатай тохиолдолд аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд шилжүүлж төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2.3 Үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ мэргэшсэн сэтгэцийн эмч үйлчлүүлэгчдээс асуумж ярилцлага авч, эмнэлзүйн үзлэг хийж, илэрч буй сэтгэцийн эмгэгийн эмнэлзүйн шинжүүдийг үнэлэн одоогийн сэтгэцийн байдлыг тогтооно.

2.4 Эмгэг сэтгэл судлалын болон сэтгэлзүйн оношилгоо хийж, өвчний олон улсын Х ангиллын V бүлгийн шалгуурыг баримталж эмнэлзүйн оношийг тавина.

2.5 Хохирогчдын сэтгэцийн байдалд тохирсон сэтгэл засал /өөрийгөө сургах дасгал, ганцаарчилсан сэтгэл засал, сэтгэц танин мэдэхүйн сэтгэл засал, бүлгийн сэтгэл засал, гэр бүлийн сэтгэл засал/ эмчилгээг стандартын дагуу хийнэ.

2.6 Сэтгэл заслын тусламж, үйлчилгээг амбулаторийн болон эмнэлгийн нөхцөлд явуулна.

Гурав. Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг:


3.1 Сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын 4 дэх заалтын эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүргийг мөрдөн ажиллана.

Дөрөв. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг:

4.1 Үйлчлүүлэгч сэтгэл засал эмчилгээнд сайн дураараа оролцох

4.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуумжид үнэн зөв хариулах;

4.3 Үйлчлүүлэгч өөрт хамааралтай мэдээллийг аль байгууллагад ямар зорилгоор дамжуулах гэж байгааг мэдэх, зөвшөөрсөн бол зөвшөөрлийг бичгээр өгөх.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд /цаашид "хохирогч хүүхэд" гэх/-д эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэлзүй, сэтгэл засал, нийгмийн ажлын тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хүчирхийлэлд өртсөн хохирогч, өртөх эрсдэл бүхий хүүхдийг илрүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэлзүй болон нийгмийн ажлын тусламж, үйлчилгээ үзүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэргийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөн хэрэгжүүлнэ.

1.3. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөрдөн ажиллана.

Хоёр. Хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

2.1. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ өөрт нь болон эцэг, эх, асран хамгаалагчид үзлэгийн талаар мэдээлэл өгч, тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр бүтэн биеийн үзлэг хийнэ. Шаардлагатай тохиолдолд ганцаарчлан ярилцаж, үзлэг хийнэ.

2.2. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй, өртөх эрсдэлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хүүхэдтэй эелдэг харилцаж, хүндэтгэлтэй хандах;
- Хүүхэдтэй ярилцах үедээ хүүхдийн хөгжил, сэтгэл зүй, насны онцлогт тохирсон энгийн үг, хэллэг хэрэглэх;
- Хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийг буруутгасан үг хэлэх, хандлага, үйлдэл гаргахгүй байх;

2.3. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг цагдаагийн албан хаагч, хамтарсан баг, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагад өгнө.

2.4. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа талаар хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүдэд тайлбарлан таниулна.

2.5. Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг стандарт, зааврын дагуу үзүүлэн баримтжуулна.

2.6. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд яаралтай болон бусад эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсний дараа тусгай хамгаалалтаар хангах эрх бүхий байгууллагын албан хаагчид дахин мэдэгдэж, хүлээлгэн өгнө.

Гурав. Хохирогч хүүхдэд сэтгэл засал, сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх

Сэтгэл зүйч хохирогч хүүхдэд дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.1. Хүүхдэд тулгарсан сэтгэцийн хөнгөн хэлбэрийн тулгамдсан асуудлыг даван туулах чадавхийг дээшлүүлэх, эргэн хэвийн амьдралдаа ороход нь дэмжин, тусална.

3.2. Хүүхдийн онцлог, сэтгэл санааны байдлыг үнэлж, анхан шатны тайвшруулах, богино болон урт хугацааны шаардлагатай сэтгэлзүйн үйлчилгээг үзүүлнэ.

3.3. Хүүхдэд ганцаарчилсан, гэр бүлийн гишүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.

3.4. Үйлчлүүлэгч болон түүний гэр бүл, бусад холбогдогч талуудад сэтгэл зүйн боловсрол олгох зөвлөгөө, мэдээлэл өгнө.

3.5. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангахын тулд шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтнүүд /эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, цагдаа, багш, сэтгэцийн эмч, бусад сэтгэл зүйчид гэх мэт/-тэй хамтран ажиллах, холбон зуучилна.

3.6. Хүнд хэлбэрийн сэтгэл гутрал, амиа хорлох оролдлого, бодол санаа төрсөн хүүхдийг Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Хүүхэд өсвөр үеийн клиникт шилжүүлнэ.

Сэтгэл засалч хохирогч хүүхдэд дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.7. Сэтгэцийн байдалд тохирсон эмчилгээг стандарт зааврын дагуу хийнэ.

3.8. Эмчилгээний үр дүнг сайжруулах зорилгоор хүчирхийлэлтэй орчинд амьдарч байгаа хүүхдийг тусгаарлан эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчилнэ.

3.9. Гэр орны хүчирхийлэлтэй орчныг арилгахад чиглэн хохирогч хүүхдийн амьдран суугаа хорооны хамтарсан баг /Засаг дарга, цагдаагийн болон нийгмийн ажилтан/-т мэдээлэл өгч холбон зуучилна.

3.10. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн хохирогч хүүхдийн аюулгүй байдал, нууцлалыг хангана.

3.11. Хорооны хамтарсан багт эмчилгээ, үйлчилгээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл зөвлөгөө өгнө.

3.12. Хамтарсан багийн нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ, хохирогч хүүхдийн гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө гаргахад нь санал, зөвлөгөө гарган хамтран ажиллана.

3.13. Хүчирхийллийн орчинг арилгахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг харгалзан цаашид анхаарах асуудлаар хамтарсан багт зөвлөгөө, мэдээлэл өгнө.

Дөрөв: Эрүүл мэндийн нийгмийн ажлын тусламж, үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдэд дараах эрүүл мэндийн нийгмийн ажлын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- 4.1. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхэд, тэдний асран хамгаалагчдыг мэдээллээр хангах;
- 4.2. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээг журмын дагуу хийх;
- 4.3. Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, мэдээлэл өгөх;
- 4.4. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаарх мэдээллийг эцэг, эх, асран хамгаалагч, багш, холбогдох бусад ажилтанд өгөх;
- 4.5. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
- 4.6. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдэд тусламж үйлчилгээ хүргэдэг эмнэлгийн бусад ажилчдыг чадавхижуулах сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
- 4.7. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах;
- 4.8. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхэд хэвтэн эмчлүүлээд гарах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч дуусах үед цаашид анхаарах асуудлын талаар хохирогч болон түүний гэр бүл, хорооны хамтарсан багт зөвлөгөө өгөх;
- 4.9. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдийн тоо мэдээ, судалгаанд үндэслэн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /тэргүүн комиссар Ө.Энхтөр/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/ нарт үүрэг болгож, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д зөвлөсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д даалгасугай.

4. Энэ журмыг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 01 дугаар сарын 31-ны
өдрийн А/25 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ СТАТИСТИК
МЭДЭЭЛЭЛ, ТОО БҮРТГЭЛ ХӨТӨЛЖ, МЭДЭЭЛЛИЙН
САН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн санг хариуцах байгууллага, түүний үүргийг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Байгууллага тус бүр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ олж авсан тоо бүртгэлийн мэдээллийг тусгайлан боловсруулсан програм хангамжид бүртгэнэ.

Хоёр. Мэдээллийн сан түүнийг хариуцах байгууллага

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15.1.3-т заасан буюу нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах мэдээллийн санг бүрдүүлнэ.

2.2. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.3. Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.1-д заасан дараах мэдээллийн санг бүрдүүлнэ. Үүнд:

- а) түр хамгаалан байрлуулах үйлчилгээний;
- б) сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээний;
- в) нийгмийн халамжийн үйлчилгээний;
- г) хүүхэд хамгааллын үйлчилгээний.

2.4. Цагдаагийн байгууллага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25.1.1-д заасан дараах мэдээллийн санг бүрдүүлнэ. Үүнд:

а) цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн;

б) хүчирхийлэл үйлдэгчийн;

в) хохирогчийн;

г) гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, түүний шийдвэрлэлтийн;

д) гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийн;

е) авсан арга хэмжээний.

**Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл,
мэдээллийн сан хариуцсан байгууллагын чиг үүрэг**

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. энэ журмын дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл, статистик мэдээллийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12.1.4-т заасны дагуу хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2.6-т заасан мэдээллээс гадна хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийг хүлээн авч, ажлын чиглэл хүргүүлэх.

3.2. Мэдээллийн сан хариуцсан байгууллагууд энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. хариуцсан мэдээллийн сангаас гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл, статистик мэдээллээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг хагас, бүтэн жилээр хангах;

3.2.2. бүртгэгдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, баяжилт хөдөлгөөн хийх, хадгалах;

3.2.3. гэр бүлийн хүчирхийллийн тоо бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэлт, ашиглах журмыг байгууллага тус бүр дотоод журмаараа зохицуулж, хяналт тавих;

3.3. Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах, задруулахыг хориглоно.

Дөрөв. Мэдээлэл солилцох

4.1. Энэ журамд заасан байгууллагууд, хамтарсан баг нь бусад байгууллага болон өөр хоорондоо гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг солилцохдоо хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг баримтална.

-оОо-



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 0.1 дугаар сарын 31-ны
өдрийн А/25 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ХУУЛЬ САХИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хууль сахиулах болон холбогдох бусад байгууллагууд мэдээлэл солилцож Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийг мэдээллээр ханган, хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, түүний хэрэгжилтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагууд мэдээлэл солилцох журам нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэ журмаас бүрдэнэ.

1.3. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх энэхүү журамд заасан мэдээллийг нэгтгэн боловсруулах хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл хэрэгжүүлнэ.

1.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлд хүргүүлэх мэдээ, тайланг тогтоосон маягтын дагуу дараах хугацаанд цахим болон бичгээр хүргүүлнэ. Үүнд:

1.4.1.сарын мэдээг дараа сарын 10-ны дотор;

1.4.2.улирлын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор;

1.4.3.хагас жилийн мэдээг хагас жилийн дараа сарын 10-ны дотор;

1.4.4.жилийн мэдээг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор.

1.5. Энэ журмын 1.4-т заасан мэдээний маягтын загварыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл батална.

1.6. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага дахь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээллийн санд байгаа мэдээллийг солилцох, ашиглахад Монгол Улсын Засгийн газрын 212 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам"-ыг баримтална.

Хоёр. Мэдээлэл солилцох, тайлагнах

2.1. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагууд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу энэхүү журамд заасан мэдээллийг харилцан солилцож, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тайлагнана.

2.2. Дор дурдсан төрийн байгууллага, албан тушаалтан болон хамтарсан баг хуульд заасан үүргийн дагуу хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ. Үүнд:

2.2.1. хамтарсан багийн мэдээ, тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

а) гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан талаар;

б) хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар;

в) нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөөлөн хэрэгжүүлсэн ажлын талаар;

г) хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг чиглэлээр хийсэн ажлын талаар.

2.2.2. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

а) харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаарх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан талаар;

б) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэж чиглэл өгсөн талаар;

в) сум, хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан талаар.

2.2.3. бүх шатны Засаг даргын тайланд дараах агуулга тусгагдсан байна. Үүнд:

а) харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан талаар;

б) хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн ажлын талаар;

в) иргэдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан талаар;

г) хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн талаар.

2.3. Дараах төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар Зөвлөл болон прокурорын байгууллага ажлын тайланг хагас, бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлд хүргүүлнэ.

2.3.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

а) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулсан талаар;

б) олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан талаар.

2.3.2. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

а) түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулсан талаар;

б) асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хэрэгжилтэд хяналт тавих ажлын талаар.

2.3.3.Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

I. Боловсролын чиглэлээр:

а)боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан талаар;

б)гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, үйлчилгээ, туслалцаа дэмжлэг үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх талаар хийсэн ажлын талаар;

II. Соёлын чиглэлээр:

а)хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулсан талаар;

б)хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоож ажилласан талаар.

2.3.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тайланд дараах агуулгыг тусгасан байна.

а)хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий эмнэлэгт ажиллах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан талаар;

б)нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох мэдээ, судалгааг мэдээллийн санд оруулсан талаар;

в)гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтыг зохион байгуулсан ажлын талаар;

2.3.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар Зөвлөлийн тайланд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

а)нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын талаар;

б)хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтныг давтан сургасан, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан ажлын талаар;

в) хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан, туслалцаа дэмжлэг үзүүлсэн ажлын талаар;

г)энэ журмын 2.2.2-2.2.3-д заасан мэдээг хүлээн авсан талаарх танилцуулга.

2.3.7.Прокурорын байгууллагын мэдээ, тайланд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хяналт тавьж ажилласан талаар тусгана.

2.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл жилийн ажлын тайланг Засгийн газарт хүргүүлэхдээ дараах агуулгыг тусгана. Үүнд:

2.4.1.энэ журмын 2.3.1-2.3.9-д заасан ажлын нэгдсэн танилцуулга;

2.4.2.салбар хоорондын хамтын ажиллагааг хэрхэн уялдуулан зохицуулж ажилласан талаар;

2.4.3.хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийсэн талаарх мэдээлэл, гаргасан зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ажлын талаар.

2.5. Энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан мэдээллийн талаар Засгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл нь шүүх эрх мэдлийн, хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэх болон бусад байгууллагуудын тухайн мэдээлэлд шууд хамаарах нэмэлт лавлагаа, тооцоо, аргачлал, тайлбар, тодруулгыг харилцан гаргуулан авч болно.

2.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан ажил, арга хэмжээг хугацаанд нь энэ журамд заасан эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүргүүлнэ.

2.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллага албан тушаалтнаас өгсөн чиглэлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тайлагнах үүрэгтэй.

Гурав. Мэдээлэл солилцох, тайлан мэдээний хөтлөлт, хадгалалт, ашиглалт

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл нь гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн урсгалын хэвийн нөхцөл, нууцлалыг хангах ажлыг хариуцан зохион байгуулна.

3.2. Шүүх эрх мэдлийн, хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэх болон бусад байгууллагууд нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, энэ журамд заасан мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийн санд бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

3.3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаархаас бусад мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж болно.

3.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл солилцох, тайлагнах явцад төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагаанд Архивын тухай хуулийг мөрдлөг болгоно.

Дөрөв. Мэдээлэл солилцох, тайлагнахад хориглох зүйл

4.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл солилцох, тайлагнахад дор дурдсан зүйлсийг хориглоно. Үүнд:

4.1.1. мэдээллийг хууль бусаар ашиглах, хувийн ашиг сонирхлоор хэрэглэх, бусдад дамжуулах;

4.1.2. төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

4.1.3. тайлан, мэдээ, мэдээллийг хуурамчаар гаргаж өгөх, эсхүл тайланг энэхүү журмын 1.4 дэх хэсэгт заасан хугацаанаас хожимдуулах.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

-оОо-



**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /тэргүүн комиссар Ө.Энхтөр/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/ нарт тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 02 дугаар сарын 14-ны
өдрийн 12 дугаар тушаалын
хавсралт

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үеийн аюулгүй байдалд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгч болон ажилтнуудын аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

1.3.Нэг цэгийн үйлчилгээний төв нь MNS Монгол Улсын стандартаар тавигдах шаардлагыг хангасан байна.

1.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн байр нь хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн гишүүн байрлах тусгай өрөөнүүдтэй байна.

1.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үйлчилгээг нэг цэгийн төвөөр үзүүлэх үед тухайн төвийн харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан аюулын зэргээс шалтгаалж аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Хоёр. Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны аюулгүй байдлыг хангах

2.1.Нэг цэгийн үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хөдөлгөөнт болон явган эргүүлийн чиглэлд тусгаж, хяналтад байлгана.

2.2.Төвийн аюулгүй байдлыг хянах зорилгоор дотор болон гадна орчныг хамруулсан телекамерыг 24 цагийн хяналтад байхаар зохион байгуулна.

2.3.Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага харьяаллын дагуу дуудлагаар тэргүүн ээлжинд шуурхай үйлчилж, шаардлагатай тохиолдолд хойшлуулшгүй ажиллагааг явуулна.

2.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан нь дараах үүрэгтэй:

2.4.1.үйлчлүүлж байгаа иргэнд хууль тогтоомж, төвийн дотоод журам мөрдөхийг шаардах;

2.4.2.бусдад хор уршиг учруулж болзошгүй эд зүйл, материал байгаа эсэхийг шалгах;

2.4.3.төвөөр үйлчлүүлэгчдийн бүртгэл, тэмдэглэлийг хөтөлж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулах;

2.4.4.үйлчлүүлэгчийн болон мэдээллийн аюулгүй байдлын нууцлалыг хангаж, баримт материалыг баталгаатай, аюулгүй газар хадгалах;

2.4.5.үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллийг өгөх.

—oOo—

ТАНИЛЦУУЛГА

"Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам"-ын талаар

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга) –ийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт "Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу журмын төслийг боловсруулав.

Журмын төслийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүл мэндийн сайдын 2010 оны 68 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг Цэгийн Үйлчилгээний түр удирдамж, Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэргийн, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2009 оны 308/189/129 тоот тушаалаар батлагдсан "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам", Цагдаагийн байгууллагын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх журам зэрэг эрх зүйн актад нийцүүлэн боловсрууллаа.

Тус журмаар нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллагаас хяналт тавих хүрээ, зохион байгуулалтын арга, талуудын хамтран ажиллах хэлбэрийг зохицуулна.

Энэхүү журам батлагдснаар аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд хамрагдсан хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал бүрэн хамгаалагдах боломж бүрдэнэ.

—oOo—

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 03 сарын
27-ний/ны өдөр

Дугаар А.51.1.А.69

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/ нарт даалгасугай.



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид хороо гэнэ/-ны бүрэлдэхүүн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд энэ журам болон Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөнө.

1.3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу аймаг дүүргийн Засаг дарга, тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймаг, дүүрэгт байгуулна. Сум дундын шүүх ажиллаж байгаа сумдад тус хороог байгуулан ажиллаж болно.

1.4. Хорооны хурлыг улирал тутам зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдаж, шийдвэр гаргана. Шийдвэр нь хурлын тэмдэглэлээр баталгаажна.

Хоёр. Хорооны үйл ажиллагааны зарчим

2.1. Хороо нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно.

2.1.1. хүүхдийн эрх, нэр төрийг хүндэтгэх;

2.1.2. хүүхдийн дээд ашиг сонирхолыг эн тэргүүнд ханган хамгаалах;

2.1.3. гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд болон гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, зөвлөгөө нь мэргэжлийн, чадварлаг байх;

2.1.4. хорооны үйл ажиллагаанд хүүхдийн болон хөндлөнгийн оролцоог хангах;

2.1.5. байгууллага болон хувь хүний нууцад хамаарахаас бусад асуудлаар хорооны үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх;

2.1.6. хүүхдийн хувийн халдашгүй байдлыг хүндэтгэж, нууцыг хадгалах;

Гурав. Хорооны нийтлэг чиг үүрэг

3.1. Хороо нь зөрчил, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед болон дараагийн шатанд хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдийн эрх ашгийг ханган хамгаална.

3.2. Хороо нь гэмт хэрэг үйлдэж, шүүхээс эрүүгийн хариуцлага /өсвөр насны хүнд оногдуулах ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ/ хүлээлгэсэн хүүхдийг холбогдох байгууллага /шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх/ -аас хүлээн авч дараах шаардлага хангасан зөвлөгөө, туслалцаа, дэмжлэгийг үзүүлнэ.

- 3.2.1. хүүхдийн нас биед тохирсон байх;
- 3.2.2. эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзах;
- 3.2.3. нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах;
- 3.2.4. боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох;
- 3.2.5. үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн хор уршгийг нь ухамсарлуулах;
- 3.2.6. бусдад учруулсан хохирол гэм хорыг арилгахад хүүхдийг

оролцуулах;

3.2.7. гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг судлан, сөрөг нөлөөнөөс тусгаарлах;

3.2.8. хүүхдийн хүсэл сонирхолд нийцсэн байх;

3.3. Хороо нь хүүхдийг нийгмийн хэвийн амьдралд эргэн ороход туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа тухайн аймаг, дүүргийн харьяат хүүхэдтэй эргэх холбоо тогтоон, сургалт хүмүүжлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.4. Хороо нь гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг зөрчил, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллагатай хамтран ажиллана.

3.5. Хороо нь хүүхдийг зөрчил, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах дараах арга хэмжээг авна:

3.5.1. хууль зөрчсөн хүүхдэд шүүхээс оногдуулж болох баривчлах, цагдан хорих арга хэмжээг эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг эрмэлзэх;

3.5.2. өсвөр насны хүнийг түүний эцэг эх, хууль ёсны төлөөлөгчийн хяналтанд өгөх, хяналтандаа авсан этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоож өгөх, бусад тохиолдолд хорооны даргын шийдвэрийг үндэслэх.

3.5.3. өсвөр насны хүний байцаалт нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх;

3.5.4. өсвөр насны хүний оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзвэл байцаалтанд сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтныг заавал оролцуулах;

3.5.5. өсвөр насны хүнийг байцаах, шүүн таслах ажиллагаанд урьдчилан бэлтгэх, хэргийн оролцогчдын бүрэн оролцох боломжийг бүрдүүлэх, хүүхдийг байцаалтад дуудахдаа тэдгээрийн эцэг эх хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудах, байцаалтанд хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах ба өсвөр насны хүн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг тайлбарлаж өгөх;

3.5.6. хэргийн материалыг хүүхэд, эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчид хамтад нь танилцуулах эсхүл өсвөр насны хүнд хохирол учруулж болзошгүй тохиолдолд хэргийн материалыг танилцуулахгүй байж болно.

3.5.7. хүүхдийн хэргийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад насанд хүрээгүй хүний эрх ашгийг хамгаалах, энэ талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.6. Хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжүүлэх, төлөвшүүлэх зорилгоор хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн дараах арга хэмжээг сонгон хэрэгжүүлнэ.

3.6.1. боловсрол, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаан, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох;

3.6.2. сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд урт болон богино хугацааны сэтгэл заслын эмчилгээ хийх;

3.6.3. эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

3.6.4. хорт зуршлаас ангижруулах эмчилгээнд хамруулах;

3.7. Хүүхдийн хэргийг шийдвэрлэхдээ хүүхдийн өмгөөлөгч, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, тухайн хүүхдийг сайн мэдэх бусад этгээдийг заавал оролцуулах боломжийг хангахын төлөө ажиллана.

3.8. Хууль зөрчсөн хүүхдийг дахин хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

3.9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дээрх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийн гэр бүл, оршин суугаа газрын баг, хорооны хамтарсан багтай байнгын харилцаа холбоотой байж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.10. Хууль зөрчсөн хүүхдийг хүмүүжүүлж нийгэмшүүлэх үйл ажиллагаанд бусад байгууллагуудыг татан оролцуулах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар хамтран ажиллана.

Дөрөв. Хорооны бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн үүрэг

4.1. Хороог тухайн шатны Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга ахална.

4.2. Хорооны дарга нь гишүүдийн ажил үүргийг хуваарилах, ажлын төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах, хорооны хурлыг удирдах, тайлан мэдээллийг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах, шаардагдах төсөв санхүүжилтийг холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.

4.3. Хорооны гишүүнээр аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, аймаг, дүүргийн Шүүхийн Тамгын газрын төлөөлөл, аймаг, дүүргийн прокурор, сум дундын ахлах прокурор, Цагдаагийн газар/хэлтэс/-ын дарга, Боловсрол, соёлын газар/хэлтэс/-ын дарга, Эрүүл мэндийн газар/нэгдэл/-ын дарга, Хөдөлмөр, нийгмийн халамжийн газар/хэлтэс/-ын дарга, Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч, хүүхэд, гэр бүлд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөл ажиллана.

4.4. Хорооны ажлын алба нь аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байх ба дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.4.1. хорооны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

4.4.2. хорооноос хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих;

4.4.4. хорооны үйл ажиллагаа болон иргэд байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтэй холбоотой мэдээллийг хүлээн авч хорооны дарга, хорооны гишүүдэд танилцуулах;

4.4.4. хорооны хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, холбогдох баримт бичгийн төслийг боловсруулах, албажуулах, сурталчлах, хорооны албан хэрэг хөтлөлт, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

4.4.5. хорооны гишүүд болон хамтран ажилладаг байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах ажлыг зохион байгуулах;

5.4.6. аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрийн дэргэд гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхдэд тусламж үзүүлэх байртай байна.

4.5. Аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ.

4.5.1. хорооны үйл ажиллагааг орон нутгийн хүүхдийн зөвлөл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаатай холбох, хамтран ажиллах боломжоор хангах;

4.5.2. хорооны үйлчилгээнд хамаарч буй хүүхдийн талаар Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хороог төлөөлж асуудал дэвшүүлж, шийдвэрлүүлэх;

4.5.3. хорооны хуралд оролцож санал гаргах, үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, хорооны тайлан мэдээ хүлээн авах, хорооны бодлого,

чиглэлийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бодлого, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөвт тусгах;

4.6. Шүүхийн Тамгын газрын төлөөлөл дараахь байдлаар оролцоно.

4.6.1. хүүхдийн хэргийг дагнан шийдэх шүүгчийг томилон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд оролцсон хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

4.6.2. хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хүүхдийн нэр төр, эрхийг хүндэтгэн үздэг харилцаа, ёс зүйг шүүхийн орчинд төлөвшүүлэх, хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн эрхийн талаар мэргэшүүлэх, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан хуульчийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

4.6.3. хүүхдийн асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийг хороонд сар тутам гаргах, мэдээлэх;

4.7. Аймаг, дүүргийн прокурор, сум дундын ахлах прокурор нь хорооны үйл ажиллагаанд дараахь хэлбэрээр оролцоно.

4.7.1. Прокурорын шатанд байгаа хүүхэд оролцсон, хохирсон гэмт хэрэг, хэргийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллээр хороог хангах;

4.7.2. хүүхдийн хэргийг дагнан шийдэх прокурорыг томилон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд оролцсон зөрчил, хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

4.7.3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийн зөрчил гаргуулахгүй байхад анхаарч хяналт тавих, хүүхдийг саатуулах, баривчлах, хорих арга хэмжээг хамгийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг эрмэлзэж ажиллах;

4.7.4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүүхдийг эрүү шүүлт, хүнлэг бус харилцаанаас хамгаалах;

4.8. Цагдаагийн газар/хэлтэс/-ын дарга дараахь үүрэг хүлээнэ.

4.8.1. хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн талаарх мэдээллээр хороог хангах;

4.8.2. хүүхэд оролцсон хэргийг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг хүүхдэд ээлтэй орчинд явуулах, хэргийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.8.3. хүүхдийн эрхийн мэргэшлийн сургалтад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг тогтмол хамруулах, хүүхдийн эрхийг хүндэтгэх, ёс зүйтэй харилцааг албан хаагч нарт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах;

4.8.4. хууль зөрчсөн хүүхдийг дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар хороотой хамтран ажиллах;

4.8.5. насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэшсэн цагдаагийн ажилтныг томилон ажиллуулах;

4.9. Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч дараахь үүрэг хүлээнэ.

4.9.1. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг төлөөлж холбогдох байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргах, хүүхдэд тулгарч буй асуудлаар хороог мэдээллээр хангах;

4.9.2. хүүхдийн хэргийг шуурхай шийдвэрлэхийн тулд өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлэх;

4.9.3. шүүх ажиллагаанд оролцох, хороог мэдээллээр хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргах;

4.10. Боловсрол, соёлын газар/хэлтэс/-ын дарга дараах үүрэг хүлээнэ.

4.10.1. Ерөнхий боловсролын сургуульд сурдаг хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийг хороонд ирүүлэх;

4.10.2. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн хэргийн болон хувийн нууцыг хадгалах, боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамрагдах, ялгаварлан гадуурхагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх;

4.10.3. боловсролын нийгмийн ажилтныг хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхэдтэй ажиллах нөхцөл боломжоор хангах;

4.10.4. сургуулиас гарсан, хасагдсан, завсардсан, бичиг үсэг мэдэхгүй хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд боловсрол олгох ажлыг зохион байгуулах;

4.10.5. багшийн ажлыг дүгнэх, үнэлэх шалгуур үзүүлтэд хууль зөрчсөн хүүхдийг анги хамт олонд нь нэгтгэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх хүчин зүтгэлийг тусгаж, хэрэгжүүлэх;

4.11. Эрүүл мэндийн газар/нэгдэл/-ийн дарга дараахь үүрэг хүлээнэ.

4.11.1. хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах;

4.11.2. эмч, эмнэлгийн ажилтнууд хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, ёс зүйтэй, мэргэжлийн өндөр түвшинд хүргэх ажлыг зохион байгуулах;

4.11.3. хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн эрүүл мэндийн байдлын талаар шаардлагатай мэдээллийг цагдаагийн байгууллагад шуурхай хүргэх.

4.12. Хөдөлмөр, нийгмийн халамжийн газар/хэлтэс/-ын дарга дараахь үүрэг хүлээнэ.

4.12.1. хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах, ажилтай болоход туслах;

4.12.2. хууль зөрчсөн, хохирогч өсвөр насны хүүхдийн эцэг эх, ар гэрийн хүмүүсийг ажил, мэргэжилтэй болоход дэмжлэг үзүүлэх;

4.12.3. сургалт хүмүүжлийн байгууллагаас суллагдсан орон гэргүй өсвөр насны хүүхэд, түүний гэр бүлийг орон байраар хангах, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамруулах;

4.12.4. хүүхэд, гэр бүлд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөл хууль зөрчсөн, гэрч хохирогч хүүхдэд шаардлагатай тохиолдолд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг мэргэжлийн түвшинд шуурхай хүргэх, холбон зуучлах үүрэг хүлээнэ,

Тав. Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд үзүүлэх туслалцаа, үйлчилгээ

5.1. Хороо нь хууль зөрчсөн хүүхдэд дараахь туслалцаа, үйлчилгээг үзүүлнэ.

5.1.1. хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа нэн даруй хууль зөрчсөн хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах;

5.1.2. нөхцөл байдлын үнэлгээ хийх;

5.1.3. өмгөөлөгчөө сонгох боломжгүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй нь тогтоогдвол Монголын хуульчдын холбоо болон бусад холбогдох байгууллагад хандан өмгөөлөгчөө сонгох эсвэл томилуулах, Хууль зүйн туслалцааны төвд хандан улсын өмгөөлөгч авах боломжоор хангах;

5.1.4. нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хууль зөрчсөн хүүхэд, түүний эцэг эх, хамтарсан баг бусад оролцогчтой ажиллах төлөвлөгөө боловсруулах;

5.1.5. хохирогчоос уучлалт гуйх, хохирогчтой эвлэрэх ажиллагааг зохион байгуулах, зөрчил гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан хохирол гэм хорыг хүүхэд, эцэг эх, хууль ёсны төлөөлөгчийн дэмжлэгтэйгээр төлж барагдуулах ажлыг зохион байгуулах;

5.1.6. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэлмэрч, орчуулагч, багш, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож оролцуулах;

5.1.7. хууль зөрчсөн хүүхдийн буруу зан үйлийг засах, хичээлийн хоцрогдлоо арилгах, нийгэмших, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг тухайн хүүхдийн сэтгэл зүй, боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээнд хамруулах;

5.1.8. хууль зөрчсөн хүүхдийн хувийн байдлын талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тодорхойлолт, батлан даалтын саналыг Цагдаа, Прокурор, Шүүх байгууллагад гаргаж өгөх;

5.1.9. хэрэг хянан шийдвэрлэх явцад хууль зөрчсөн хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсэн тухай гомдол саналыг хүлээн авах, гомдлын мөрөөр

хүүхдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдийг томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж, хүүхдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

5.2. Хороо нь гэмт хэргийн хохирогч хүүхдэд дараахь туслалцаа, үйлчилгээг үзүүлнэ.

5.2.1. хохирогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг нэн даруй зохион байгуулна.

5.2.2. сум, хорооны нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хохирогч хүүхэд, түүний эцэг эх, хамтарсан баг, бусад оролцогчтой хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах, нийгэм сэтгэл зүйн, эрүүл мэндийн, хууль эрх зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

5.2.3. хохирогчтой эвлэрэх ажиллагааг зохион байгуулахад хохирогчийг ямар хэлбэрээр, хэзээ, хэрхэн оролцуулах талаар хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч, шаардлагатай гэж үзвэл өмгөөлөгч бусад этгээдүүдийг оролцуулан зөвлөлдөж шийдвэр гаргах;

5.2.4. зөрчил гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан хохирол гэм хорыг хууль зүйн дагуу барагдуулах, чухал шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг урьдчилан гаргуулах ажлыг зохион байгуулах;

5.2.5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулах ажлыг зохион байгуулах;

5.2.6. хохирогч хүүхдээс байцаалт мэдүүлэг авах, хохирогч хүүхдийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллах;

5.2.7. өмгөөлөгч авах хүсэлтэй, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлаар хорооны хуралд санал оруулж шийдвэр гаргуулах;

5.2.8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хохирогч хүүхдэд авах шаардлагатай тохиолдолд хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасан хамгаалалтыг хэрэглэх тухай хохирогч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлт, эсвэл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн саналыг бичгээр гаргуулах ажлыг зохион байгуулах;

5.2.9. хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирогч хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тухай гомдол саналыг хүлээн авах, гомдлын мөрөөр хүүхдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий этгээдийг томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, хүүхдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

5.3. Хороо нь гэмт хэргийн гэрч хүүхдэд дараах туслалцаа, үйлчилгээг үзүүлнэ.

5.3.1. гэрч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа гэрч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах;

5.3.2. сум, хорооны цагдаа болон нийгмийн ажилтан нь гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчтэй уулзаж, хорооноос гэрч хүүхдэд үзүүлж болох үйлчилгээ, зөвлөгөө, туслалцааг танилцуулж, хамтран ажиллах боломжийг санал болгох;

5.3.3. гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч энэ ажиллагаанд ямар эрх, үүрэг, хариуцлагатай оролцох талаар хууль зүйн зөвлөгөөг өгөх;

5.3.4. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг гэрч хүүхэд авах шаардлагатай нөхцөл байдал үүссэн талаар хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч хүсэлт гаргавал хороо холбогдох албан тушаалтанд холбон зуучлах;

5.3.5. гэрч хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, ашиг сонирхол, хувийн халдашгүй байдал зөрчигдсөн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгчийн зүгээс ёс зүйн зөрчил гаргасан, эрх ашгийг хохироосон зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллийн талаар хороонд гомдол гаргасан тохиолдолд хороо хүүхдийн эрх ашгийг хамгаалахаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.3.6. гэрч хүүхдийн эрх, ашиг сонирхол хууль ёсны төлөөлөгчтэй зөрчилдсөн нь тогтоогдсон тохиолдолд хорооноос хүүхдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдийг томилуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах;

5.3.7. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтантай холбоо тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд хүндрэл бэрхшээлгүй шуурхай явуулах ажлыг зохион байгуулах;

5.3.8. гэрч хүүхдээс байцаалт мэдүүлэг авах, гэрч хүүхдийг шүүх хуралд оролцуулах тусгай нөхцөл боломжийг бүрдүүлсэн орчныг бий болгох асуудлаар цагдаа, прокурор, шүүх байгууллагатай хамтран ажиллах;

5.4. Хорооноос үйлчилгээ авч буй хүүхэд бүрийн оршин суух сум хорооны хамтарсан багтай хамтран төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн, үр дүнг тооцно.

5.5. Эцэг эх гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцно.

5.6. Хороо нь хууль, зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхдийн хэрэг, хувийн мэдээлэл, хорооноос үзүүлсэн үйлчилгээг агуулсан хувийн хэргийг хүүхэд бүр дээр нээх, баримтжуулах, хадгалах, үйлчилгээ үзүүлж дууссаны дараа хорооны бүртгэл

мэдээллийн санд шаардлагатай мэдээллийг оруулж, хувийн хэргийг хүүхэд түүний хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгнө.

5.7. Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхдийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээг авах талаар орон нутаг дах төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Зургаа. Хорооны үйл ажиллагааны хяналт

6.1. Хорооны үйл ажиллагаанд хууль зүй, дотоод хэргийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл хяналт тавина.

6.2. Хороо нь энэ журмын 6.1-д дурдсан байгууллагуудад үйл ажиллагааныхаа тайланг хагас жил тутам хүргүүлнэ.

Долоо. Бусад

7.1. Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусгаж, хэрэгжүүлнэ.

7.2. Журам зөрчсөн байгууллага, албан тушаалтанд Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----000-----

